

СТРАТЕГИЙН

THE MONGOLIAN JOURNAL OF STRATEGIC STUDIES

№81 /2021/

СУДАЛГАА

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Дарга

Б.Даваадорж
ССХ-ийн захирал, профессор

Ерөнхий редактор

доктор Ж.Мэндээ
ССХ-ийн Дэд захирал, Эрдэмтэн нарийн
бичгийн дарга

Гишүүд

Доктор З.Болдбаатар
доктор Э.Энхмаа
ССХ-ийн НТСС-ийн эрхлэгч
доктор Б.Отгонсүрэн
ССХ-ийн ОУБНСС-ийн эрхлэгч
Ч.Цэцэгмаа
ССХ-ийн ЭЗСС-ийн эрхлэгч
доктор А.Түвшинтөгс

Нарийн бичгийн дарга

С.Буянхишиг
ССХ-ийн Хэвлэлийн менежер

Редакцын хаяг:

Самбуугийн гудамж 11,
Засгийн газрын-11, 8 давхар
Утас: (976-51)264000
Факс: (976-11)324055

Шуудангийн хаяг:

Монгол Улс, Улаанбаатар
Төв шуудан- 870

Захиалгын индекс:

200952

EDITOR'S BOARD

Editor in Chief

B.Davaadorj Prof.
Director, ISS

Executive Editor

J.Mendee Dr.
Deputy Director and Dean, ISS

Members

Z.Boldbaatar Dr.
E.Enkhmaa Dr. Head of Department for
Domestic Policy Studies, ISS
B.Otgonsuren Dr. Head of Department for
International and Regional Studies, ISS
Ch.Tsetsegmaa
Head of Department for Economic Studies, ISS
A.Tuvshintugs Dr.

Secretary

Seseer Buyankhishig
Manager of Publications, ISS

Board Address:

8th floor, Government Building-11,
Sambuu Str. 11
Tel: (976-51)264000
Fax: (976-11)324055

Postal Address:

Central Post Office 870
Ulaanbaatar

Subscription index:

200952

Цахим хуудас: www.iss.gov.mn

Зохиогчийн эрх: @ Стратеги судалгааны хүрээлэн, 2021

Сэтгүүлд нийтэлсэн материалын агуулга, мэдээллийн үнэн зөвийг зохиогчид хариуцна.

Дугаар эрхэлсэн Б.Отгонсүрэн

ӨМНӨХ ҮГ



**СТРАТЕГИ СУДАЛГААНЫ
ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ, БРИГАДЫН
ГЕНЕРАЛ, ПРОФЕССОР
Б.ДАВААДОРЖ**

Эрхэм уншигч Таны гэгээн оюуны мэлмийд “Стратегийн судалгаа” сэтгүүлийн 81 дэх дугаараа толилуулж буйдаа таатай байна.

Үндэсний аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагаа, улс орны хөгжлийн стратеги, шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад бодитой дэмжлэг үзүүлэх, Монгол Улсад стратегийн судалгааг хөгжүүлэх эрхэм зорилттой ҮАБЗ-ийн Стратеги судалгааны хүрээлэн байгуулагдсан цагаасаа хойш “Стратегийн судалгаа” сэтгүүлийг улирал тутам тогтмол хэвлүүлж уншигч олны хүртээл болгож ирсэн сайхан уламжлалтай билээ.

Сүүлийн жилүүдэд цар тахлын улмаас сэтгүүлийн дугаар тогтсон хугацаандаа уншигч Та бүхэнд хүрч чадаагүйд түмэнтээ хүлцэл өчье. Хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид цар тахлын эрсдэлийг сөрж, түүний аюултай зэрэгцэн ажиллаж, сэтгүүлийн энэ удаагийн дугаараас эхэлж улирал тутамд тогтмол хэвлэж, олны хүртээл болгохоор зорьж байгаадаа туйлын баяртай байна.

Эдүгээ Монгол Улсын гадаад орчин хувьсан өөрчлөгдөж, их гүрнүүдийн геостратегийн сэргөлдөөн ширүүсч, даяаршлын эрин үе төгсгөл болох, дэлхийн дэг журам өөрчлөгдөх үйл явц ид өрнөж буй энэ цаг дор судлаачид биднээс нөр их хөдөлмөр, хүчин чармайлт, ур ухаан, мэдлэг чадвараа шавхаж ажиллах, үйл явдлын өрнөл, хэтийн төлөвийг бодитой тодорхойлсон дорвитой суурь судалгаа хийхийг цаг үе шаардаж байна. Мөн

хувьсан өөрчлөгдөж буй гадаад орчин, түүний нөлөөллийг Монгол Улсын аюулгүй байдалтай холбож, олон талаас нухацтай судлах явдал манай судлаачдын эрхэм үүрэг, бас хариуцлага юм.

Энэ удаагийн дугаарт аюулгүй байдлын асуудлаарх манай судлаачдын бичсэн судалгааны өгүүллийг нийтэлж буйн дээр зохиогчийн эрхийг хүндэтгэж, тэдний дэвшүүлсэн үзэл бодол, дүгнэлтийг хөндөхгүйгээр эрхэм уншигч Танд хүргэж байна.

Аливаа судалгааны бүтээл гэдэг өөрийн зохих үнэлэмж, зориулалттай бас тодорхой хэрэгцээ, шаардлагыг хангасан “оюуны бүтээгдэхүүн” байх учиртай. Тиймээс судлаачдын судалгааны үр дүн, үнэ цэнийг эрхэм уншигч авхай Та бүхэн оюун ухаандаа тунгаан шүүж, дэнслэнэ биз ээ.

Энэхүү сэтгүүлд нийтэлсэн судалгааны өгүүллэгүүдтэй холбоотой шүүмж, санал болон бидний цаашдын судалгаанд тустай санаа бодлыг www.iss.gov.mn цахим хаягаар хүлээн авч та бүхэнтэй эргэх холбоотой хамтран ажиллахыг бид зорьж байна.

Стратегийн болон аюулгүй байдлын асуудлаар эрдэмтэн судлаачдын үзэл бодол, оюуны талбар болсон манай сэтгүүлд өөрийн бүтээлийг нийтлэх хүсэлтэй иргэн бүрт манай сэтгүүлийн үүд хаалга ямагт нээлттэй байх болно.

АГУУЛГА

CONTENT

Д.Уламбаяр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын шинэ парадигм	5	D. Ulambayar Prof “The new paradigms of the Mongolia’s national security and foreign policy”
Л.Эрдэнэчулуун Бид НҮБ-гүйгээр амьдарч чадах уу?	26	L.Erdenechuluun “Can we survive without the United Nations?”
Н.Соёлгэрэл Афганистаны 20 жилийн дайн дууссан нь буюу бүс нутагт аюулгүй байдлын хаос үүсэх үү	32	N.Soyolgerel “Twenty Years’ War in Afghanistan is over, Will there be Security Chaos in the Region?”
П.Батжаргал Төв Азийн аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудал	45	P.Batjargal “Some security issues in Central Asia”
Г.Мэндсайхан Их гүрнүүдийн Ойрх Дорнод дахь бодлого, стратеги	54	G.Mendsaikhan “Geopolitical situation in the Far East”
Б.Батмөнх Эдийн засгийн аюулгүй байдал ба хөгжлийн асуудал	63	D.Batmunkh “The economic security”
Б.Отгонсүрэн БНХАУ-ын байгалийн хийн хоолойн стратеги бүс нутагт	75	B. Otgonsuren Ph.D “PRC’s natural gas pipelines policy towards sub region”
С.Чандмань, Г.Өнөржаргал Хөрш орнуудтай харилцах эдийн засгийн тэнцвэргүй харилцаа	84	S.Chandmani, G.Unurjargal “The Mongolia’s economic relations with its two neighbours”
Е. И. Лиштованный Орчин үеийн Орос-Монголын харилцаа	94	E.I.Lishtovannii “Modern relations between Russia and Mongolia”
Фань Сяожү Геополитикийн тушааг даван туулж, хамтдаа хөгжих арга замыг эрэлхийлэх нь: ЗХА-ийн нөхцөл байдал ба Монгол Хятадын харилцааг эргэцүүлэхүй	99	Fan Xiaoju “Finding the path forward on collaborat- ing on overcoming geopolitical challenges: The current situation in Northeast Asian sub region and the relations between Mongolia and China”



Д.УЛАМБАЯР (Ph.D, Prof)
ХИС-ийн Олон улсын
харилцаа, нийгэм судлалын
сургуулийн захирал

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД БОДЛОГЫН ШИНЭ ПАРАДИГМ

Abstracts: *This article talks about a new trend of national security issues and geopolitical parameters, also impacts of conservative and hybrid factors affecting in international relations, Mongolia's new geopolitical environment, the new paradigms in Mongolia's foreign policy & its principles, geopolitical space, time, foreign policy curves, and the nature & phenomenon of multi-dimensional diplomacy and a new navigating for a regional geopolitics and the new geostrategic assessment in landlocked Mongolia.*

The external and internal geopolitical environment of Mongolia Post-Cold War can be divided into three decades: the last decade of the Twentieth Century, the first and second decades of the New Millennium. It is clear that these geopolitical spatial, temporal, and gravitational have their own unique characteristics.

We need to conduct analysis and risk assessment in international relations and geopolitical processes at the intersection of natural and social sciences.

It can be concluded that Mongolia located is at the core center of gravity in the process of formation a New Multi-Polar World Order.

Finding the balancing interests and power of balance between the relations with two neighbors, tripartite cooperation, and "third neighbor" diplomacy are new issues in Mongolia's foreign policy and security. In other words, Mongolia's «third neighbor» policy in the 1990s is different from the «third neighbor» policy in the second decade of the New Millennium.

The geopolitical determination of Mongolia, which is landlocked, far from the world market, sandwiched between two great powers, and a development aid seeker, underdeveloped and small, is outdated.

Keywords: *national security, foreign policy, paradigms, hybrid, geopolitical space & time, gravity, geostrategic assessment, New Multi-Polar World Order, New Millennium, “third neighbor” diplomacy, balance of interests, power of balance, etc.,*

Нэг. Аюулгүй байдал, геополитикийн шинэ параметр

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.1-д: «Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ»¹ гэжээ. Даяаршил, дижиталчлалын үе шатанд дээрх нь харьцангуй ойлголт болно. Харин үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх үйл явц мөн бөгөөд үүн лүгээ үндэсний аюулгүй байдлын судалгаа, дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай. Аюулгүй байдлын онол, үзэл баримтлал, аргазүйд томоохон өөрчлөлт гарч, аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа бол аюулгүй байдалд нөлөөлж буй аюулын чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, төр, хувийн хэвшлийн түншлэл, хувь хүний хүчин зүйл чухал болов. Энэ нь аюулгүй байдалд заналхийлж буй аюулын хэлбэрийн агуулга, шинж чанарын өөрчлөлт, шинэ чиглэл рүү шилжиж буй зэрэг үйл явцыг ойлгож, заналхийлж буй хэлбэрүүдийг олж тогтоох явдал ажгуу. Түүнчлэн аюулгүйжүүлэх (securitization) хэмээх шинэ ойлголт, *hybrid* аюул гарч ирэв. COVID-19 цар тахал бол *hybrid threat* мөн.

Геополитикийн шинэ параметр (өгөгдөл) гэдэг нь бүс нутгийн болон глобал орон зайд их гүрнүүдийн геополитикт уламжлалт бус чиг хандлага хүч түрэн гарч ирсэн хийгээд хүчний шинэ шилжилт хөдөлгөөн эрчимжиж, дахин хуваарилалт явагдаж, геостратегийн шинэ үнэлгээтэй улс орнуудын оролцоо, тэдний чадамж, тэдгээрийн гадаад бодлогын шинэ навигацийг хэлж болохоор байна.

Геополитик бол газарзүй, орон зайн байршил, хүч чадавхад суурилсан гадаад улс төрийн бодлого даруй мөн бөгөөд түүнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь олон улсын харилцааны орчин, орон зай, цаг хугацаа, таталцлын хүч, харин дотоод хүчин зүйл нь эдийн засгийн байдал, тогтолцоо, засаглалын систем, түүний чанар, ардчиллын төлөвшил юм. Наполеон Баноарт хэлэхдээ: “*Аливаа улсын гадаад бодлого нь түүний оршин буй газарзүйн байршилаар тодорхойлогдоно*”² гэжээ.

Эдүгээ үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа ч багасч, даяаршил, дижитал үйл явц хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйл болж байна. Дурдсан үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг хүчин зүйл болов.

Их гүрнүүд гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн хоёр зарчмыг баримталж байна.

Геополитикийн орон зай, цаг хугацаа бол улс орнууд нийгэм-улс төрийн хувьд зөрчилтэй, олон янз боловч харилцан шүтэлцээтэй, бие биеэсээ улам их шалтгаалцаж,

¹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ:, 2010

² To know a nation's geography is to know its foreign policy” – Napoleon Bonaparte (Emperor of France from 1804 to 1814) Luis Ritto. Diplomacy and Its Practice. VII. International Relations, Geopolitics and Diplomacy. 2015

бие биедээ зайлшгүй шаардлагатай болж, олон талаараа бүхэл бүтэн дэлхий ертөнцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ бүс нутагт хоршин хөгжих, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх, хамтын аюулгүй байдлын байнгын тогтолцоог бүрдүүлэхийн зайлшгүй нь дэлхий хэмээх гараг улам бүр жижгэрч, улс орнууд бие биетэйгээ харилцан хамааралтай болж, ямар ч хүчирхэг эдийн засаг, батлан хамгаалах чадавхтай улс, гүрэн ч өөрийнхөө хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдлаа дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болсон гэдэгт үндэслэж байна.

Эдүгээ:

- Олон улсын хамтын ажиллагааны хамгийн чухал зүйл нь олон улсын эрхзүйн зарчим, хэм хэмжээний хүрээнд дэлхийн улс орнуудын тогтвортой байдлыг сахин хангах;
- Олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг урт удаан хугацаанд тогтвортой хадгалах явдал тулгамдсан асуудал болсоор байна.
- Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дүрмээр тоглодог олон улсын дэг журмыг хадгалах, их гүрнүүд болон хөрш орнуудын хооронд тогтвортой түншлэлийн тэнцвэртэй харилцааг цогцлоох;
- Олон улсын харилцаанд түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлж, дэлхийн хэмжээний даяар, нийт хүн төрөлхтөнд нийтлэг нүүрлэж буй аюул, сорилт, өөрчлөлтүүдийг шийдвэрлэх, даван туулахад оролцоогоо илүү идэвхжүүлэх явдал чухал болсоор байна.

Монгол Улсын хувьд хүчний тэнцвэр (balance of power) барих бус, харин тэнцвэрийн хүчийг (power of balance) олохоос гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болсоор байна. Бие биенийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх тухайд Монголын сүсэгтэн олон хийгээд Дээрхийн гэгээнтэн XIV Далай ламын хоорондын харилцааны асуудал ч хамаарагдана.

Украины сургамж бол Өрнөд-ОХУ-ын хооронд ашиг сонирхлын тэнцвэрийг зөв барьж чадаагүйд оршино. Энэ бол бидэнд хамаатай чухал сургамж.

Эдүгээ олон улсын харилцаа, глобал эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн хүчин зүйлс нь:

- COVID-19 цар тахлын хүчин зүйлс;
- Геополитикийн хүчин зүйлс;
- Глобалчлалын хүчин зүйлс;
- Дижиталчлалын хүчин зүйлс;
- Соёл иргэншлийн хүчин зүйлс;
- Дэлхийн дулаарал, цаг уурын хүчин зүйлс;
- Дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй нийтлэг асуудал эдгээр болно.

COVID-19 цар тахлын хувьд дэлхийн бүх улс орон аюулгүй болтол аль ч улс орон дангаараа аюулгүй байх боломжгүй болов.

Неолибераль үзлийн нэр хүнд унаж, үүнтэй уялдан зүүн төвийн үзэл газар авч, хайпер глобалчлалын эсрэг үндсэрхэх үзэл, популизм ч эрчимжиж байгааг бид харж байна.

Сансрын уудам, нарны аймаг эрдэм шинжилгээ, туршилт судалгааны судлагдахуун байгаад зогсохгүй, харин бизнесийн асар том орон зай болон хувирч байна.

Аюулгүй байдлын талаарх бидний уламжлалт ойлголт дижитал технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан үзэгдэл, мөн чанар, хамрах цар хүрээний хувьд улам бүр өргөжин тэлсээр олон улсын харилцааны хүрээнээс халин гарч, дэлхийн гаднах сансрын уудмын орон зайг хамарч байна. *Дэлхийн цор ганц дагуул сар, цаашилаад ангараг гаригт их гүрнүүдийн тугаа намируулж, эзэмших геополитикийн шинэ өрсөлдөөн нэгэнт эхэлжээ.* Сансрын цэргийн хүчнийг ОХУ, БНХАУ 2015 онд, Энэтхэг 2018 онд АНУ, Франц 2019 онд тус тус байгуулав.

АНУ, ОХУ эдийн засгийн хориг арга хэмжээ, сонгуульд хөндлөнгөөс оролцсон, цахим халдлага, хүний эрх болон геополитикийн асуудлаар санал зөрөлдөөнтэй байгаа хэдий ч сансрын хамтын ажиллагааны гэрээгээ 2030 оны 12 дугаар сар хүртэл сунгахаар тохиролцсон нь чухал ач холбогдолтой.³

Нөгөө талд сансар судлалын салбарт Space-X тэргүүтэй хувийн хэвшлийн үндэстэн дамнасан корпорациуд хүч түрэн орж ирэв.

Өрнөдийн эдийн засгийн хориг арга хэмжээ гүнзгийрэхийн хэрээр ОХУ, БНХАУ-ын улс төр-аюулгүй байдал, худалдаа-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа эрчимжсэн нь Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн ач холбогдлыг өсгөж байгааг тууштай ашиглах шаардлагатай байна. Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэлийн (*comprehensive strategic interaction partnership*) түвшинд хүрч, түүнчлэн БНХАУ-ын удирдлага Хятад-Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэж мэдэгдсэн.⁴ Иймд өнөө болон ойрх ирээдүйн Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн хамгийн ойр орчинд таатай нөхцөл бүрдээд байгааг үгүйсгэж үл болно.

Гэхдээ Орос, Хятадын зүгээс цэргийн эвсэл байгуулах үзэл санаа гарсаар байгааг анхаарах ёстой. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2020 оны 10 дугаар сарын 22-нд олон улсын аюулгүй байдлын асуудлаарх мэтгэлцээний “Валдай” клубын XVII хуралдаанд оролцож үг хэлэх үеэр Хятадын төлөөлөгчийн цахимаар асуусан асуултад хариулахдаа: “...бид цэргийн эвсэл байгуулах зорилт тавиагүй боловч зарчмын хувьд бид үүнийг үгүйсгэхгүй. Ямартаа ч юу болохыг бүгдээрээ харцгаая”⁵ гэж хэлсэн байна.

Харин ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров Энэтхэгийн Гадаад хэргийн сайд Субраманиям Джайшанкартай хэлэлцээ хийсний дараа хэвлэлийн бага хурлын үеэр сурвалжлагчийн асуултанд хариулахдаа: “Орос, Хятадын харилцан итгэлцэл өндөр дээд түвшинд хүрсэн. Тэглээ гээд цэргийн эвсэл байгуулахгүй. Орос, Хятадын харилцаа бүх цаг үеийнхээ хамгийн оргил түвшинд хүрсэн. Гэхдээ энэ харилцаа нь цэргийн эвсэл

³ Russia backs extending space cooperation deal with U.S. to 2030 – agencies. By Reuters Staff, April 3, 2021 <https://www.reuters.com/article/us-russia-usa-space-idUSKBN2>

⁴ Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С.Горбачева в Китайскую Народную Республику 15-18 мая 1989 года Документы и материалы. М., Изд. Политической Литературы. 1989, стр. 18

⁵ Выступление В.Путина на заседании клуба “Валдай”. Полный текст 23 Октября, 2020 <https://tass.ru/politika/9789887>

байгуулах зорилго тавиагүй”⁶ гэж мэдэгдсэн юм. Хоёр хөрш хоёул АНУ-тай сөргөлдөж буйн хувьд батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа улам эрчимжиж байгааг бид харж байна.

Социализм нуран унаснаас хойш АНУ дэлхий дээр жолоодогчийн үүрэг гүйцэтгэх тухай үзэл санаа бодлогын шинж чанартай болж байгаад ОХУ, лалын ертөнц ихээхэн эгдүүцэж, дээрхийг Хятад зэрэг гүрэн ганцаараа жанжлах гэсэн эрмэлзлэл гэж ч шүүмжилж эхэлсэн. Хүйтэн дайнд ялалт байгуулсандаа эрэмшсэн АНУ, түүний холбоотнууд дэлхий дахинд хүний эрх, эрх чөлөө, ардчиллыг сэргээн баталгаажуулах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцааг түгээн дэлгэрүүлэх тухай зааж сургаж байв.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин бүр 2014 оны 10 дугаар сард “Дэлхийн дэг тогтолцоо: Шинэ зүй зохицол уу, эсвэл дүрэмгүй тоглоом уу?” сэдвийн дор зохиогдсон “Валдай” олон улсын мэтгэлцээний клубын төгсгөлийн хуралдаанд оролцож үг хэлэхдээ: АНУ-ыг хүйтэн дайны дараа дэлхий дахинд тогтсон дэг журмыг эвдсэнд буруутгаж, дэлхий ертөнцийг эмхлэн тохинуулах шинэ тогтолцоог буй болгохгүй бол бүхэлдээ анархи, эмх замбараагүй байдалд орж болзошгүйг сануулж, Орос, АНУ хоёр болсон үйл явдлыг хамтран дүгнэж, томоохон эдийн засагтай бусад оронтой хамтран олон туйлт ертөнцийн үзэл баримтлалын дагуу дэлхийг удирдах нэгдсэн шинэ дэг тогтолцоог цоглоон бүтээхийг уриалсан юм. Орос-Америкийн харилцаа нь стратегийн тогтвортой байдал, олон улсын аюулгүй байдлын чухал хүчин зүйл хэвээр байна гэж тэрбээр үзэж байсан билээ.⁷


ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхжсэн нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын дэг журам, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхэлсэн хэмээн судлаачид үзсээр байгаа юм. Дээрхтэй холбоотойгоор хүчний шилжилт хөдөлгөөн эрчимжиж, дахин хуваарилалт явагдаж байна. Тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэж байна. Тэгвэл дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлыг дэлхийн III дайнтай зүйрлэх болжээ.

Хүйтэн дайн дууссанаар Монголын геополитикийн орчин, орон зай үндсээрээ өөрчлөгдөж, далайд гарцгүй (*land-locked*), цөмийн зэвсгээр хүрээлэгдсэн (*nuclear-locked*), хоёр их гүрний дунд хашигдсан (*power-locked*), мөн монгол угсаатнаар хүрээлэгдсэн (*mongols ethno-locked*) онцлог бүрхүүлтэй цоо шинэ нөхцөл байдал буй болов. Геополитикийн шинэ орчинд Монгол Улс үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, бие даасан, нээлттэй, эвсэлд үл нэгдэх, прагматик гадаад бодлого явуулсан нь XX зууны сүүлчийн улиралд Монгол Улсын гадаад харилцаанд гарсан хамгийн том ололт мөн.

⁶ Сергей Лавров заявил что Россия и Китай не преследуют цели создать военный союз
ТАСС 06 Апрель, 2020 <https://tass.ru/politika/11077113>

⁷ В.Путин принял участие в итоговой пленарной сессии XI заседания Международного дискуссионного клуба «Валдай». Тема заседания-«Мировой порядок: новые правила или игра без правил?». 24 октября 2014 года. Сочи.

Схем 1. Монгол Улсын геополитикийн шинэ орон зайн байршил



Хоёр. Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм

Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь нэгд, Монгол Улсад хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгэм байгуулах гадаад таатай нөхцөлийг хангах; хоёрт, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг бүс нутаг болон олон улсын хэмжээнд баталгаажуулах; гуравт, Үндэсний хөгжил дэвшлийг урагшлуулахад гадаад харилцааны нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглах, үр өгөөжийг тууштай нэмэгдүүлэх; дөрөвт, Монгол Улсын олон улсын нэр хүнд, байр суурийг хэлбэрэлтгүй бэхжүүлж, хүн төрөлхтний хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах; тавд, Гадаад дахь монгол иргэд, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах; зургаад, Дэлхий нийтийн өмнө нийтлэг тулгамдаж буй аюул сорилтыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх эдгээр болно.

Монгол Улсын гадаад бодлогын зарчим нь үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, эвсэлд үл нэгдсэн, бие даасан, ардчилсан үнэт зүйлийг дээдэлсэн, прагматик байх эдгээр болно. Тэргүүлэх чиглэл нь хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харьцах, “гуравдагч хөрш”-ийн бодлого, гурвалсан хөршийн хамтын ажиллагаа, цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын эрхзүйгээр баталгаажуулах, II сувгийн дипломаси, цэргийн дипломаси буюу энхийг сахиулах ажиллагаа эдгээр болно. Дээрх зорилго, зарчим, тэргүүлэх чиглэл нь өөр хоорондоо шүтэн барилдлагатай цогц үйл юм.

Схем 2. Монгол Улсын гадаад бодлогын зарчим, хэв шинж



Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хөндөөгүй хөрш болон “гуравдагч хөрш” гүрнүүдийн хоорондын геополитикийн сөргөлдөөнд оролцохгүй. Монгол Улс үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар л хангана. Түүнчлэн үндэсний аюулгүй байдлаа эдийн засгийн аргаар хангах асуудлыг чухалчлан авч үзэх ёстой болов уу.

Төвч байр суурь (centrism) бол төвийг сахих байр суурьтай огт ижилгүй. Энэ бол баруун, зүүн тийш хальтирч хэлбийхгүй smart буюу ухаалаг байх байр суурь юм. UB Dialogue бол 2-1.5 дугаар сувгийн дипломат ажиллагааны тод жишээ болно.


Гурав. Геополитикийн оронзай, цаг хугацаа, таталцлын хүч, гадаад бодлогын муруйлт, дипломатын олон хэмжээс

Хүйтэн дайн дууссаны дараах Монголын геополитикийн гадаад, дотоод орчныг XX зууны сүүлийн арван жил, Шинэ мянганы эхний арван жил, хоёр дахь арван жил гэж гурав хувааж болохоор байдаг. Эдгээрийн орон зай, цаг хугацаа, таталцлын хүч өөр өөрийн өвөрмөц онцлог ялгаатай байсан хийгээд байгаа нь тодорхой байна.

Бид байгаль, нийгмийн шинжлэх ухааны солбилцол дээр олон улсын харилцаа, геополитикийн үйл явцад судалгаа, дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийж байх шаардлагатай.

Олон улсын харилцаа бол физикийн entropy төлөв байдал буюу эмх замбараагүй анархи төлөв байдал юм. Олон улсын харилцааны аливаа юмс үзэгдэл, үйл явдал геополитикийн оронзай, цаг хугацааны гадна оршин байна гэсэн ойлголт байхгүй.

**Зураг 1. Хоёр туйлт системийн үеийн гадаад бодлогын муруйлт
(Gravity and Curvature of Space/Time-Bipolarity)**



Дээрх зурагт олон улсын харилцаа, геополитикийн орон зай, цаг хугацааны орчинд шийдвэрлэх нөлөө үзүүлж байсан ЗСБНХУ-ын жин нөлөө, таталцлын хүчний үйлчлэлийн дүнд БНМАУ-ын гадаад бодлого, дипломат ажиллагааны муруйлтыг харуулж байна. Энэ үеийг олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоо үйлчилж байсан хүйтэн дайны үе хэмээн тодорхойлдог.

**Зураг 2. Нэг туйлт системийн үеийн гадаад бодлогын муруйлт
(Gravity and Curvature of Space/Time-Unipolarity or Pax Americana)**



Дээрх зурагт хүйтэн дайн дуусч, олон улсын харилцаа, геополитикийн орон зай, цаг хугацааны орчинд шийдвэрлэх нөлөө үзүүлж нэг туйлт дэлхийн шинэ дэг журмыг тодорхойлж байсан 1990-ээд оны АНУ-ын жин нөлөө, таталцлын хүчний үйлчлэлийн дүнд Монгол Улсын гадаад бодлого, дипломат ажиллагааны муруйлтыг харуулж байна.

Орон зайн муруйлт нь А.Эйнштейнээс хоёр зуун жилийн өмнө нээгдсэн Исаак Ньютоны ертөнц дахины таталцлын хуулийн тайлал болсон билээ. Өөрөөр хэлбэл, Исаак Ньютон таталцал буюу хүндийн хүчний үйлчлэлийг тайлбарласан боловч түүний мөн чанарыг тодорхойлж чадаагүй.

Харин Альберт Эйнштейн 2016 онд харьцангуй ерөнхий онолоороо $E=mc^2$ тэгшитгэлээрээ энерги нь массыг гэрлийн хурдны квадратаар үржүүлсэнтэй тэнцэхийг харуулсан юм.

А.Эйнштейн массаас (цул) шалтгаалан орон зай, цаг хугацааны муруйлт буюу гажуудлаас таталцлын хүч үүсдэг гэсэн харьцангуйн ерөнхий онолыг нээжээ. XX зууны эхэн хүртэл орон зайн муруйлтыг түүнд үйлчлэгч хүчтэй нь холбосон физикийн онол нээгдээгүй байсан билээ. 1916 онд нээсэн түүний харьцангуйн ерөнхий онолоор орон зай, цаг хугацаанд хүндийн хүчний нөлөөллөөр таталцлын хүч хэрхэн буй болж, масс ихтэй биетийн ойролцоо оронзай, цаг хугацааны хэмжээсүүд хэрхэн муруйдгийг харуулсан. Энэ муруйлт нь таталцлын хүч буюу хүндийн хүчний тайлал бөгөөд одод, галактикуудын таталцлын хүчний нөлөөгөөр орчлон ертөнц агшиж, сунадаг. Масс их байх тусам муруйлт их, мөн татах хүч их байх болно гэж А.Эйнштейн үзсэн юм.

А.Эйнштейний томьёолол ёсоор масс ихтэй газар орон зай, цаг хугацаатайгаа хамт муруйдаг буюу гажууддаг болохыг баталж чадсан явдал болно. Альберт Эйнштейн хар нүх хэмээх маш хүчтэй таталцлын нууцлаг орон зайн орчин байж болохыг үгүйсгээгүй бөгөөд тэнд супер татах хүч үйлчлэх тул түүнээс гэрэл ч зугтааж чадахгүй, түүнийг юу ч эсэргүүцэж чадахгүй, тиймээс орон зай, цаг хугацааг ч чангааж, гажуудуулдаг гэж үзсэн юм. Тэгэхээр цаг хугацаа орон зайг татаж, сунгаж болно гэсэн үг аж. Цаг хугацааны урсгалын хурд физикийн тодорхой нөхцөлөөс хамаарч орон зайн янз бүрийн мужид өөр өөр байдаг гэж хэлж болно. Үүнийг харьцангуйн ерөнхий онол гэдэг бөлгөө.

Тэгвэл гадаад бодлого, дипломат ажиллагаа ч тодорхой геополитикийн орон зай, цаг хугацааны мөчлөг дотор хүндийн хүчний (mass) нөлөөгөөр муруйж, олон хэмжээстэй байж болох юм. Учир нь геополитик бол улс гүрний чухамхүү тэрхүү амьдрах оронзай, цаг хугацаа, таталцлын хүчийг хамруулсан улс төрийн шинжлэх ухааны ухагдахуун даруй мөн билээ.

Дэлхийн дэг тогтолцоог тодорхойлж буй олон улсын харилцааны мөн чанар, үзэгдэл, үйл явцад жин нөлөө ихтэй (mass) их гүрнүүдийн гадаад бодлогын таталцлын орчинд геополитикийн оронзай-цаг хугацаа, гадаад бодлого хамтдаа муруйдаг байна. Өөрөөр хэлбэл, масс ихтэй таталцлын орчин, оронзай, цаг хугацаанд гадаад бодлого ч муруйлтыг харуулна. Тийм учраас л эрх ашгийн тэнцвэр барих үндсэн дээр тэнцвэрийн хүчийг олох гэдэг чухал асуудлыг хөндөн тавьж байгаа юм. Харилцан хамааралтай, даяаршсан, мөн дижиталчлалын орчинд жижиг улсын гадаад бодлого илүү прагматик байх ёстой. «Олон хэмжээст дипломаси» (multi-dimensional diplomacy) бол прагматик гадаад бодлогын нэг чухал хэв шинж буюу парадигм гэж хэлж болохоор байгаа юм. Тиймээс өнөөгийн эмх замраагүй, анархи (өөрөөр хэлбэл үүнийг илбэн тохинуулснаар шинэ тогтолцоо төлөвших учиртай) дэлхий ертөнцөд жижиг улс үндэсний эрх ашиг, аюулгүй байдлаа сахин хангах чиглэлд олон тулгуурт гадаад бодлогын зарчмын хүрээнд олон хэмжээст дипломаси явуулах шаардлага тулгарч байгаа юм.

Олон хэмжээст дипломаси бол олон улсын эрх зүйн үүднээс императив (jus cogens буюу imperativus) буюу хатуу бус өөрөөр хэлбэл хуульчлагдсан бус, аль нэг үзэл суртал, онолд ягштал баригдахгүй, мөн байнга төвийг сахин сууж зожигрохгүй, олон улсын харилцаа, геополитикийн орчны оронзай, цаг хугацааны өөрчлөлтөд хариу барих, дасан зохицох, хөрвөх чадвартай, цохилт даах, хүнд нөхцөл байдлаас нэр төртэй гарах, геополитикийн **цаг хугацаа-орон зайн талбарт харьцангуй онол лугаа агшиж, сунах чадвартай байх явдал юм. Үүнийг л өөрөөр хэлбэл олон хэмжээст буюу multi-dimensional diplomacy гэх агаад** илүү диспозитив (dispositive) буюу уян хатан, идэвхтэй, maneuver хийх чадвар сайтай, сюрприз багатай, тогтвортой, нэгдмэл, залгамж шинжтэй, олон улсын тавцан дээр идэвхтэй тоглогч байх ёстой. Идэвхтэй гадаад бодлого бол өөрөө батлах хамгаалах хүч болдог.

Даяаршил, дижиталчлалын үед хамгийн хүчирхэг батлан хамгаалах чадавхтай, хамгийн хүчирхэг эдийн засагтай улс гүрэн ч өөрийн аюулгүй байдал, хөгжил дэвшлийг дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болов. Нэг туйлт дэлхийн шинэ дэг журам буюу Pax America-н төгсөл 2001 оны есдүгээр сарын 11-ний үйл явдлаар эхэлж, 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрлаар дуусчээ.

Үүний нөгөө талд Хятадын эдийн засгийн засгийн эрчимтэй хөгжил, ОХУ-ын эдийн засгийн сэргэлт, тэдний иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үе шатыг жинхэнэ ёсоор эхлүүлэв.

ОХУ, БНХАУ-ын оройлолтой олон туйлт дэлхийн шинэ дэг тогтолцоо төлөвших үйл явцад эгнээ нь өргөжиж буй ШХАБ болон ЕАЭЗХ, БРИКС⁸, АДБХОБ, Торгоны их замын дагуух «Бүс ба зам» мега ложистикийн санаачилга чухал үүрэг гүйцэтгэж байна.

Чухамхүү Монгол Улс жин нөлөө нь нэмэгдэж буй олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцын татах хүчний яг төвд нь оршиж байна гэж дүгнэж болохоор байна.

⁸ Судлаачид Бразил, ӨАБНУ-ын эдийн засгийн хүндрэлтэй байдлаас БРИКС-ийн үүрэг бүдгэрч байна гэж үзэх болсон. ӨАБНУ “Bloomberg” агентлаг 2019 оны дөрөвдүгээр сард эдийн засаг нь хамгийн хүнд байдалтай байгаа орнуудын жагсаалтыг гаргахад Венесуэл, Аргентины дараа гуравдугаарт жагссан байна. 2016 онд Хятадын Сямэн хотноо зохиогдсон БРИКС-ийн дээд уулзалт үүнийг үгүйсгэхийг хичээсэн.

Зураг 3. ШХАБ, ЕАЭЗХ, БРИКС, “нэг бүс, нэг зам” санаачилга, АДБХОБ-ны дунд оршин буй Монгол Улс



Дээрх зурагт олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үе шатны бүтцийн институцийн татах хүчний дунд оршиж буй Монгол Улсыг харуулж байна.

Тиймээс хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах, гурвалсан хөршийн хамтын ажиллагаа, «гуравдагч хөрш»-ийн бодлогын дунд эрх ашгийн тэнцвэр барьж, тэнцвэрийн хүчийг олохуй нь Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалд гарч буй шинэ асуудал болно. Өөрөөр хэлбэл, 1990-ээд оны Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого, шинэ Мянганы хоёр дахь арван жилийн «гуравдагч хөрш»-ийн бодлого хоорондоо ялгаатай байна.

Зураг 4. Монгол Улс ба түүний “гуравдагч хөрш”-үүд



Олон тулгуурт (multi-pillar) гадаад бодлогын хүрээнд Монгол Улсын дипломат ажиллагаа олон хэмжээстэй байж, зөвхөн хоёр их хөрш төдийгүй, дэлхийн нөлөө бүхий ардчилсан, хөгжингүй их гүрнүүд, холбоод, Ази-Номхон далайн бүсийн хөгжингүй орнуудтай харилцаагаа түлхүү хөгжүүлж, НҮБ, түүний системийн болон төрөлжсөн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн бэхжүүлэх учиртай. Энэ нь Монгол Улсын геополитикийн онцлог орчин, оронзай, цаг хугацаа, масс, таталцлын хүчтэй шууд холбоотой юм.

Тиймээс олон талт хамтын ажиллагааны шинэ формат болох ЕХ-той түншлэл, хамтын ажиллагааны шинэ түншлэл тогтоож, АСЕАН-ын Найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд нэгдэн, АРФ, Азийн яриа хэлэлцээ (ACD), Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал (CICA), АПЕК, ПЕКК, Монгол, АНУ, Японы гурван талт уулзалтын форматыг эхлүүлж, FEALAC буюу Forum for East Asia-Latin America Cooperation, АСЕМ-11, ЕАБХАБ-ын (OSCE) 57 дахь гишүүнээр элсч, Европын Чөлөөт худалдааны нийгэмлэг (ЕЧХН- European Free Trade Association EFTA), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага буюу OECD-тэй түншлэлийн харилцаа тогтоож, ШХАБ дахь ажиглагч статус, ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны хэлэлцээ эхлүүлж, АСЕАН+3 форматад орж ажиллах санаачилга, зөөлөн хүчний бодлого, II сувгийн дипломат ажиллагааны хүрээнд Улаанбаатарын яриа хэлэлцээ буюу UB Dialogue-гийн 1.5 суваг болтол өргөжилт, эвлэрүүлэн зуучлах үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, 2007, 2009 онд Япон-БНАСАУ, 2014 онд АНУ-БНАСАУ-ын уулзалт, 2018 онд Япон-БНАСАУ-ын уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж, Европын Сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ-European Bank for Reconstruction & Development-EBRD)-нд гишүүнээр элссэн, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцож, цэргийн дипломат ажиллагаа явуулж, Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын судалгааны think tank төвийг Улаанбаатарт байгуулан, АДБХОБ (АІВ)-ны санаачлагчдын нэг болж байгаа нь олон хэмжээст дипломасийн тод илрэл юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах энхийг сахиулах ажиллагаанд тууштай оролцож, НҮБ-д цэрэг хандивлагч 124 орны дунд 2019 оны эцсийн байдлаар 27 дугаарт эрэмбэлэгдэж байгаа бөгөөд Өмнөд Судан, Баруун Сахар, Конго, Суданы Дарфур муж, Суданы Абией муж зэрэг НҮБ-ын энхийг сахиулах таван ажиллагаанд нийт 886 цэргийн албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Тус ажиллагаанд Монгол Улсын энгийн иргэн, иргэний цагдаагийн байгууллагын албан хаагчид 2016 оноос бие даан оролцож байгаа нь⁹ цэргийн дипломат ажиллагааны тод илрэл юм.

Монгол Улс НАТО-гийн “Дэлхийн өнцөг булан бүрт буй түншүүд” (Partners Across the Globe) хөтөлбөрийн хүрээнд “харилцагч орон”-ы статустайгаар хамтран ажиллаж, 2012 оны гуравдугаар сараас “Individual Partnership and Cooperation” хөтөлбөрөөр хамтын ажиллагаа баяжиж, 2020 оны дөрөвдүгээр сард үүнийг шинэчилсэн байна. Афганистан дахь НАТО-гийн тэргүүлсэн олон улсын аюулгүй байдлыг хангах хүчин чармайлтад Монгол Улс дэмжлэг үзүүлсэн билээ.¹⁰

Олон хэмжээст дипломасийн эдийн засаглаг шинж нь гадаад харилцааг эдийн засагжуулж (economization), эдийн засгийн хүч (power of economies), хүчний эдийн засаг(economies of power)-ийн дунд хүрээмжтэй (inclusive), тогтвортой (sustainable),

⁹ Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном-2019. УБ., 2020, 93 дахь тал pdf

¹⁰ NATO Relations with Mongolia March 21, 2021 https://www.nato.int/cps/en/natohq/topics_85297.htm

тэнцвэртэй (balanced), технологид суурилсан (innovative), эрчимтэй (intensive), далайцтай (extensive) байх нь олон хэмжээст дипломасийн амжилтын тулгуур байх нь тодорхой.

Олон хэмжээст дипломасийн шинжлэх ухаанч чанар нь бүтээмжтэй (productivity), өрсөлдөх чадамжтай (competitive), бүтээлч (constructive), нэгдмэл ба залгамж шинжтэй (integrity & continuity) байх, ногоон, цэнхэр эдийн засаг байх, тэдгээрийн шүтэн барилдлагыг хангах нь (supply chain-connective) нэн чухал болно.

Олон хэмжээст дипломаси нь зөөлөн тэнцвэржүүлэхүйн (soft balancing) үндсэн дээр тэнцвэрийн хүчийг (power of balance) олсноор ухаалаг тэнцвэр (smart balance)-ийг буй болгож, даяаршил, дижитал үйл явцад дасан зохицох (adaptation), хөрвөх (convertibility), өөрчлөлтөд хариу барих (responses to change), хариуцлага үүрэх (responsibility), уян хаган (dispositive or flexibility), pragmatic байж, цохилт даах, хүнд нөхцөл байдлаас нэртэй гарах (resilience) байдлыг өөртөө шингээдэг.

Түншлэлийн харилцаа нь олон хэмжээст дипломасийг харуулна. Монгол Улс “иж бүрэн”, “стратегийн”, “иж бүрэн стратегийн”, “олон талтай”, “өргөн хүрээтэй” “өргөтгөсөн” мөн “оюун санааны”, “энхийн төлөө”, “түншлэл, хамтын ажиллагаа”-ны түншлэлийг хэрэгжүүлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хоёр талт харилцаа, хамтын ажиллагааны онцлог, ашиг сонирхлоос хамааран түншлэлийн харилцаагаа янз бүрээр тодотгож, томьёолон гаргаж ирж байгаа ч утга агуулга нь хоорондоо адил төстэй юм уу, ойролцоо утгатай байдаг. Зарим орон «стратегийн» гэдэг үгнээс зайлсхийдэг. «Стратегийн түншлэл»-д уламжлалт болон уламжлалт бус аюул, түүний аюулгүй байдлын асуудал, энхтайвныг сахин хангах, олон улсын терроризмын эсрэг тэмцэх, чөлөөт худалдааны хэлэлцээр гол төлөв тусгагдсан байдгаас гадна гол нь энэ харилцаа урт хугацаанд тогтвортой, бүх талыг хамран үргэлжилнэ гэсэн санаа явж байдаг байна. Харин энд “холбоотны буюу эвслийн” эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих буюу харгалзах, «ах дүүгийн» харилцааны ах нь сургах, дүү нь сонсох агуулга суурилдаггүй бөгөөд үүгээрээ түншлэгч талуудын тэгш эрх хангагдаж буй гэж үзэж болно. Мөн өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь хамтын хариуцлага хүлээдэг. Тэгэхлээр түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрсаг харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн юм.

Далайд гарцгүй, хоёр их гүрнийн дунд орших газаргүйн байршил нь *олон тулгуурт гадаад бодлогоос гадна «олон хэмжээст дипломаси»* явуулах нь түүхэн болон геополитикийн зайлшгүй шаардлагыг буй болгож байгаа тухай дээр тэмдэглэсэн. Байршил нь хүчтэй хөршүүдтэйгээ (Орос, Хятад) болон глобал гүрэн “гуравдагч хөрш” АНУ-тай, бүс нутгийн “гуравдагч хөрш” гүрнүүд болох Япон, Энхтхэг, БНСУ, Турктэй тогтоосон стратегийн түншлэл, иж бүрэн түншлэлийг хөгжүүлэх замаар тэнцвэрийн хүчийг барих боломжтой.

Дөрөв. Монгол Улсын газарзүйн байршлыг геостратегийн үүднээс шинээр үнэлэх нь

Аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагаа мэдлэг, мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээнд суурилах нь аргазүйн нэн чухал ач холбогдолтой. Өнөөгийн даяаршсан, дижитал ертөнцөд мэдлэг нэн чухал мэдээлэл болж, эргээд мэдээлэл нь нэн чухал мэдлэг болж байгаа явдал бөгөөд энэхүү эргэх орчилд судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээний ач холбогдол тасралтгүй өсөн нэмэгдсээр байна.

Улс орон, хувийн хэвшил, хувь хүн гадаад харилцаа, дижитал үйл явцад хэдий чинээ идэвхтэй оролцоотой байна, түүнээс ашиг хүртэх, хөгжих боломж төдийн хэмжээгээр нэмэгдэж байгаа нь өнөөгийн бодит байдал, дүр төрх юм.

Өнөөгийн олон улсын харилцааны бодит хэрэгцээ нь нэгд, урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа (*preventive diplomacy*), хоёрт, онцгой байдал, хямралын үеийн бэлэн байдал, шуурхай удирдлага (*crisis management*), оновчтой шийдвэр, гуравт, аюулгүйжүүлэх бодлого явуулах арга барилыг чадварлаг эзэмшихийг шаардаж байна.

Далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдсан, хоёр их гүрний дунд хашигдсан, хөгжлийн тусламж горилогч, буурай хөгжилтэй, бага жижиг улс хэмээн онцолж байсан Монгол Улсын газарзүйн байршил, геополитикийн тодорхойлт хуучирч байна. Монгол Улс ЕХ-ны хувьд Ази дахь “үнэ цэнэтэй түнш”¹¹ мөн бөгөөд геополитикийн давтагдашгүй геостратегийн байршилтай хэмээн Европын парламентын тогтоолд онцлон тэмдэглэв. ОУВС, ДБ, АХБ болон *Bloomberg L.P*, “*Goldman Sachs Group*”, *Standard & Poor’s Financial Services LLC*, *Moody’s Investors Service*, *Fitch Ratings* Монгол Улсын газарзүйн байршил нь стратегийн онцгой ач холбогдолтой гэж дүгнэх болов.

Эдүгээ Монгол Улс дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт багтах болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын байгууллагын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнесийн бүлэглэлүүдийн геополитик, геозэдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдэлийг дагуулж байна. Үүнд Уул уурхайн салбар юуны өмнө хамаарна. *Байгалийн баялгийн үр шимээс ард иргэд нь тэгш хүртэж чадахгүй, эко орчин нь тэнцвэрээ алдвал тэр нь баялгийн хараал буюу natural resource curse болох ажгуу.* Хэт ашгийн хойноос улайрагч гадны үндэстэн дамнасан хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхол, мөн ч олон улсын банк, санхүүгийн байгууллагын заавар зөвлөмж, их гүрнүүдийн нөлөө ивээл үндэсний шинээр төрж буй баяжих нэн сонирхолтой хөрөнгөлөг этгээдүүд (мөн улс төрчид) хоёрын нийлбэрийг *economic hit men* хэмээн нэрлэх болсон нь онход оргүй зүйл биш юм. *Хоёр хөрштэй тэнцвэртэй харьцах, «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд үүнийг сайтар харгалзан үзэх шаардлага байгаа болов уу.*

Далайд гарцгүй Монгол Улсын туйлын сул талыг өөрийнх нь байгалийн баялаг, эрчимтэй хөгжиж буй Хятадын эдийн засгийн эрэлт хэрэгцээ, Орос, Хятадын иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэл, Монголын геополитикийн оронзай,

¹¹ The European Union is intent on supporting Mongolia in its continued political and economic reform path, as a valuable partner for the EU in Asia. Factsheet on the EU-Mongolia Framework Agreement on Partnership and Cooperation. Bruxelles, 17/02/2017

газарзүйн байршлын геостратегийн шинэ үнэлгээ харьцангуй давуу талыг буй болгож, эерэг тийш нь аажим боловч өөрчилсөөр буйг онцлон дурдах ёстой.

Монгол Улсыг “*аварга баавгай, аварга лууны дунд жороолж буй рону*” гэж бичсэн нь¹² тун ч чамлалттай байсан бөгөөд харин ч *жороолж буй galloper* буюу *Азийн шандаст хүлэг улс руу тэмүүлж буй* хэмээн бичих нь зүйд нийцнэ.

Монгол Улсын газар зүйн байршлын геостратегийн шинэ үнэлгээ. Үүнд:

- Үүнд: Монгол Улсын хойд хөрш дэлхийн хамгийн том нутаг дэвсгэртэй, цөмийн зэвсэгтэй, сэргэн мандаж буй, НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн ОХУ, Өмнөд хөрш дэлхийн хамгийн их хүн амтай, *өндөр хурдацтай хөгжлөөс өндөр чанарт суурилсан хөгжилд шилжиж* буй¹³, цөмийн зэвсэгтэй, НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн БНХАУ, өөр өөрийн онцлог бодлого, байр суурьтай хоёр хөршөөр хүлээлэгдсэн цорын ганц гэж хэлж болохоор геополитикийн давтагдашгүй байршилтай.
- Өрнөдийн эдийн засгийн хоригтой холбоотойгоор ОХУ-ын Алс Дорнодын бодлого, ялангуяа БНХАУ-ыг чиглэсэн бодлого идэвхжсэн нь Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн ач холбогдлыг мэдэгдэхүйц өсгөв.
- Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн харилцан ажиллагааны түншлэлийн (*comprehensive strategic interaction partnership*) түвшинд хүрсэн нь Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин таатай байна гэж үзэж болох талтай. 2018 онд Орос, Хятадын худалдааны эргэлт 30 хувийн өсөлт үзүүлж, анх удаа 100 тэрбум ам. долларын босгыг давж, 107.06 тэрбум ам.долларт хүрснийг Хятадын Худалдааны яамны хэвлэлийн төлөөлөгч Гао Фен (Gao Feng) болон Гаалийн ерөнхий газар албан ёсоор зарлав.¹⁴ Энэ үзүүлэлтийг хоёр хөрш 2023 гэхэд 200 тэрбум ам.долларт хүргэхээр тохиролцсон нь Монгол Улсын газрын гүүр, идэвхтэй транзит орон болох зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Монгол Улс бүс нутагтаа хөрш гүрнүүдтэйгээ улс төр, газар нутгийн аливаа маргаангүй, түншлэлийн эрхзүйн үндсийг баттай тавьсан цорын ганц улс бөгөөд Монгол Улс 2002 онд ОХУ-тай 3543 км урт хилийг хамтран шалгаж эцэслэн тодотгосон бол, 2001-2004 онд БНХАУ-тай хилээ хоёр дахь удаагаа хамтран шалгаж, 4676.8 км урт хилийн шугамыг тогтоож, Монгол Улсын хилийн багануудыг анх удаа боржин чулуугаар шинэчлэн босгож, НҮБ-д бүртгүүлэв. Ийнхүү өнөөдөр Монгол Улсын хилийг эмжсэн 8219 км 895 м урт хил олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байна.
- Монгол Улс Орос-Хятадыг дөт замаар, Зүүн Ази, Солонгосын хойг-ЕХ-г холбох *landbridge* хийгээд *transit* улс болох боломж байна.
- Монгол Улсын байгалийн баялаг: Bloomberg-ийн үнэлгээгээр тогтоогдсон нөөц

¹² «Why All Roads Lead to Mongolia» by Steven Borowiec. September 14, 2011, <https://thediplomat.com/2011/09/why-all-roads-lead-to-mongolia/>

¹³ “The fourth plenary session of the 19th Central Committee of the Communist Party of China”-Xinhua. Oct. 28, 2019

¹⁴ *Ibid.*, Russia’s trade with China surges to more than \$107 billion .RT 14 Jan, 2019

<https://www.rt.com/business/448783-russia-china-trade-turnover/>
China-Russia trade volume tops 100 bln USD, Xinhua. 2019.01.10
http://www.xinhuanet.com/english/2019-01/10/c_137734116.htm

2.3 их наяд ам.доллар байна.¹⁵ 2019 оны 7-8 дугаар сарын заагт Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга АНУ-д төрийн айлчлал хийх үеэрээ америкийн *think-tank* Стратеги, олон улс судлалын төвд зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлэгт оролцож, “Монгол Улс-АНУ-ын харилцааны төлөв байдал” сэдвээр үг хэлэхдээ: Монгол Улсын байгалийн баялгийг зарим томоохон банкны судалгааг үндэслэн 32 их наяд ам.доллар байна гэж мэдэгдсэн билээ.¹⁶

АМГТГ-ын бүртгэсэн нөөцөөр Монгол Улсад ашигт малтмалын 1170 орд, 8000 гаруй илэрц байна.¹⁷ Оюутолгойн орд гэхэд л алтны нөөцөөрөө дэлхийд зургаадугаар байрт (46,340,000 унци алт= (one ounce gold=1,903.33 in May 31, 2021) 90 орчим тэрбум ам.доллар) орж байгаа нь Монголын нэг иргэнд 75 сая төгрөг ногдож байна.

Монгол Улс Владивосток, Тяньжин боомтоор далайд гарцтай болох эрхзүйн үндэс нэгэнт тавигдаж, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) байгууллагын 2019 орны долоодугаар сарын тайланд тэмдэглэснээр нийт 664 мянган тонн чингэлгийн даацтай 265 хөлөг онгоц Монгол Улсын далбааг мандуулан нээлттэй далайд хөвж яваа ажээ.¹⁸ ЗТХЯ-ны далайн захиргааны 2019 оны наймдугаар сарын 1-ний албан мэдээнд Монгол Улсын бүртгэлтэй нийт 604,794 тоннын даацтай 32 орны 336 хөлөг онгоц ачаа тээвэрлэж байгаа ажээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улс өөрийн худалдааны флоттой гэж хэлж болохоор байгаа юм. ОХУ-ын нутгаар дамжин, Владивостокт Монгол Улс далайд гарцтай болох боломж бүрдсэн нь худалдаа-эдийн засгийн төдийгүй геополитикийн ач холбогдолтой. 2021 оны нэгдүгээр сарын 25-нд тус хотод Монгол Улс Худалдааны төлөөлөгчийн газраа нээв.¹⁹

Монгол Улс далайд гарцгүй хөгжиж буй 32 орноос онцлог ялгаатай, харьцангуй давуу талтай юм.

АМГТГ-д албан ёсоор бүртгэгдсэн мэдээллээр Монгол Улс газрын тосны нөөцөөрөө дэлхийд 33-т ордог агаад 332.64 сая тонн нөөцтэй гэсэн тооцоо гарчээ.²⁰ БНЭУ-ын 1.2 тэрбум ам.долларын хөнгөлттэй зээлээр Дундговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт барьж буй Газрын тос боловсруулах үйлдвэр нь магад “Оюутолгой” төсөлтэй зүйрлэшгүй ач холбогдолтой бөгөөд ашиглалтад орсноор өргөн утгаар нь авч үзвэл Монгол Улсын үндэсний аюулгүй байдал улам баталгаажих учиртай. Газрын тос боловсруулах үйлдвэр 2023 онд ашиглалтад орсноор жилд 1,5 сая тонн газрын тос боловсруулж, чингэснээр жилд 43 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий, 339 мянган тонн автобензин, 824 мянган тонн дизель түлш, 80 мянган тонн онгоцны

¹⁵ Монголын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн геологийн шаталсан судалгаа, эрэл, хайгуулын ажлын үр дүнд 80 гаруй төрлийн ашигт малтмалын 1100 гаруй орд, олон мянган эрдэсжсэн цэгийг тогтоож, 2017 оны байдлаар 57 сая тонн зэс, 37.2 тэрбум тонн нүүрс, 1.2 тэрбум тонн төмрийн хүдэр, 2500 тонн алт, 1.7 сая тонн цайр, 48.3 сая тонн хайлуур жонш, 197 мянган тонн уран, 332.6 сая тонн газрын тосны баталгаат нөөцийг бүртгээд байгаа юм. Монгол Улс ураны ордоо олборлож эхлээгүй байна. 2011 онд бүртгэгдсэн 6 260 тонн нөөцтэй Дулаан-Уулын орд, 2013 онд бүртгэгдсэн 54640 тонн нөөцтэй Зөөвч-Овоо орд Монгол Улсыг ураны нөөцөөрөө дэлхийд тэргүүлэх эхний арван хоёр орны тоонд багтаасан байна. Монгол Улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс эдгээрийг албан ёсоор стратегийн ач холбогдол бүхий нөөцөд бүртгэжээ

¹⁶ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Монгол-АНУ-ын харилцааны төлөв байдал” сэдвээр уулзалт, ярилцлага өрнүүлэв. 2019.07.31 <https://president.mn/10277/>

¹⁷ Байгалийн баялаг ард түмний мэдэлд. <https://www.montsame.mn/mn/read/212290>, 2020.01.10

¹⁸ According to the UNCTAD, 265 vessels with a total cargo capacity of 664 million tons are sailing under the Mongolian flag Jul 29, 2019 CNN.com

¹⁹ Во Владивостоке откроют торгпредство Монголии. 25 Янв, 2021 <https://tass.ru/ekonomika/10539355>

²⁰ Газрын тосны ашиглалт, олборлолт. <https://mrpam.gov.mn/article/49/>

түлш, 47 мянган тонн зуухны түлш үйлдвэрлэх ажээ. Жил бүр гадаад улсаас нефтийн бүтээгдэхүүн худалдан авдаг нэг тэрбум ам.доллар Монгол Улсад үлдэнэ. Энэ хэрээр валютын ханш тогтворжиж, ДНБ 10 гаруй хувиар нэмэгдэж, улс, орон нутгийн төсвийн орлого 150 сая ам.доллараар өсч, 600 гаруй ажлын байр шинээр бий болж, үйлдвэрийг дагасан жижиг, дунд үйлдвэр хөгжих ажээ.²¹

Монгол Улсын хүн ам 3.3 сая боловч, Үндэсний Статистикийн Хорооноос 2020 оны эцсийн тооллогоор малын тоо толгой урьдчилсан дүнгээр 67.1 саяд хүрч байгаа нь²² гео-эдийн засгийн чухал үзүүлэлт мөн.

Монгол Улс АДБХОБ-ны анхны үүсгэн байгуулагч 21 орон мөний хувьд хий дамжуулах хоолойн мега төсөл, эрчим хүчний супер сүлжээ, Замын-Үүд-Эрээний хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн зээл авах чиглэлээр ажиллах шаардлага буй.

АНУ-ын Энэтхэг-Номхон далайн стратегид Монгол тодорхой байр эзэлж байна. АНУ-ын зүгээс Энэтхэг-Номхон далайн бүс нутагт явуулах бодлогыг тодорхойлж, тус улсын Батлан хамгаалах яамнаас гаргасан “Энэтхэг-Номхон далайн стратегийн баримт бичиг”-ийн 4.2-т “Япон, Өмнөд Солонгос, Австрали, Филиппин болон Тайланд улстай холбоотны харилцаагаа цаашид улам бэхжүүлэх нь чухал” гэдгийг дурдаад Ази-Номхон далайн бүс нутаг дахь стратегийн ач холбогдолтой улсуудыг нэрлэсэн юм. Тэдгээрийн тоонд Сингапур, Шинэ Зеланд, Монгол Улс болон Тайвань багтжээ. Уг баримт бичигт Шинэ Зеланд 17, Сингапур 15, Монгол 17, Тайвань 30 удаа дурдагдсан нь тухайн гурван улс болон Тайвань нь Энэтхэг-Номхон далайн бодлогод үндсэндээ адилхан байр суурь эзэлж буйг илтгэн харуулж байгаа юм.²³

Тав. Үнэлгээ

Нэгт, Даяаршил, дижиталчлалын үйл явц гүнгийрч, харилцан хамаарал тодорхойлогч хүчин зүйл болж, хамгийн хүчирхэг батлан хамгаалах чадавхтай, хамгийн хүчирхэг эдийн засагтай улс гүрэн ч өөрийн аюулгүй байдал, хөгжил дэвшлийг дангаараа хангаж, хөтлөн авч явах бололцоогүй болжээ. АНУ, ОХУ, БНХАУ-д энэхүү дүгнэлт юуны өмнө хамаарна.

Хоёрт, Хөгжиж буй орнууд олон улсын банк, санхүүгийн байгууллагын заавар зөвлөмж, зээл тусламж, их гүрнүүдийн нөлөө ивээл, хандив, үндэстэн дамнасан корпорациудын хөрөнгө оруулалтад улам бүр дулдуйдах болсон нь тэдгээр орны бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдлын тодорхой хэсэг тэдгээр байгууллага, улс гүрэн, корпорациудын үйл ажиллагаанаас олон талаар хамаарах болов.

Гуравт, ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхжиж байгаа ч хоёр хөршид эрх мэдэл нэг хүний гарт улам бүр төвлөрч, авторитар дэглэм эрчээ авч, олон нийтийн мэдээлийн хэрэгсэлд тавих хяналт чангарч, хүний эрх, эрх чөлөөг боймолж буй нь иргэдийн эрх чөлөөг эрхэмлэх үзэл бодолтой улам бүр зөрчилдөж байна.

²¹ <http://www.mongolrefinery.mn/home> “Газрын томны үйлдвэр мөнгөөр хэмжимгүй үнэт зүйлс бий болгоно”-2020.11.19 <https://montsame.mn/mn/read/243660>

²² Үндэсний Статистикийн Хороо. 2021.01.13

²³ THE DEPARTMENT OF DEFENSE Indo-Pacific Strategy Report Preparedness, Partnerships, and Promoting a Networked Region June 1, 2019

Дөрөвт, Олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явц тодорхой сорилтуудтай тулгарсаар байна. Орос-Гүржийн дайн, ОХУ Крымын хойгийг өөртөө хавсарган нэгтгэсэн, Зүүн Украин дахь зэвсэгт мөргөлдөөн, ОХУ Сирийн иргэний дайнд оролцсон, Беларусийн сонгуулийн үр дүн, ОХУ-ын цэргийн холбоотон Армен Уулын Карбахын сөргөлдөөнөөр Азербайжантай хийсэн дайнд ялагдал хүлээсэн, Өмнөд Хятадын тэнгис, Тайванийн асуудлаарх Хятад Америкийн сөргөлдөөн, худалдааны дайн, Өрнөдийн хориг арга хэмжээ үргэлжилсээр байгааг бид харж байна.

Тавд, ОХУ 2016 оны зургаадугаар сард Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг Монголын талд худалдсанаар 50:50 хувийн “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийг (Хувь нийлүүлсэн нийгэмлэг) эс тооцвол Монгол дахь ОХУ-ын гео-эдийн засгийн томоохон ашиг сонирхол үндсэндээ байхгүй болсон гэж дүгнэж болохоор байдаг. Тиймээс 2021 онд багтаж ТЭЗҮ-ийг боловсруулж гаргахаар төлөвлөгдөж буй Монголын нутгаар дамжуулан ОХУ-аас БНХАУ руу хий дамжуулах төсөл ажил хэрэг болбол Монгол Улс дахь ОХУ-ын эдийн засгийн бодит ашиг сонирхол жинхэнэ ёсоор буй болж, энэ нь цаашдаа иж бүрэн стратегийн түншлэл, гурван хөршийн эдийн засгийн коридорын цөм хэсэг болох боломж харагдаж байна. Зарим хүмүүсийн хардаж байгаагчлан Монголын нутгаар хий дамжуулах хоолой тавигдсанаар Монгол Улсын ОХУ-аас хараат байдал улам нэмэгдэх бус харин ч Орос, Хятад хоёр хөрш Монгол Улсаас илүү хамааралтай болох юм. Дурдсан төсөл нь зөвхөн эдийн засгийн үр ашигтай төсөл байх төдийгүй, улс төр-геополитикийн ач холбогдолтой гэдэг үүднээс давхар авч үзэх ёстой.

Зургаад, Даяаршил, чөлөөт зах зээл, дижиталчлалыг зөв залж жолоодох буюу манипуляци хийх явдал зайлшгүй чухал болж байна. Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх явдал мөн.

Долоод, Хятадын эдийн засгийн эрчимтэй хөгжил удааширч байгаа боловч үүнийгээ өндөр хурдацтай хөгжлөөс өндөр чанарт суурилсан хөгжилд шилжиж байна гэж онцлон тэмдэглэж байгаа²⁴ бөгөөд энэ нь глобал эдийн засгийн хөгжил, олон улсын харилцааны олон туйлт системийг бүрдүүлэхэд зохих нөлөө үзүүлсээр байна.

Наймд, Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлттэй холбоотойгоор Хятад нүүрсний хэрэглээгээ эрс багасгах чиг барьж байгаа нь Монгол Улсын хувьд таатай биш.

Ест, 2019 онд ОХУ-ын нүүрсний нийт экспортын хэмжээ 225 сая тоннд хүрчээ. Үүнээс 35 сая тонн нүүрс Хятад руу экспортолсон нь өмнөх оныхоос 27 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Ойрын үед Ази-Номхон далайн орнуудад экспортолж буй нүүрсний нийт хэмжээ 100 сая тоннд хүрэхээр байна. ОХУ ирэх арван жилд зөвхөн Хятадын зах зээлд нийлүүлэх нүүрсний экспортын хэмжээг 55 сая тоннд хүргэхээр төлөвлөж байгаа ажээ. Оросын нүүрсний хамгийн том импортлогч орон нь Хятад, Өмнөд Солонгос, Япон улс. Хятадын зах зээлд нүүрсний экспортын хэмжээгээр Австрали, Индонезийн дараа Орос эрэмбэлэгдэж байна. Австралитай харьцуулахад Оросын нүүрс богино зам туулж Хятадын гол боомтуудад хүрэх давуу талтай.²⁵ Тиймээс Монгол Улсын нүүрсний

²⁴ “The fourth plenary session of the 19th Central Committee of the Communist Party of China”-Xinhua. Oct. 28, 2019

²⁵ Экспорт российского угля в Китай может вырасти вдвое за десять лет. 15.11.2019

геополитикийн харьцангуй давуу талын хүчин зүйлд сөргөөр нөлөөх хандлага ажиглагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Монголын нүүрсний экспортын гол өрсөлдөгч нь Австрали, Индонези, Канад биш, харин ОХУ болно. Мөн Хятадын эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ дэлхийн байгалийн баялаг, түүхий эдийг сорогч **black hole** байнга хэвээрээ байна гэсэн төсөөллөө өөрчлөх шаардлагатай.

Аравт, Хятадын эдийн засаг асар хурдацтай дижиталчлагдаж байна. Монгол Улс эл үйл явцтай хөл нийлүүлж дижитал ложистикийг эрс сайжруулах шаардлагатай.

Арваннэгд, “Зэвсэглэлд хяналт тавих асуудал хариуцсан олон байгууллагын шинжээчид улс хоорондын итгэлцэл ноцтой алдагдаж, их гүрнүүд дипломат үйл ажиллагаа, яриа хэлэлцээ гэхээсээ цэргийн нөөц бололцоог илүү үнэлж эхэлж байгааг анхаарах ёстой.”²⁶

Арванхоёрт, Төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгааг дурдах хэрэгтэй.

Арвангуравт, 2020-2021 оныг дамнан үргэлжилж буй дэлхий дахиныг хамарсан коронавирусын цар тахал олон зүйлийг шинээр үнэлэх боломж олгож байна. COVID-19 цар тахлын өмнөх ба дараах дэлхий ертөнц гэсэн шинэ нөхцөл байдал бий болов.

Арвандөрөвт, Геополитикийн гол элемент болох хүч чадалд хамаарах хүчин зүйл бол ардчилсан ухаалаг засаглал, түүний чанар хийгээд улс төрийн удирдагчийн *behavior*, ёсзүй, зөвшилцөх чадавх бөгөөд улс орны үндэсний аюулгүй байдалд шууд нөлөө үзүүлдэг. Энэ бол Монгол Улсад хамаарах магадгүй хамгийн гол хүчин зүйл мөн болой.

Арвантавд, Удаан хугацаанд үргэлжлэх төлөвтэй Хятад, Америкийн худалдааны дайн, Тайваньтай холбоотой геополитикийн сөргөлдөөн Хятадын эдийн засгийн хөгжилд, цаашлаад Монгол Улсын худалдаа-эдийн засаг, “гуравдагч хөрш”-ийн бодлогод таатай нөлөө үзүүлэхгүй.

Арванзургаад, Солонгосын хойгийн аюулгүй байдалд нааштай өөрчлөлтүүд гарч буй боловч үндсэн асуудал шийдэгдээгүй хэвээр үлдэв. Үүнд:

- Нэг ч цөмийн зэвсэг устгагдаагүй
- Баллистик пуужингийн туршилт үргэлжилсэн хэвээр
- Гал зогсоох хэлэлцээр энхийн хэлэлцээрээр солигдоогүй
- БНАСАУ-ын удирдагч Ким Жон Ун 2021 оны нэгдүгээр сард хуралдсан СХН-ын VIII их хуралд хэлсэн үгэндээ: "Тус улс цөмийн хүчнээ байгуулж дууслаа" хэмээн мэдэгдэв²⁷.

Арвандолоод, Хойд мөсөн далайн бүс нь байгалийн баялаг их нөөцтэй нь тодорхой болж, тиймээс ч холбогдох улс гүрнүүд дурдсан газар нутагт өөрийн туг далбаагаа хэдийн мандуулж эхэлжээ. Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтэй холбоотойгоор Хойд Мөсөн далайн баялгийг олборлох боломж нэмэгдэж, тус далайгаар Хойд Европоос Зүүн

<https://ria.ru/20191114/1560925723.html>

²⁶ РИА Новости. 16 октября 2019

²⁷ North Korea's Kim Threatens to build more nukes and bring U.S. its "knees" as Trump's Term ends. Jan. 10, 2021 <https://www.nbcnews.com/news/world/north-korea-s-kim-threatens-build-more-nukes-bring-u-n1253625>

Өмнөд Ази хүрэх усан замын урт 40 хувиар багасч, өртөг энэ хэмжээгээр буурах боломж өргөжиж,²⁸ “нэг бүслүүр, нэг зам” санаачилга энэ чиглэлд хэдийн анхаарлаа хандуулж, БНХАУ, Энэтхэг, Сингапур улс хүртэл *Arctic Council*-д ажиглагч гишүүн орны статустай болсон нь Монгол Улс энэ чиглэлд үйл ажиллагаагаа идэвхжүүлж, ажиглагч гишүүнээр элсэх шаардлагатай болов уу.

Аравнаймд, Геополитикийн шинэ параметр, Монгол Улсын газарзүйн байршлын геостратегийн шинэ өөрчлөлт, үнэлгээг урт удаан хугацаанд хадгалах зэрэг явдал чухал болой.

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010
2. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011
3. Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном-2019. УБ., 2020 Russia backs extending space cooperation deal with U.S. to 2030 – agencies. By Reuters Staff, April 3, 2021 <https://www.reuters.com/article/us-russia-usa-space-idUSKBN2>
4. Визит Генерального секретаря ЦК КПСС, Председателя Президиума Верховного Совета СССР М.С.Горбачева в Китайскую Народную Республику 15-18 мая 1989 года Документы и материалы. М., Изд. Политической Литературы. 1989, стр. 18
5. Выступление В.Путина на заседании клуба “Валдай”. Полный текст 23 Октября, 2020 <https://tass.ru/politika/9789887>
6. Сергей Лавров заявил что Россия и Китай не преследуют цели создать военный союз ТАСС 06 Апрель, 2020 <https://tass.ru/politika/11077113>
7. В.Путин принял участие в итоговой пленарной сессии XI заседания Международного дискуссионного клуба «Валдай». Тема заседания-«Мировой порядок: новые правила или игра без правил?». 24 октября 2014 года. Сочи.
“NATO Relations with Mongolia” March 21, 2021 https://www.nato.int/cps/en/natohq/topics_85297.htm
 The European Union is intent on supporting Mongolia in its continued political and economic reform path, as a valuable partner for the EU in Asia. Factsheet on the EU-Mongolia Framework Agreement on Partnership and Cooperation. Bruxelles, 17/02/2017
«Why All Roads Lead to Mongolia» by Steven Borowiec. September 14, 2011, <https://thediplomat.com/2011/09/why-all-roads-lead-to-mongolia/>
8. “The fourth plenary session of the 19th Central Committee of the Communist Party of China”-Xinhua. Oct. 28, 2019
9. Russia’s trade with China surges to more than \$107 billion .RT 14 Jan, 2019

²⁸ Is this a new era for the Arctic? <https://www.weforum.org/agenda/2019/11.27/is-this-a-new-era-for-the-arctic/>

<https://www.rt.com/business/448783-russia-china-trade-turnover/>

China-Russia trade volume tops 100 bln USD, Xinhua. 2019.01.10

http://www.xinhuanet.com/english/2019-01/10/c_137734116.htm

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга “Монгол-АНУ-ын харилцааны төлөв байдал” сэдвээр уулзалт, ярилцлага өрнүүлэв. 2019.07.31 <https://president.mn/10277/>

10. Байгалийн баялаг ард түмний мэдэлд.

<https://www.montsame.mn/mn/read/212290>, 2020.01.10

According to the UNCTAD, 265 vessels with a total cargo capacity of 664 million tons are sailing under the Mongolian flag Jul 29, 2019 CNN.com

11. Во Владивостоке откроют торгпредство Монголии. 25 Янв, 2021

<https://tass.ru/ekonomika/10539355>

Газрын тосны ашиглалт, олборлолт. <https://mrpam.gov.mn/article/49/>

<http://www.mongolrefinery.mn/home> “Газрын томны үйлдвэр мөнгөөр хэмжимгүй үнэт зүйлс бий болгоно”- 2020.11.19 <https://montsame.mn/mn/read/243660>

12. Үндэсний статистикийн хороо. 2021.01.13

13. THE DEPARTMENT OF DEFENSE Indo-Pacific Strategy Report Preparedness, Partnerships, and Promoting a Networked Region June 1, 2019

14. “The fourth plenary session of the 19th Central Committee of the Communist Party of China”-Xinhua. Oct. 28, 2019

15. Экспорт российского угля в Китай может вырасти вдвое за десять лет. 15.11.2019

<https://ria.ru/20191114/1560925723.html>

16. РИА Новости. 16 октября 2019

North Korea’s Kim Threatens to build more nukes and bring U.S. its “knees” as Trump’s Term ends. Jan. 10, 2021 <https://www.nbcnews.com/news/world/north-korea-s-kim-threatens-build-more-nukes-bring-u-n1253625>

Is this a new era for the Arctic? <https://www.weforum.org/agenda/2019/11.27/is-this-a-new-era-for-the-arctic/>



Л.ЭРДЭНЭЧУЛУУН
Онц бөгөөд Бүрэн
Эрхт Элчин Сайд

БИД НҮБ–гүйгээр АМЬДАРЧ ЧАДАХ УУ?

Abstract: The article describes the role of the United Nations—the conditions and reasons for its establishment, and why it has received international recognition for 76 years and continues to expand in terms of membership. Furthermore, recount how the UN has fulfilled its responsibilities over the past 76 years and how its position and policies have changed in principle.

The main concept of the article asks the general question, do countries really need the UN? In particular, with the establishment of the UN, what kind of beneficial effects it has on small and developing countries like Mongolia. And based on specific examples and data, this article looks at how Mongolia's external environment and foreign relations have expanded and developed since becoming a member of the UN.

I have attempted to present this article based on the 34 years of knowledge and experience I have gained in the diplomatic service, which focused mainly on the development of multilateral relations and cooperation with the United Nations.

Нэг. НҮБ ямар үүрэгтэй юм бэ?

Улс орнууд өөр хоорондоо аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс зайлсхийх, олон улсын харилцаанд хууль, эрх зүйг дээдлэх гол үндсээ болгох хүсэл эрмэлзэл нь угтаа НҮБ үүсэн байгуулагдахад хүргэсэн байдаг. Дэлхийн хоёр их дайны гарз хохирлыг биеэр амсч даван туулсан улс орнууд, ялангуяа дайнд ялагч их гүрнүүд хүн төрөлхтөн амар амгалан аж төрөх, энх тайвнаар зэрэгцэн орших, дайны гамшгаас хойч үеийнхнийг ангижруулахын үндэс суурь нь олон улсын эрх зүйг мөрдлөг болгох, дайн мөргөлдөөнөөс сэргийлэхэд орших юм гэдэгт санал нэгдсэн билээ. Тийм ч учраас НҮБ-ын Дүрмийн нэгдүгээр зүйлийн эхэнд заахдаа “Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, энэ зорилгын үүднээс энх тайванд учрах аюул заналыг сэрэмжлэн

зайлуулах, түрэмгийлэл буюу энх тайвныг бусниулах бусад явуулгыг дарахын тулд үр нөлөөтэй хамтарсан арга хэмжээ авах, олон улсын маргаан буюу энх тайвныг бусниулахад хүргэж болзошгүй байдлыг шударга ёс, олон улсын эрх зүйн зарчмын дагуу эв зүйгээр зохицуулах буюу шийдвэрлэж байх” гэсэн байдаг.

Олон улсын байгууллага үүсгэн байгуулах асуудлаарх Нэгдсэн Үндэстнүүдийн бага хурлын төгсгөлийн хуралдаан дээр 1945 оны зургаадугаар сарын 26-ны өдөр Сан Франциско хотноо гарын үсэг зурж НҮБ байгуулагдсанаас хойш даруй 76 жилийн нүүрийг үзээд байна.

Гэхдээ хүн төрөлхтөн хамтын эрх ашгаа хамгаалах, энх тайван, дэлхийн дэг журмыг тогтоох зорилго бүхий олон улсын байгууллага–НҮБ-ыг байгуулсан нь анхны тохиолдол биш ээ. Тэртээ XVII зуунд Төв Европын 100 жилийн дайны дараа тухайн үеийн Европын орнууд 1648 онд Вестфалийн, Наполеоны дайны дараа 1815 онд Венийн, Дэлхийн I дайны дараа 1919 онд Версалийн бага хурлыг тус тус зохион байгуулж олон улсын гэрээг байгуулж байсан. Версалийн энх тайвны бага хурлын шийдвэрийн дагуу 1919 онд Үндэстнүүдийн холбоо гэдэг олон улсын байгууллагыг байгуулж байсан удаатай. Гэвч дээрх хамтын гэрээ, байгууллага нь цагийн аясаар, он цагийн шалгарлыг даалгүй устан алга болсон юм.

НҮБ нь өнгөрсөн 76 жилийн түүхэн хугацаанд дайны гамшгаас ангижруулах, олон улсын аюулгүй байдлыг сахин хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, том, жижиг үндэстэн адил эрх тэгштэй байх, улс орнууд хөгжил дэвшилд хүрэхэд голлох үүрэг гүйцэтгэж, жинтэй хувь нэмрээ оруулсаар ирсэн байдаг.

“Хүйтэн дайн”-ы ид үе буюу 1950-1970-аад оны үед НҮБ-ын үүрэг, оролцоо бүүрч илүү чухал байв. Солонгосын дайн, Вьетнамын дайн, Суэц, Карибын болон Европуужингийн хямрал зэрэг “Хүйтэн дайн”-ы сөргөлдөөн дээд цэгтээ хүрсэн халуун үед НҮБ нь дайн, мөргөлдөөнийг намжаах зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, олон улсын яриа хэлцээний индэр болж байсан юм. Дээрх дайн, хямрал, мөргөлдөөнийг НҮБ-ын оролцоо, тусалцаагүйгээр даван туулах бололцоогүй байсан. Тухайлбал, НҮБ-ын хоёр дахь Ерөнхий нарийн бичгийн дарга Даг Хаммаршельд Африк тивд гарсан иргэний дайныг зохицуулах үүрэг гүйцэтгэж байхдаа 1961 онд онгоцны ослоор золгүйгээр амь үрэгдсэн бөгөөд энэ нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад НҮБ нь хэрхэн идэвх чармайлт гарган ажиллаж байсны нэг тод жишээ юм.

“Хүйтэн дайн”-ы үед “Хоёр туйлт ертөнц”-ийн мөргөлдөөнийг зөөлрүүлж саармагжуулахад НҮБ нь “жийргэвч”, зуучлагч дундын бүс болж байсан олон арван жишээг дурдаж болно.

Хэрэв НҮБ байгаагүй бол хүн төрөлхтний дийлэнх хэсэг нь дайн, мөргөлдөөнд уусч хүнд бэрх олон бэрхшээлтэй тулгарах байсан биз ээ.

Бие биенээ сөрөн зогссон “хоёр туйлт ертөнц” задран унаж “Хүйтэн дайн” дуусгавар болсон хэдий ч улс гүрнүүд шинээр олон бэрхшээл, сорилттой тулгарах болсон юм. Уламжлалт аюулгүй байдлын асуудал дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн ойлголцол, итгэлцлийн үр дүнд намжиж “толгойн өвчин” байхаа больсон хэдий ч уламжлалт бус аюулгүй байдлын асуудлууд болох дэлхийн дулаарал, халдварт өвчин, олон улсын терроризм, шашин, үндэстэн хоорондын мөргөлдөөн улам идэвхжин газар

авч улс орнууд нэгдэн нягтрах, хүчээ нэгтгэж хамтран эрс шийдэмгий тэмцэх шаардлага зүй ёсоор тулгарсан билээ.

Дэлхий нийтийг хамарсан дээрх сорилттой тулгарахад ямар ч улс орон, хүчирхэг ч бай дангаар, олон улсын хамтын нийгэмлэггүйгээр шийдэх боломжгүй гэдгийг хүн төрөлхтөн ойлгосон юм.

ЗХУ задарч, социалист систем нурах 1990-ээд оны үед АНУ-ын нөлөө нэмэгдэх, ЗХУ-ын хуучин орон зайд ноёрхох хандлага гарч байсан. Миний бие тэрхүү чухал шилжилтийн үед буюу 1990-1996 онд НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгч, Элчин сайдаар ажиллаж байсны зэрэгцээ НҮБ-ын Нэгдүгээр хороо буюу Зэвсэг хураах, аюулгүй байдлын асуудал хариуцсан хорооны дарга, мөн Зэвсэг хураах комиссын дарга, орлогч дарга, ажлын хэсгийн даргын сонгуульт ажлыг тус тус хийж байсны хувьд олон улсын харилцааны хувьсал өөрчлөлтийг биеэр мэдэрч байсан гэдгийг хэлэх нь зүйтэй. Нөгөөтэйгүүр дипломат албанд Гадаад хэргийн сайд хүртэл ажилласан 34 жил бүхэлдээ олон талт харилцаа, хамтын ажиллагаа буюу НҮБ-ын чиглэлээр ажилласан байдаг. Зөвхөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд 1970 оноос хойш миний бие 28 удаа оролцсон байх жишээтэй.

НҮБ-ын олон тогтоол, шийдвэр нь хөгжиж буй жижиг, буурай орнуудын эрх ашгийг хамгаалахад чиглэж, тэдний тусын тулд үйлчилж ирсэн нь тус байгууллага өнөөдрийг хүртэл нэр хүндтэйгээр оршин тогтнож байгаагийн нэг илрэл юм.

НҮБ нь түүхэндээ ч, одоо ч тэр жижиг буурай, хөгжиж буй орнууд эрх ашгаа хамгаалах, дуу хоолойгоо хүргэх гол индэр болсоор ирсэн.

Нэг тодорхой жишээ дурдахад Өрнөдийн өндөр хөгжилтэй орнууд 90-ээд оныг хүртэл олон жилийн турш ядуурал, байгаль орчны асуудалд хойрго хандаж ирсэн байдаг. Харин социалист болон хөгжиж байгаа орнуудын олон жилийн уйгагүй хүчин чармайлтын үрээр дээрх хоёр асуудлыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүрсэн байдаг. Ийнхүү хүлээн зөвшөөрсний тодорхой илрэл нь ядуурал, байгаль орчинг хамгаалах чиглэлээр Дэлхийн банк, ОУВС зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллагаас олон төсөл хөтөлбөрийг дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа билээ. Мөн түүнчлэн хүний эрхийн тухай асуудал нь агуулгын хувьд баяжин илүү өргөн утгаар ойлгох болсон юм. Австрийн Вена хотноо 1993 онд хуралдсан НҮБ-ын Хүний эрхийн асуудлаарх бага хурлаас “хөгжих эрх”-ийн тухай зарчмыг анх удаагаа баталсан.

Хоёр туйлт ертөнцийн өрсөлдөөний үед жижиг орнуудын эрх ашгийг хамгаалах нэг гол суваг нь “77-ийн бүлэг” болон Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн /ЭҮНХ/ байсан юм. Чухамхүү энэхүү хоёр чухал сувгаар дамжуулан НҮБ-ын хүрээнд нийгэм, эдийн засгийн хувьд манай улстай ижил болон хөгжиж байгаа буурай орнууд нийтлэг эрх ашгаа хамгаалах, өөрсдийгөө илэрхийлэх зэргээр ажиллаж ирсэн.

Эдийн засгийн хамтын сонирхлоо харилцан дэмжих, НҮБ-ын системийн хүрээнд болж байгаа олон улсын эдийн засгийн гол асуудлаарх хэлэлцүүлэгт нэгдмэл байр сууринаас хандан, Өмнөд-Өмнөдийн хөгжлийн хамтын ажиллагааг дэмжих зорилго бүхий хөгжиж буй 77 орон 1964 онд анх “77-ийн бүлэг”-ийг байгуулсан бөгөөд одоо энэ бүлэг нь НҮБ-ын 134 гишүүн орнуудын нэгтгэсэн хамгийн том бүлэг болоод байна.

ЭҮНХ цэрэг-улс төрийн аливаа эвсэлд нэгдэхээс татгалзах, хараат бус, тэгш байдлын зарчимд тулгуурлан ард түмнийг энх тайвнаар зэрэгцэн орших зарчмыг баримтлан 1961 онд 25 гишүүнтэй байгуулагдаж байсан байдаг. Хэдийгээр үүрэг, нөлөө нь багасч байгаа ч дэлхийн 120 улсыг нэгтгэсэн, гишүүн орнууд нь НҮБ-ын гишүүдийн гуравны хоёрыг, дэлхийн хүн амын 55 хувийг бүрдүүлж байна.

Манай улс “77-ийн бүлэг”, ЭҮНХ-д 1992 онд тус тус гишүүн болсон билээ.

НҮБ дээрх жижиг орнуудын эрх ашигт нийцсэн нэг бодит шийдвэр нь гишүүн 16 орон санаачлан “Жижиг орнуудын бүлэг”-ийг 90-ээд оны эхээр байгуулсан явдал юм. Бүлгийн зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг баримжааг үл харгалзан 10 саяас доош хүн амтай улс орнуудыг багтаасан байдаг. Бүлэг нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж НҮБ-ын гол гол байгууллагын сонгуульд дэлхийн нөлөө бүхий улс орнуудтай өрсөлдөн сонгогдож байсныг дурдах нь зүйтэй.

Монгол Улсад НҮБ хэрэгтэй юу?

Манай улс 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын гишүүн болсон билээ. Угтаа Монгол Улс НҮБ байгуулагдсаны хойтон жил буюу 1946 онд тус байгууллагад элсэх өргөдлөө өгсөн боловч тухай үеийн олон улсын байдал, их гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчлийн уршгаар даруй 15 жилийн дараа ийнхүү бүрэн эрхт гишүүн болсон байдаг. Дээрх 15 жил бол манай улс тусгаар тогтнолоо дэлхий дахинаар хүлээн зөвшөөрүүлэх тэмцлийн он жилүүд байсан юм.

Монгол Улс НҮБ-ын гэр бүлд багтсанаар гадаад харилцаагаа өргөжүүлэх, дэлхийн олон улстай дипломат харилцаа тогтоох таатай, эерэг боломжийг нээсэн. Ардын хувьсгалаар буюу 1921 онд тусгаар тогтнолоо зарласан манай улс 1961 оны 10 дугаар сар буюу дөчин жилийн хугацаанд дэлхийн арван долоохон улстай дипломат харилцаатай, тэдгээр орон бараг бүхэлдээ “социалист” системийн орнууд байсан бол НҮБ-ын гишүүн болсноос хойш арван жилийн дотор гэхэд л 54 улстай дипломат харилцаатай болж гадаад харилцаа хурдацтай өргөжсөн байдаг. Дээрх 54 улс бараг бүхэлдээ барууны өндөр хөгжилтэй, хуучны ойлголтоор “капиталист” ертөнцийн орнууд байсан гэдгийг хэлэх нь зүйтэй.

Өдгөө манай улс идэвхтэй харилцаа, хамтын ажиллагаа явуулж “гуравдагч хөрш”-ийн гэгдэх Япон, Турк, Сингапур, Англи, Франц, Швейцар, Итали, Австри зэрэг олон улс орон угтаа 1961-1971 оны арван жилийн хооронд Монгол Улстай дипломат харилцаа тогтоосон байдаг юм.

Манай улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон цагаас эхлэн олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бататган бэхжүүлэх, харилцаа хамтын ажиллагаа өргөжүүлэн хөгжүүлэх, өөрийн дуу хоолойг дэлхий дахинаа хүргэх талаар идэвх санаачилгатай ажиллаж ирсэн байдаг.

Монгол Улс өөрийн эрх мэдэлгүй, толгойгүй явж ирсэн, зөвхөн ЗХУ-ыг аялдан дагаж, тэдний гар хөл болж байсан гэсэн өнгөрсөн үеийг дүгнэсэн олон янзын шүүмжлэл байдаг. Мэдээж социалист системийн нэг хэсэг болж байсан манай улсын хувьд тухайн үеийн улс төр, нийгмийн тогтолцоогоо хамгаалж, социалист байгуулалтын талд тууштай зогсож байсан нь үнэн. Нөгөөтэйгүүр НҮБ ч хоёр системийн үзэл суртлын талбар, бие биенээ шүүмжлэх, сөргөлдөх “халуун” цэг болж байсан нь тийм

байхыг ч шаардаж байсныг дурдах нь зүйтэй. Гэхдээ Монгол Улс, түүний Засгийн газар дандаа нэг талыг аялдан дагасан, “хэт үзэл сурталжсан”, нэг улсын дохио зангаагаар явж ирсэн гэвэл үнэнд нийцэхгүй ээ.

Бүс нутагт төдийгүй дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдлыг бататгах, нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийг бэхжүүлэх, Монгол Улстай нэгэн адил жижиг, хөгжиж буй орны нийтлэг эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлыг олон улсын хамтын нийгэмлэгт дэвшүүлэн тавьж идэвх санаачилгатай ажиллаж ирснийг түүх гэрчилнэ. Манай улсын санал, санаачилгаар батлуулсан олон арван тогтоол, шийдвэр одоо ч зарим нь ач холбогдлоо алдаагүй, хүчин төгөлдөр хэвээр байж бусдад үлгэр дууриалал болсоор ирсэн.

Монгол Улс, НҮБ-ын харилцаа, хамтын ажиллагааны 60 жилийн түүхэнд манай орон НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар 50 гаруй удаа тогтоол санаачлан батлуулж, 500 гаруй тогтоол, шийдвэрт хамтран зохиогчоор оролцсон байдаг юм. Тухайлбал манай улсын санаачилгаар “Зэвсэг хураах долоо хоногийн тухай”, “Улс түмэн энх тайвнаар орших эрхийн тухай”, “Эдийн засгийн хөгжил ба байгаль орчныг хамгаалах тухай”, “Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах тухай”, “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах тухай”, “Хоршооллын хөдөлгөөнийг дэмжих тухай”, “Бичигтэн болох НҮБ-ын арван жилийн тухай”, “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусын тухай”, “Далайд гарцгүй орнуудын асуудал”, “Олон улсын хэлэлцээ хийх зарчим, чиглэлүүд” зэргийг дурдаж болно.

Социалист систем задран унаж Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990-ээд оны шилжилтийн бэрх үеийг даван туулахад НҮБ-ын туслалцаа, дэмжлэг чухал байсан. Эдийн засаг хямралд ороод байсан хүнд хэцүү үед НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Монголыг дэмжих хандивлагчдын бүлгийг үүсгэн бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн түүнчлэн ДЭМБ, ЮНЕСКО зэрэг НҮБ-ын төрөлжсөн болон системийн байгууллагаас, мөн ОУВС, Дэлхийн банкны зүгээс ардчиллыг бэхжүүлэх, эдийн засгийг сэргээх, хүний эрхийг хамгаалах, ядуурлыг бууруулах зэрэг олон тооны төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн байдаг.

Өнөөдөр манай улс НҮБ-ын хүрээнд ядуурлыг бууруулах, эдийн засгийн хөгжлийг хангах, бичиг үсэг үл мэдэх байдлыг арилгахад тус дөхөм үзүүлэх, далайд гарцгүй орнуудын байдлыг сайжруулах, Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах, шинээр болон сэргээн тогтоосон орнуудын ардчиллыг дэмжих зэргээр идэвхтэй хамтран ажиллаж байна.

Монгол Улс, НҮБ-ын харилцаа, хамтын ажиллагааны дэлхийд нэрийн хуудас болж танигдсан нэг чиглэл нь энхийг сахиулах үйл ажиллагаа билээ. Энхийг сахиулах үйл ажиллагааны тухай хангалттай мэдээлэл олон нийтэд байдаг учраас энд дахин нурших шаардлагагүй юм. Харин энд зайлшгүй дурдах ёстой зүйл бол энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй манай цэрэг дайчид хэдийгээр гадаадад, өөр улсад алба хааж байгаа ч үнэн чанартаа Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалж байгаа эх орончид гэж үзэх учиртай юм. Бид НҮБ зэрэг олон талт хамтын ажиллагааны байгууллагаар өөрийн улсын гадаад аюулгүй байдлаа баталгаажуулахын гол утга учир үүнд оршино.

Шинэ зууны эхэнд НҮБ-ын гишүүн орнуудын хамтын хүчин чармайлтын үр дүнд Мянганы хөгжлийн зорилтуудыг баталж хэрэгжүүлж ирсэн бол 2015 онд хуралдсан Ерөнхий Ассамблейн чуулганаар Тогтвортой хөгжлийн зорилтууд хэмээх түүхэн баримт бичгийг баталсан юм. НҮБ-ын гишүүн 193 улс тогтвортой хөгжлийн төлөөх хөтөч зургаа тохиролцож хүн төрөлхтөн ирэх 15 жилийн турш баримтлан хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй болсон юм.

НҮБ бол Монголын ихээхэн чухал өмөг түшиг. Манай тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын гадаад дахь нэг баталгаа юм. Аливаа улс гүрэнд өөрийн ашиг сонирхол бий бөгөөд гагцхүү тэрхүү ашиг сонирхлынхоо төлөө байдаг. Харин НҮБ-д бол нэг талын ашиг сонирхол гэж үгүй. Харин улс хоорондын эрх ашгийг зохицуулах, бага буурай болоод хөгжиж байгаа оронд туслах үүрэгтэйгээр онцлог. НҮБ-ын байнгын энэ үүргийг сайтар ухамсарлан, ашиглах чадвартай байх нь манайх шиг улс орнуудад нэн чухал билээ.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

НҮБ	- Нэгдсэн Үндэстний Байгууллага
ЗХУ	- Зөвлөлт Холбоот Улс
ОУВС	- Олон Улсын Валютын Сан
ЭҮНХ	- Эвсэлд Үл Нэгдэх Хөдөлгөөн
ДЭМБ	- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЮНЕСКО	-Нэгдсэн Үндэстний Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага



Н.СОЁЛГЭРЭЛ
ҮАБЗ-ийн ССХ-ийн
ОУБНСС-ийн Эрдэм
шинжилгээний ажилтан

АФГАНИСТАНЫ 20 ЖИЛИЙН ДАЙН ДУУССАН НЬ БУЮУ БҮС НУТАГТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАОС ҮҮСЭХ ҮҮ*

Abstract: International experts have different views on the victories, damages and defeats of the Twenty Years' War. Based on these facts, the article discusses in detail why Afghanistan is a country, its geopolitical significance, damages and defeats of the Twenty Years' War, the money spent by the fighting parties, the results achieved, and how the process will develop. It will also review the situation that will arise after the withdrawal of coalition's troops from Afghanistan, the country's ability to maintain its own security, and how to deal with the aforementioned terrorist groups.

Түлхүүр үгс: геополитик, дайн, эвслийн хүчин, талибууд, хохирол, зардал, энхийн гэрээ, терроризм, тэмцэл

Оршил

Исламын хэт даврагч, террорист бүлэглэлүүдтэй өрнүүлсэн хорин жилийн дайныг¹ дуусган АНУ, Их Британи, НАТО-гийн зүгээс ирэх есдүгээр сарын 11 гэхэд Афганистанаас цэрэг, зэвсэг техникээ бүрэн гаргахаар нэгэнт шийдвэрлэсэн. Дайныг эцэслэн, цэргээ гаргах чиглэлд АНУ-ын сүүлийн гурван Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг дамнан үргэлжилж буй үйл явц ийнхүү эцсийн шатандаа орж, Америкийн түүхэн дэх хамгийн урт дайн төгсч байна.

* Тайлбар: Энэхүү өгүүллийг сүүлийн үед өрнөж буй үйл явдлуудаас өмнө буюу 2021 оны тавдугаар сард бичсэн болно.

¹ Тайлбар: Хорин жилийн өмнө буюу 2001 оны есдүгээр сарын 11-ний өдөр дэлхий дахиныг цочроосон, хүн төрөлхтөний эсрэг балмад хэрэг болсон билээ. Энэ өдөр исламын босогчдын “Аль-Каида” бүлэглэлийнхэн АНУ-д дөрвөн террорист халдлага үйлдэж, 3000 орчим хүний аминд хүрч, 6000 гаруй хүн гэмтэж бэртэн, наад зах нь 10 тэрбум ам.долларын эд материалын хохирол учруулсан юм. “Аль-Каида” бүлэглэлийнхнийг орогнуулж байсан “Талибан” бүлэглэлийг дарахын тулд АНУ-ын зүгээс Афганистанд терроризмтэй тэмцэх дайн зарласан билээ. Америкаас гадна олон улс орон терроризмын эсрэг хууль тогтоомжоо чангатгаж, террорист халдлагаас урьдчилан сэргийлэхийн тулд хууль сахиулах болон тагнуулын байгууллагын эрх мэдлийг өргөжүүлсэн.

Энэхүү үйл явдалтай зэрэгцэн Талибан, Аль-Каида болон Исламын улс бүлэглэлүүдийн үйл ажиллагаа Афганистанд улам бүр эрчимжиж байна. Тиймээс эвслийн хүчний цэргүүд тус улсыг орхисны дараа Кабул бие даан улс, үндэстнийхээ аюулгүй, тогтвортой байдлыг хэрхэн хангах бол гэсэн асуудалд дэлхий дахин, бүс нутгийн улсууд ихээхэн анхаарал хандуулж байна. Үүсээд буй энэ нөхцөл байдлын улмаас талууд 2020 оны хоёрдугаар сард АНУ, Талибан хөдөлгөөний хооронд байгуулсан Энхийн хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй. Энэ нь цаашдаа олон улсын харилцаан дахь дайн, зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн бас нэг муу жишгийг тогтоож байна.

Дайны улмаас учирсан хохирол, ялалт, ялагдлын талаар олон улсын шинжээчид олон янзын дүгнэлтийг өөрсдийн өнцгөөс хийж байгаа. Эдгээр баримт материалд үндэслэн өгүүлэлд яагаад Афганистан гэж, геополитикийн ач холбогдол, хорин жилийн дайны учруулсан хохирол, дайтагч талуудын зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүн, үйл явц цаашид хэрхэн өрнөх зэрэг асуудлыг сийрүүлэн авч үзье. Түүнчлэн Эвслийн цэрэг Афганистаныг бүрэн орхисны дараа үүсэх нөхцөл, тус улсын өөрийн арми аюулгүй байдлаа сахин хамгаалах чадвартай эсэх, өмнө дурдсан террорист бүлэглэлүүдтэй цаашид хэрхэн тэмцэх зэрэг асуудлыг олон улсын цэрэг, дайны шинжээчид хэрхэн авч үзэж байгааг тоймлон дүгнэнэ.

Нэг. Афганистаны геополитикийн ач холбогдол

Баруун, Зүүн, Өмнөд, Төв Азийг холбосон Афганистаны газар зүйн байрлал нь түүхийн турш тус улсыг буфер газар нутаг болгож иржээ. Геополитикийн онолд эртнээс далайн гүрний зүгээс эх газрын гүрнийг, эх газрын гүрний зүгээс далайн гүрний хүчийг сулруулахаар эрмэлздэг болохыг тайлбарласан байдаг. Үүний дагуу далайгаас эх газар руу, эх газраас далай тэнгис рүү нэвтэрч, нөлөөгөө тогтоохыг эрмэлзэж байсан² их гүрнүүдийн оролдлого саатахад хүрч байсан нэг цэг бол Афганистан юм. Оросын сонирхол, нөлөө Төв Азийг дайран Афганистанд тулаад, арваад жил дайтаад ч цааш нэвтэрч чадаагүй бол хүйтэн дайны үед мөн АНУ тэнгис талаас нэвтрэхээр зүтгэсэн ч Пакистан хүрээд зогссон байдаг. Орос, Америкаас өмнө бүс нутагт нөлөө бүхий байсан Их Британийн тухайд Энэтхэгээс гарсныхаа дараа Афганистаныг сонирхох сонирхол нь буурсан гэж үздэг. Эдгээр сонирхлыг түүхийн турш Афганистанд болж байсан дайн, мөргөлдөөнүүд гэрчилнэ. (Зураг 1.)

Зураг 1. Афганистанд болсон дайн, мөргөлдөөн (1839-2021)



² “Introduction to Contemporary Geopolitics”, HSE University, <https://www.coursera.org/lecture/contemporary-geopolitics/sea-power-vs-land-power-Elrtq2>

Харин сүүлд 2001 оны есдүгээр сарын 11-нд болсон халдлагын дараа АНУ түүхэндээ анх удаа “heartland” руу орох боломжтой болсон. Үүнийг геополитикчид “09.11-ний бэлэг”³ ч гэж нэрлэдэг.

Хоёр. Афганистаны дайны өрнөл, цэргийн голлох ажиллагаанууд

Америкийн түүхэнд хамгийн урт үргэлжилж, асар их хөрөнгө мөнгө зарцуулсан Афганистаны дайны хорин жилийн түүхийг⁴ цаг хугацааны он дарааллаар сийрүүлэн үзье.

2001 он: Осама Бин Ладен халдлагыг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсний дараа Конгресс нэн даруй 22.9 тэрбум ам.долларын яаралтай тусламжийн хөрөнгийг хуваарилан, улмаар сар хүрэхгүй хугацааны дараа буюу аравдугаар сарын 07-нд АНУ-ын нисэх онгоцууд талибын хүчнийг бөмбөгдөж, нийслэл Кабулаас шахан гаргасан. Хамид Карзай түр захиргааны газрын тэргүүн болж, Бин Ладен 12 дугаар сард нь Пакистан руу оргон зайлсан;

2002 он: Гуравдугаар сард АНУ-ын цэргийнхэн талибуудын эсрэг Анаконда ажиллагааг эхлүүлж, Афганистаныг сэргээн босгохоо амлаж байв;

2003 он: Тавдугаар сард Бушийн захиргаа Афганистанд үндсэн байлдааныг дууссан гэж мэдэгдэв. Энхийг сахиулах үүрэг даалгаврыг НАТО хяналтандаа авсан бөгөөд энэ оргил үед оролцогч 50 орны 130 мянган цэрэг Афганистанд байрлаж байжээ;

2004 он: Афганистанд шинэ Үндсэн хуулийг баталж, аравдугаар сарын 9-нд афганчууд анхны чөлөөт сонгуулиа хийжээ. Хариуд нь Бин Ладен дахин террорист халдлага хийнэ хэмээн сүрдүүлсэн;

2005 он: Тавдугаар сард Афганистаны цэргийн байгууламжуудад тоног төхөөрөмж нийлүүлж, сургалт явуулах болсны хариуд АНУ-ын арми тус улсад байрлах гэрээнд Буш, Карзай нар гарын үсэг зурав;

2006-2008 он: Пакистаны Дамадола хотод явуулсан Америкийн агаарын дайралт Аль-Каидагийн нэг ч бус, эсрэгээрээ 18 энгийн иргэний аминд хүрсэн нь ихээхэн шүүмжлэл дагуулсан. Үүнтэй зэрэгцэн Афганистаны шинэ Засгийн газар төрийн үндсэн үйлчилгээ, тэр дундаа цагдаа, хууль сахиулах үйлчилгээг үзүүлэх чадавхгүй байсан тул тус улсад хүчирхийлэл газар аваад байв;

2009 он: Ерөнхийлөгч Обама үүрэгт ажилдаа орж, 40 гаруй мянган цэргийг Афганистан руу нэмж илгээхээ амлаж байсан ба тэрбээр шинэ командлагчаар дэслэгч генерал Стэнли МакКристалыг томилсон;

2010 он: Афганистаны өмнөд хэсэгт талибуудтай тэмцэхийн тулд НАТО томоохон хүчээ илгээсэн ба улмаар 2014 он гэхэд бүх хамгаалалтыг Афганистаны хүчинд шилжүүлэхээр тохиролцсон. Обама МакКристалыг генерал Дэвид Петреусаар сольсон;

2011 он: Тусгай хүчнийхэн Осама Бин Ладеныг устгасан ба Обама оны эцэс гэхэд 10 мянга; 2012 оны зун гэхэд 23 мянган цэргээ Афганистанаас гаргахаа мэдэгдэв. АНУ, талибаны удирдагчидтай урьдчилсан энхийн хэлэлцээ хийв;

³ “Why September 12 matters so much”, By Lauren Monsen -Sep 9, 2020., <https://share.america.gov/why-september-12-matters-so-much-to-america/>

⁴ “The U.S. War in Afghanistan 1999 – 2021”, <https://www.cfr.org/timeline/us-war-afghanistan>

2012 он: АНУ-ын 70 мянган цэрэг үлдэв. Эдгээрийг 2013 он хүртэл хурдацтай гаргахаар талууд тохиролцов. Гэвч удалгүй талибууд АНУ-тай хийж байсан энхийн хэлэлцээгээ цуцлав;

2013 он: АНУ-ын зэвсэгт хүчин Афганистаны армийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх үүрэг рүү шилжсэн. Талибууд АНУ-тай энхийн хэлэлцээг дахин эхлүүлж, Карзай-АНУ-ын хэлэлцээ зогсоход хүрсэн;

2014 он: Америкийн цэргүүд гарах ажиллагаа идэвхжиж, оны эцэст ердөө 9800 зөвлөх үүрэг бүхий албан хаагчид үлджээ;

2015-2017 он: Америкийн Батлан хамгаалах яам Афганистанд хийх бэлтгэл, цэргийн техник хэрэгсэл болон НАТО-г дэмжих, терроризмийн эсрэг хариу арга хэмжээнд шаардагдах зардлыг Конгрессоос хүсч, шийдүүлж байв;

2017 он: Афганистан дахь Эрх чөлөө ажиллагаа, Исламын улс бүлэглэлийн эсрэг шийдвэрлэх ажиллагаа явуулахад 58.8 тэрбум ам.доллар хүсч байсан;

2018 он: Ширүүн жил байсан ба дайны бусад жилээс илүү их хэмжээний бөмбөг болон бусад тэсрэх бөмбөгийг АНУ хаясан билээ;

2019 он: АНУ-ын цэргийн ажиллагаа ч эрчтэй, талибуудын террорист халдлага үйлдэх нь ч үргэлжилсээр байсан. Ерөнхийлөгч Трамп зуны сүүлээр талибуудтай хийсэн энхийн хэлэлцээг цуцалжээ;

2020 он: Энхийн хэлэлцээ дахин эхэлж, АНУ, талибуудын хооронд хоёрдугаар сард нь Энхийн гэрээ байгуулагдав.

Уг гэрээ зөрчил мөргөлдөөнийг зохицуулах, эвлэрүүлэх чиглэлд байгуулсан олон улсын гэрээ, эрх зүйн түүхэнд олон зүйлээрээ анхаарал татсан баримт бичиг болсон юм. 2020 оны хоёрдугаар сард Афганистанд 19 жил үргэлжилж буй дайныг эцэслэх алхам хийж, Катарын нийслэл Доха хотод АНУ-ын тусгай элч Залмай Халилзад болон талибуудын гол төлөөлөгч Мулла Абдул Гани нар Энхийн хэлэлцээрт гарын үсэг зурсан⁵ билээ. Хэлэлцээр нь Афганистанд энхийг тогтоох анхны чухал алхам болсон хэдий ч Афганистаны засаг захиргаа, мөн олон улсын аюулгүй байдлын зарим шинжээч нар хэлэлцээрийн үр дүнд төдийлөн сэтгэл хангалуун бус байсан. Ашраф Ганийн Засгийн газар болон Пакистаны оролцоог хэлэлцээрт орхигдуулсан хэмээн үзсэн.

Хэлэлцээрийн гол утга санааны тухайд гэвэл Гэрээнд тусгагдсан дөрвөн үндсэн асуудал байсан.⁶ Үүнд:

1.Гал зогсоох. Талууд хүчирхийллийг зогсоохын тулд “байнгын гал зогсоох”-ыг чухал, гэж үзсэн ба энэ нь цааш үргэлжлэх Афганистаны дотоод хэлэлцээний үндэс болно хэмээн тооцоолж байв.

2.Гадны хүчнийг татан буулгах. АНУ, тус улсад байгаа өөрийн цэргийн тоог 135 хоногийн дотор тухайн үед байсан 13 мянга орчмоос 8600 болгож цөөлөхөөр шийдвэрлэсэн. Цаашлаад талибууд хэлэлцээрээр хүлээсэн амлалтаа биелүүлбэл АНУ болон гадаадын бусад цэргүүд Афганистаныг арван дөрвөн сарын дотор бүрмөсөн орхиж гарахаар хэлэлцээрт тусгасан. Мэргэжилтнүүд цэргээ их хурдан гаргах нь Афганистанд

⁵ “U.S.-Taliban peace agreement”, <https://thediplomat.com/tag/u-s-taliban-peace-agreement/>

⁶ Мөн тэнд

тогтворгүй байдал үүсгэж болзошгүйг анхааруулсан учраас ийнхүү нилээд тавиу хугацаа төлөвлөсөн байв.

3.Афганистаны дотоод хэлэлцээ. Талибан, Афганистаны Засгийн газар хоорондын яриа хэлэлцээг 2020 оны гуравдугаар сард эхлэхээр тохирсон. Үүнээс өмнө талибууд Афганы Засгийн газартай шууд яриа хэлэлцээ хийхээс татгалзаж, тэднийг “америкийн гөлөг” гэж дайрч доромжилдог байсан ч байр сууриа өөрчлөөд байсан. Талибаны удирдагчийн орлогч болох Сиражуддин Хаккани “...хэрэв бид гадаад дайсантай тохиролцоонд хүрч чадах юм бол Афганистаны доторх санал зөрөлдөөнийг шийдвэрлэх боломжтой” хэмээн мэдэгдэж байсан.

4.Терроризмын эсрэг баталгаа. АНУ-ын зүгээс тус улсад халдлага үйлдсээр байгаа «Аль-Каида», Исламын улс бүлэглэл болон бусад алан хядах бүлгийн ажиллагааг зогсоохыг зорьж байгаа. Тиймээс ч хэлэлцээрийн нэг тал болох талибуудын зүгээс АНУ, түүний холбоотны аюулгүй байдалд заналхийлсэн аливаа бүлэглэл, хүмүүст Афганистаныг ашиглуулахгүй гэсэн баталгаа өгчээ.


Гэрээг афганчуудын дийлэнх нь дэмжиж байсан ч Афганистаны дотоодын хэлэлцээ эхлэх үед зэвсгийг хураах, нийгэмшүүлэх зэргээр олон асуудлаар талибуудтай тохиролцоход бэрхшээл тулгарсан. Энхийн гэрээ байгуулагдаад удаагүй байхад л Афганистаны Ерөнхийлөгч Ашраф Гани 2020 оны гуравдугаар сарын 1-нд “...энх тайван гэх нэрээр талибын 5000 хоригдлыг суллах боломжгүй. Энэ бол Афганистаны ард иргэдийн төлөө зөвшөөрч болохгүй зүйл”⁷ хэмээн мэдэгдсэн нь үүнийг гэрчилнэ. Тэрбээр, АНУ-ын зүгээс хоригдлуудыг суллахыг зөвшөөрч байгаа боловч эцсийн шийдвэр гаргах эрх нь Кабулд байгаа гэдгийг онцолж байв. Мөн Ерөнхийлөгч Д.Трамп хэлэхдээ “...хэрэв биднийг гарсны дараа цаашдаа асуудал үүсгээд байвал бид дахиад л хүрээд очно”⁸ хэмээн анхааруулж байсан.

Гурав. Хорин жилийн дайн: хүрсэн үр дүн, учруулсан, амссан хохирол

Товчхондоо Осама Бин Ладен болон есдүгээр сарын 11-ний халдлагатай холбоотой Аль-Каида бүлэглэлийнхнийг орогнуулж байсан талибуудыг Афганистанаас зайлуулах зорилгоор АНУ тус улсад 2001 оны 10 дугаар сараас цэргийн ажиллагаа эхлүүлсэн. АНУ өнгөрсөн жилүүдэд явагдсан цэргийн ажиллагаанд нэг их наяд ам.доллар зарцуулж, нийт 2300 цэргээ алджээ. Шинжээчид Афганистаны дайны энэ бүх зардал, хохирлыг нэгэнт тооцож, гаргажээ.


⁷ “Afghan President Ghani rejects Taliban prisoner release under U.S deal”., By Abdul Qadir Sediq, <https://www.reuters.com/article/us-usa-afghanistan-taliban-idUSKBN2001BE>

⁸ “Afghan conflict: Trump hails deal with Taliban to end 18-year war”., <https://www.bbc.com/news/world-asia-51692546>

Зураг 2. Афганистанд байрлаж байсан америк цэргийн тоо (2002-2018)⁹

Зурагт дүрсэлснээс үзвэл, дайны ид үе буюу 2010-2013 онд АНУ тэргүүтэй өрнөдийн хүчний бие бүрэлдэхүүний тоо 100 мянгаас давж байв. Улмаар АНУ, НАТО-гийн цэргийн гол хүч 2014 онд энэ улсаас гарсан бөгөөд зааварлагч, зөвлөх зэргээс бүрдсэн эвслийн хүчний албан хаагчид үлдсэн. Түүнчлэн Афганистанд АНУ-ын хувийн аюулгүй байдлын албаны олон тооны гэрээт ажилчид байдаг. 2020 оны эцсийн байдлаар АНУ-ын 7800 гаруй иргэн байсныг АНУ-ын Конгрессын судалгаа харуулж байна.

Зардлын тухайд америкчууд Афганистаны дайнд 2001-2020 онд нийт 978 тэрбум ам.доллар зарцуулжээ.¹⁰ АНУ-ын албан ёсны тоо баримтаас үзвэл 2010-2012 оны хооронд нэг хэсэг 100 мянга гаруй цэрэгтэй байсан үедээ дайны зардал жилд бараг 100 тэрбум ам.доллар болж өсчээ.

Зураг 3. Афганистанд явуулсан цэргийн ажиллагааны зардал (2001-2019)

⁹ "Afghanistan war: What has the conflict cost the US?", By Reality Check team, <https://www.bbc.com/news/world-47391821>

¹⁰ "Afghanistan War: Cost, Timeline, and Economic Impact", <https://www.thebalance.com/cost-of-afghanistan-war-timeline-economic-impact-4122493>

Харин АНУ-ын зэвсэгт хүчин довтолгооны ажиллагаанаас илүүтэй Афганистаны хүчнийг сурган бэлтгэхэд илүү их анхаарал хандуулах болсон 2015 оноос эхлэн цэргийн тоогоо бууруулсны улмаас зардал огцом буурсан юм. 2018 онд жилийн зардлын хэмжээ ойролцоогоор 45 тэрбум ам.доллар байсан гэж Пентагоны өндөр албан тушаалтан мэдээлж байв.

АНУ-ын Батлан хамгаалах яамны мэдээлснээр Афганистан дахь цэргийн зардлын нийт хэмжээ (2001 оны 10 дугаар сараас 2019 оны есдүгээр сар хүртэл) 778 тэрбум ам.долларт хүрсэн байна. Түүнчлэн АНУ-ын төрийн департамент АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) болон Засгийн газрын бусад байгууллагатай хамт сэргээн босголтын төслүүдэд 44 тэрбум ам.доллар зарцуулсан. Ингээд албан ёсны мэдээлэлд үндэслэн нийт зардлыг 822 тэрбум ам.доллар хэмээн тооцож болох боловч Афганистантай холбоотой үйл ажиллагааны бааз болгон ашигладаг АНУ-ын Пакистанд зарцуулах зардлыг оруулаагүй болно. Харин Афганистан, Пакистан дахь дайны зардлыг судалж үзсэн Браун Их сургуулийн 2019 оны судалгаа АНУ ойролцоогоор 978 тэрбум ам.доллар зарцуулсан болохыг нэгтгэн тооцоолсон байна.

Хэрвээ эдгээр дээр Батлан хамгаалах яам, Ахмадын хэрэг эрхлэх газрын суурь төсвийн нэмэгдлийг нэмж тооцвол зардлын хэмжээ улам өсдөг. Дайн байлдаанд тусгайлан зориулж гаргасан 978 тэрбум ам.доллараас гадна Батлан хамгаалах яамны суурь төсөв 2000 оны хоёрдугаар сараас хойш 343 тэрбум орчим ам.доллараар нэмэгдэж, 2020 оны санхүүгийн жилд 633 тэрбум ам.доллар болсон зэргийг тооцоолох хэрэгтэй.¹¹ Ахмадын хэрэг эрхлэх газрын (VA) төсөв мөн хугацаанд 175 гаруй тэрбум ам.доллараар нэмэгдсэн байна.

Дайны зардал, цэргийн тоог он, дарааллаар задлан харвал¹²:

Санхүүгийн жил	Зарцуулсан төсөв	Цэргийн тоо
2001	\$23 тэрбум	9,700
2002	\$23 тэрбум	9,700
2003	\$17 тэрбум	13,100
2004	\$15 тэрбум	18,300
2005	\$21 тэрбум	17,821
2006	\$19 тэрбум	20,502
2007	\$31 тэрбум	24,780
2008	\$39 тэрбум	32,500
2009	\$56 тэрбум	69,000
2010	\$94 тэрбум	96,900
2011	\$107 тэрбум	94,100
2012	\$101 тэрбум	65,800
2013	\$86 тэрбум	43,300
2014	\$77 тэрбум	10,600
2015	\$58 тэрбум	8,930
2016	\$50 тэрбум	9,200

¹¹ "Counting the costs of America's 20-year war in Afghanistan", <https://apnews.com/article/asia-pacific-afghanistan-middle-east-business-5e850e5149ea0a3907cac2f282878dd5>

¹² "Afghanistan War: Cost, Timeline, and Economic Impact", <https://www.thebalance.com/cost-of-afghanistan-war-time-line-economic-impact-4122493>

Санхүүгийн жил	Зарцуулсан төсөв	Цэргийн тоо
2017 ¹	\$54 тэрбум	тодорхойгүй
2018	\$52 тэрбум	тодорхойгүй
2019	\$52 тэрбум	тодорхойгүй

Жич: Эвслийн нийт хүчний тухайд бус дан ганц АНУ-ын зарцуулсан зардал, цэргийн тоо болно.

Дайны шинжээчдийн тайлбарлаж буйгаар, дайн мөргөлдөөнд тухайн үед амссан хохирол, зарцуулсан шууд зардлаас гадна дайны дараа тохиолдох эрсдэл, зардал ч бас багагүй анхаарал татсан асуудал байдгийг¹³ онцолж байна. Дайны ахмад дайчдыг халамжлах зардал нь дайн эцэслэсний дараах 3-4 жилийн хугацаанд ихэвчлэн дээд цэгтээ хүрдэг аж. Энэ удаагийн тохиолдол болох Афганистаны дайны ахмад дайчдын эрүүл мэндийн болон тахир дутуугийн төлбөрийн зардал ирэх 40 жилийн хугацаанд нэг их наяд гаруй ам.доллар болно хэмээн таамаглаж байна. Таамгийг тодорхой тоо баримтууд дээр үндэслэн хийжээ. Тодруулбал, тархины гэмтлийг Ирак, Афганистаны ахмад дайчдын «нэрийн хуудас» гэж нэрлэдэг бөгөөд 2000 оноос хойш бараг 350 мянган ахмад дайчин ийнхүү оношлогджээ. Судалгаагаар өдөрт дунджаар 20 ахмад дайчид амиа хорлодгийг тогтоосон тул ахмад дайчдын амиа хорлолтыг дайны улмаас амсах томоохон хохирол гэж үзэж байна.

Дайны дараах эдийн засгийн зардлын асуудал ч бас сонирхол татна. Өмнөх дайнуудаас ялгаатай нь ихэнх америк гэр бүл Афганистаны дайны нөлөөг мэдэрдэггүй байжээ. Цэрэг татлагад хамрагдаагүй ч дайны хөлс төлөхөд шууд татвар ногдуулдаггүй байв. Гэсэн хэдий ч эдийн засгийн зардал өндөр байгаа юм. Ойрх Дорнодод болсон дайны хөлсийг төлөхийн тулд гэхэд л АНУ-д 453 тэрбум ам.долларын өрийн хүү нэмж тооцсоныг судлаач Райан Эдвардс тооцоолжээ. Харин Афганистан дахь дайн нь Дэлхийн II дайны үед зарцуулсан 4.1 их наяд ам.долларын (инфляцийг тооцоолсон) зарцуулалтын дараа хоёрдугаарт бичигдэж байна. Ирэх 40 жилийн хугацаанд энэхүү зарлага нь улсын өрийг 7.9 их наяд ам.доллараар өсгөх төлөвтэй байгаа аж. Компанид ажиллагсад, ялангуяа жижиг бизнес эрхлэгчдийг Үндэсний гварди, цэргийн нөөцөд татах байдлаар үйл ажиллагааг нь зогсоож байсан. Тэдний хэсэг болох амь үрэгдсэн, шархадсан, сэтгэлзүйн хувьд цочролд орсон иргэдийнх нь эдийн засагт оруулах байсан хувь нэмрийг одоогоор сайтар тооцоолоогүй байгаа ч учирсан хохирол нь ирэх хэдэн арван жилд мэдрэгдэх бололтой.

Дөрөв. АНУ, Эвслийн хүчнийхний Афганистаныг орхих үйл явц, Афганистаны цэрэг, батлан хамгаалахын чадавч

АНУ болон эвслийн хүчнийхэн цэргийн албан хаагчдаа 2021 оны тавдугаар сарын 1-нээс албан ёсоор татаж эхэлсэнтэй зэрэгцэн Талибан болон бусад бүлэглэлийн зүгээс халдлага, дайралт зохион байгуулах нь идэвхжлээ. Хэдийгээр нутаг буцахаа хүлээж буй АНУ, НАТО-гийн цөөн хэдэн цэрэг байрлаж буй бааз болон Кандахар дахь АНУ-ын цэргийн бааз руу пуужингийн дайралт хийсэн нь бүтэлгүйтсэн ч тэд америк цэргүүдийг зүгээр явуулахгүй, Афганистанаас гаран гартал нь элдэв аргаар саатуулах төлөвтэй байгаа нь ажиглагдаж байна. Энэ 2021 он гарсаар Афганистанд хорь гаруй удаагийн

¹³ “Cost of war”, <https://watson.brown.edu/costsofwar/costs/economic/budget/veterans>

том жижиг халдлага болж, 258 хүний аминд хүрчээ.¹⁴ Эдгээр террорист ажиллагааны заримынх нь хариуцлагыг талибууд хүлээж байгаа тул өмнө дурдсан гал зогсоох Энхийн хэлэлцээрийг одоо нэгэнт бүрэн цуцлагдсанд тооцож болно. Хэлэлцээрээс хойш Талибан бүлэглэл өөрсдөө гал зогсоолгүй, үйл ажиллагаагаа үргэлжлүүлсээр ирсэн хэрнээ 2020 оны тавдугаар сарын 1-ний өдөр гэхэд бүх цэргээ татсан байна хэмээсэн гэрээний заалтаа зөрчсөн хэмээн АНУ-ыг буруутгаж байгаа юм.

Улмаар Афганистан дахь исламын хэт даврагч, зэвсэгт бүлэглэлүүд есдүгээр сарын 11-нийх шиг халдлагыг зохион байгуулахаар төлөвлөж байж болзошгүй хэмээн Өрнөдийн тагнуулын албаныхан таамаглаж байна. АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байдены товлосон есдүгээр сарын 11-ний өдөр ойртох тусам нөхцөл байдал улам бүр муудаж болзошгүй гэж түгшиж байгаа ба Их Британийн Батлан хамгаалах штабын дарга, генерал Сэр Ник Картер «Энэ бол бидний найдаж байсан үр дүн биш байсан» хэмээн мэдэгджээ. Одоо Афганистаны ирээдүйг бүрэн дүүрэн тодорхойлоход эрт байгаа ба сүүлийн 20 жилийн хугацаанд терроризмтой тэмцэх чиглэлд олж авсан ололтуудыг үгүй хийж мэдэхээр байна.

Ерөнхийлөгч Байденд Афганистанаас цэргээ гаргах төлөвлөгөө эртнээс байсан. Тэрээр 2009, 2011 онд Обамагийн засаг захиргааны Дэд Ерөнхийлөгчийн хувиар тус улсад айлчилсан. Энэ үед тэрээр Афганы бүтээн байгуулалтад хэтэрхий их цаг, хөрөнгө мөнгө зарцуулж байхындаа оронд терроризмын эсрэг агаарын довтолгоо, исламын хэт даврагч зэвсэгт бүлэглэлүүдийн тусгай хүчний дайралттай тэмцэх тал дээр анхаарлаа хандуулах ёстой хэмээн мэдэгдэж байсан. Үүнтэй нь Пентагон санал зөрж, АНУ-ын Батлан хамгаалахын нарийн бичгийн дарга асан Роберт Гейтс дурсамж номондоо Байденыг «Сүүлийн хориод жилийн хугацаанд Америкийн засаг захиргааны хэрэгжүүлсэн гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын бүхий л чухал асуудалд буруу хандсан явдал»¹⁵ гэж тодорхойлсон байдаг.

Нэг талаас Афганистан дахь нөхцөл байдал сайнгүй байгаа, нөгөө талаас Америкийн цэргүүдийн тус улсыг орхихтой холбоотой зарим асуудал шийдэгдээгүй хэвээр байгаа ч есдүгээр сарын 11 гэсэн тогтсон хугацаанаас өмнө цэрэг, техникээ гаргахаар Ерөнхийлөгч Байден шийдвэрлэсэн.

Харин цаашид хорин жилийн дайны түүхэнд оргил үедээ АНУ-ын дангаараа 100 мянга, эвслийн хүчнийхтэй нийлээд 150 мянга гаруй цэрэг тус улсад байрлаж, Афганистаны армитай хавсран энхийг тогтоон, аюулгүй байдлыг сахиулж байсан бол цаашид яах вэ гэсэн асуудал зайлшгүй гарч байна.

Талибуудын тоо хэдэн арван мянгаар хэмжигддэг ба одоо энэ бүлэглэл сүүлийн 19 жилийнхээс ч илүү хүчтэй болжээ. 55-85 мянга хүртэлх байнгын байлдагчтай тооцогдож байна. Энэ оны эхний байдлаар тэд нийт нутаг дэвсгэрийн 19 орчим хувийг хяналтанд авсан бол Засгийн газрын цэргүүд 33 хувийг нь хянаж байна. Энэ бол Афганистаны Засгийн газрыг хүндхэн нөхцөлд үлдээн, эвслийн цэрэг тус улсаас гарч байгаа хэрэг юм.

Афганистаны армийн одоогийн зохион байгуулалт 2002 оны 12 дугаар сараас эхтэй ба газрын дайн явуулах зориулалттай аж. Өнөөгийн байдлаар 180 мянга орчим цэрэгтэйд тооцогдож байна. Дэлхийн улсуудын батлан хамгаалах чадавхыг үнэлдэг

¹⁴ “2021 Afghanistan attacks”, <https://tolonews.com/afghanistan-172073>

¹⁵ “Duty: Memoirs of a Secretary at War” Robert Gates, 2015.

Global fire power агентлагийн тайланд 2021 онд Афганистан нь 140 улсаас 75-д эрэмбэлэгджээ. Цэргийн тоогоороо гэхэд л 31 дүгээрт орсон байна.¹⁶ Мэдээж тайланд дурдсан олон улсын дундажтай харьцуулахад эдгээр нь тийм ч чамлахаар үзүүлэлт биш боловч нөхцөл байдалтай нь харьцуулбал санаа зовох асуудал юм хэмээн шинжээчид тайлбарлаж байна. Олон жилийн партизаны дайны туршлага бүхий талибууд нь үл тоож болох дайсан биш билээ.

Тав. Бүс нутагт үүсэх аюулгүй байдлын хаос, өрнөдийнхний шинэ стратеги

Ийнхүү 2021 оны намар гэхэд АНУ, НАТО тэргүүтэй эвслийн хүчнийхэн Афганистанаас цэргээ бүрэн гаргасан байх нь нэгэнт тодорхой болсон ба үүнээс цааш хэрхэх вэ гэдэгт шинжээчид анхаарал хандуулж байна. Эвслийн хүчнийхэн ч терроризмтэй тэмцэх тэмцлээ цаашид үргэлжлүүлнэ гэдгээ мэдэгдсэн. Харин энэ тэмцэл хэрхэн өрнөх тухайд дараах таамгийг дэвшүүлцгээж байна.¹⁷ Үүнд:

Дроноор цохилт өгөх. Өмнө нь Афганистантай хил залгаа Пакистаны алслагдсан, овог аймгууд болон Аль-Каида бүлэглэлийн удирдагч нар нуугдаж байсан Йеменийн газар нутагт дроны дайралтуудаар хүчтэй цохилт өгч байсан нь улс биш тоглогчид болох исламын хэт даврагч бүлэглэлүүдийн үйл ажиллагаанд тухай бүр тодорхой нөлөө үзүүлж байсныг өрнөдийн тагнуулын албаныхан мэдэгдэж байна. Дроны дайралтаас зугатахын тулд нуугдаж буй бүлэглэлийн толгойлогч нар нэг газартаа хоёроос илүү хонохгүй, байнгын хөдөлгөөнтэй байсан ч үл үзэгдэх байг харвах Hellfire пуужингаас¹⁸ зугтаж чадаагүй юм. Гэхдээ ийм төрлийн төхөөрөмжийн тухайд нэг том асуудал байдаг нь нисгэгчгүй онгоцны цохилт нь тухайн газар орны энгийн иргэдийн хувьд ихээхэн эрсдэлтэй хэмээн үнэлэгддэг явдал юм. Ирак, Сирид барьцаалагдсан энгийн иргэд хохирсон тохиолдлууд гарч байжээ. Тиймээс Исламын улс бүлэглэлийн нэг удирдагч “Жихади Жон” нэрээр алдаршсан Мохаммед Эмвазиг дээрх төрлийн төхөөрөмжөөр устгахаар оролдсон хэд хэдэн дайралтаа америкчууд энгийн иргэд өртөхөөс сэргийлж зогсоож байжээ. Түүнчлэн Йемений хүний эрхийн төлөө тэмцэгчид энгийн иргэдийн цугларалтыг зэвсэгт босогчид гэж андуурч нисгэгчгүй нисэх онгоц дайралт хийсэн хэмээн шүүмжилдэг.

Тагнуулын сүлжээг ашиглах. Хорин жил үргэлжилсэн дайны турш АНУ-ын ТТГ, Английн MI6 болон эвслийн хүчнийхний бусад тагнуулын байгууллагууд Афганистаны Аюулгүй байдлын агентлагтай (NDS) нягт хамтран ажиллаж болзошгүй аюул заналыг илрүүлэн, урьдчилан сэргийлж ирсэн. Тиймээс энэ хамтын ажиллагааг цаашид илүү өргөн хүрээнд үргэлжүүлэх нь терроризмтэй тэмцэх гол суваг хэмээн харж байна. Гэхдээ энд нэг асуудал байна. Талибанчууд хэрвээ Афганистаны засгийн эрхэнд гарвал өрнөдийнхөн тэдэнтэй бүхий л мэдээллээ хуваалцан ажиллаж чадах болов уу, үүнд бэлэн эсэхийг төсөөлөхөд маш хэцүү байгааг шинжээчид хүлээн зөвшөөрч байна.

Өмнө дурдсан 2020 оны хоёрдугаар сард Доход байгуулсан Энхийн хэлэлцээрээр¹⁹ Аль-Каидагаас харилцаагаа тасална гэж хүлээсэн үүргээ талибууд биелүүлэх эсэх нь тун

¹⁶ “2021 Afghanistan Military Strength”, https://www.globalfirepower.com/country-military-strength-detail.php?country_id=afghanistan

¹⁷ “Afghanistan War: How can the West fight terrorism after leaving?”, <https://www.bbc.com/news/world-asia-56860781>

¹⁸ Тайлбар: “Hellfire” нь лазер чиглүүлэгчтэй, нисдэг тэрэг болон нисгэгчгүй онгоцонд суурилуулан харвах боломжтой пуужин юм.

¹⁹ 2020 оны хоёрдугаар сарын 29-нд Катарын нийслэл Доход АНУ, Талибууд хооронд байгуулсан түүхэн гэгдэх Энхийн хэлэлцээрээр талууд харилцан үүрэг хүлээсэн.

эргэлзээтэй байна. Учир нь есдүгээр сарын 11-ний халдлагаас ч өмнө эдгээр бүлэглэл хоорондоо гэр бүл, омгийн харилцаатай байсан. Хэдийгээр талибууд Афганистаны Засгийн газрын бүрэлдэхүүнд багтахын тулд олон улсад хориглосон террорист бүлэглэлүүдтэй төдийлөн “найзлахгүй” байж болох ч Британийн Eden Intelligence судалгааны төвийн захирал Гэвин Макничалл тэдэнд итгэх нь гэнэн хэрэг хэмээн анхааруулж байна.

Тусгай хүчний дайралт. Тагнуулын мэдээнд үндэслэн Англи, Америкийн Тусгай хүчний цомхон багуудын явуулсан шөнийн дайралтууд террорист бүлэглэлүүдийн сүлжээнд тухай бүр асар их хохирол учруулж байсан. Шөнийн цагаар нисдэг тэргээр болон явган эргүүл хийдэг эвслийн тусгай хүчний ангиуд Афганистаны тусгай хүчнийхэнтэй нягт хамтран ажиллаж, олон удаагийн халдлагаас урьдчилан сэргийлсэн. Харин есдүгээр сараас хойш ийм төрлийн дайралтуудыг хэрэгжүүлэхийн тулд зайнаас төлөвлөх шаардлагатай болох тул хугацаа хоцрох, эрт сэрэмжлүүлэх арга хэмжээ сулрах эрсдэл нэмэгдэхийг анхаарах нь зүйтэй аж.

Шинэ түшиц газрын эрэлд. Эвслийн цэргүүд Афганистанаас бүрэн гарснаар тус улсын зүүн хэсэгт орших бүс нутгийн хэмжээнд дайсны онц чухал бай, объектуудыг устгах ажиллагаанд АНУ-ын тусгай хүчнийхэн түшиц болгон ашиглаж байсан нууц бааз хаагдаж байгаа юм (зурагт заасан газар нь энэхүү Чапман бааз байрладаг Хост муж юм). Энэ нь Аль-Кайда, Исламын улс бүлэглэлийн тухайд сайн мэдээ байх болно. Харин терроризмийн эсрэг цаашдын тэмцэлдээ АНУ энэхүү бүс нутгийн хаанаас тохирох өөр газрыг олж авах нь тодорхойгүй байна.



Пакистан бол газарзүйн хувьд хамгийн тод нэр дэвшигч боловч Пакистаны албад зэвсэгт исламист бүлэглэлүүдтэй холбоотой гэсэн хардлага бий. Тиймээс Пакистаныг Оман орлох магадлалтай гэж үзэж байна.

Өрнөдийнхний түнш болох тогтвортой засгийн газар бүхий Оманы Энэтхэгийн далайн эрэг дээрх Дукм хотод Их Британи гэхэд л томоохон баазуудтай болсон. Гэхдээ Дукм нь Афганистаны хилээс 1600 км зайд оршдог тул цэргийн нисэх онгоцууд нь мөн л Пакистан дээгүүр нисэх шаардлагатай хэвээр байх болно. Дараагийн нэг боломж бол Бахрейн бөгөөд Их Британийн HMS Juffair хэмээх жижиг хэмжээний тэнгисийн цэргийн бааз, АНУ-ын маш том нөөц бүхий тэнгисийн цэргийн V флот тэнд байрладаг юм.

Афганистаны хойд талаар хил залгах Төв Азийн улсуудыг мөн энд мартаж болохгүй. Өмнө нь 2001 оны есдүгээр сарын 11-ний халдлагын дараах эхний жилүүдэд АНУ-ын цэргүүд Узбекистаны зүүн өмнөд хэсэгт байрлах Карши-Ханабад буюу K2 гэж нэрлэгддэг Зөвлөлтийн хуучин баазыг ашиглаж байсан. Гэвч 2005 онд Узбекистаны Андижанд болсон хүний эрхийг зөрчсөн үйл явдлын улмаас талуудын харилцаа муудсаны дараа Америк энэхүү баазыг ашиглахаа больсон бөгөөд энэ газар химийн бодис, цацраг идэвхт

бодисоор маш их бохирдсон гэсэн мэдээлэл гарч байсан тул дахин энд буцаж ирэх нь маргаантай юм.

Энэ мэт эвслийн хүчнийхний зүгээс исламын хэт даврагч, зэвсэгт бүлэглэлүүдийн эсрэг тэмцлээ үргэлжлүүлэхийн тулд түшиц болох газар орныг эрэлхийлж байгаа ч бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангахад Афганистаны одоогийн Засгийн газрын хийх үр дүнтэй тэмцэл нэн тэргүүнд хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн олон улс, шинжээчид санал нэгтэй байна.

Дүгнэлт

Афганистанд цагийн байдал тогтворгүй хэвээр байгаа ба үүсээд буй энэ нөхцөл байдал нь 2020 онд АНУ, Талибан хөдөлгөөний хооронд байгуулсан Энхийн хэлэлцээрийн хэрэгжилтийг үгүй хийж байна. Энэ нь цаашдаа олон улсын харилцаан дахь дайн, зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийн нэг муу жишгийг тогтоож байна.

Америкийн шийдвэрийг даган эвслийн хүчнийхэн ч мөн цэргээ бүрэн гаргаж байгаа нь Афганистанд хэсэгтээ аюулгүй байдлын ХАОС үүсэхээр байгааг харуулж байна. Гэхдээ мэдээж энэ бол нэг улсын асуудал бус бүс нутгийн, цаашлаад бүс нутагтай хил залгаа улсуудын аюулгүй байдалд нөлөөлөх асуудал тул юун түрүүнд манай хоёр хөрш болох ОХУ, БНХАУ зүгээр хараад суухгүй болов уу. Афганистанд тогтвортой байдлыг бэхжүүлэхэд оролцох сонирхолтойгоо ч тэд илэрхийлдэг. Хятадын баруун бүсийн аюулгүй байдал, эдийн засгийн сонирхол, ОХУ-ын нөлөөний, аюулгүйн бүс дэх оролцоо зэргийг энд дурдаж болно. Харин АНУ, НАТО-гийн хүчнийхний зүгээс цэргээ гаргасан ч орчин үеийн цэргийн зэвсэг, техникийн өндөр технологийг ашиглан Афганистан, бүс нутгийн зэвсэгт бүлэглэлүүдтэй тэмцэх ажиллагаагаа үргэлжлүүлэхээ мэдэгдээд буй. Бүс нутгийн улсуудтай цэрэг, батлан хамгаалахын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр эрэлхийлж, шинэ түшиц газартай болохоор зорих нь дамжиггүй.

Хориод жилийн турш үргэлжилж буй Афганистаны дайнд АНУ, НАТО-гийн эвсэл үү?, эсвэл талибууд ялсан уу? гэдэг асуулт одоо хариулт байхгүй хэвээр байгаа. Тиймдээ ч олон улсын шинжээчид Афганы хэрэг явдлыг хүчээр бус, улс төр-дипломатын аргаар зохицуулах нь зүйтэй гэдэг дээр санал нэгддэг. Дайтагч талууд ч үүнийг зөвшөөрдөг.

-
1. “Introduction to Contemporary Geopolitics”, HSE University, <https://www.coursera.org/lecture/contemporary-geopolitics/sea-power-vs-land-power-Eltq2>
 2. “Why September 12 matters so much”, By Lauren Monsen -Sep 9, 2020., <https://share.america.gov/why-september-12-matters-so-much-to-america/>
 3. “The U.S. War in Afghanistan 1999 – 2021”, <https://www.cfr.org/timeline/us-war-afghanistan>

4. “U.S.-Taliban peace agreement”, <https://thediplomat.com/tag/u-s-taliban-peace-agreement/>
5. “Afghan President Ghani rejects Taliban prisoner release under U.S deal”. By Abdul Qadir Sediq, <https://www.reuters.com/article/us-usa-afghanistan-taliban-idUSKBN2001BE>
6. “Afghan conflict: Trump hails deal with Taliban to end 18-year war”. <https://www.bbc.com/news/world-asia-51692546>
7. “Afghanistan war: What has the conflict cost the US?”. By Reality Check team, <https://www.bbc.com/news/world-47391821>
8. “Afghanistan War: Cost, Timeline, and Economic Impact”. <https://www.thebalance.com/cost-of-afghanistan-war-timeline-economic-impact-4122493>
9. “Counting the costs of America’s 20-year war in Afghanistan”. <https://apnews.com/article/asia-pacific-afghanistan-middle-east-business-5e850e5149ea0a3907cac2f282878dd5>
10. “Cost of war”. <https://watson.brown.edu/costsofwar/costs/economic/budget/veterans>
11. “2021 Afghanistan attacks”. <https://tolonews.com/afghanistan-172073>
12. “Duty: Memoirs of a Secretary at War” Robert Gates, 2015.
13. “2021 Afghanistan Military Strength”. https://www.globalfirepower.com/country-military-strength-detail.php?country_id=afghanistan
14. “Afghanistan War: How can the West fight terrorism after leaving?”. <https://www.bbc.com/news/world-asia-56860781>



П.БАТЖАРГАЛ
 ҮАБЗ-ийн ССХ-ийн
 ОУБНСС-ийн Эрдэм
 шинжилгээний ажилтан

ТӨВ АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Abstract: Central Asian region, becoming a key region in the Eurasian spatial coordinate system and the geopolitical crossroads of the world's great powers. Its security is critical to the stability and economic development of neighboring countries and the world. Territorial disputes in Central Asia, competition for water and energy resources, and the current situation in Afghanistan are threatening regional security, but there will be no significant change in the near future, and the political situation is predictable.

For Mongolia, the stability of the Central Asian region is critical to security, and there are currently no direct negative factors. From an economic point of view, it is still important for the development of the western region, although it does not reach the level of Northeast Asia.

Keywords: regional security, territorial disputes, stability, post-Soviet countries, Central Asia

Оршил

Төв Ази нь баруун талаасаа Каспийн тэнгис, зүүн талаасаа төв Хятад, хойд талаасаа Оросын өмнөд хэсэг, өмнө талаасаа Энэтхэгийн умард хэсгээр хязгаарлагддаг Азийн бүс нутаг юм. Үүнд хуучин ЗХУ-ын таван орон буюу Казахстан, Кыргыз, Тажикистан, Туркменистан, Узбекистан түүнчлэн Афганистан төдийгүй Иран, Хятад, Монгол, Пакистан, Энэтхэгийн зарим нутаг, Сибирийн баруун өмнөд хэсэг багтана¹ гэсэн нь газар зүй, геополитикийн² талаас хийгдсэн илүү оновчтой тодорхойлолт хэмээн судлаачид үздэг байна.

1991 онд ЗХУ задран унаснаар Төв Азийн бүс нутагт тусгаар тогтносон улс бий болж Евразийн орон зайн координатын системд гол байр суурь эзэлдэг бүс нутаг болон

¹ <https://www.imemo.ru/files/File/ru/publ/2013/13002.pdf> Вызовы безопасности в Центральной Азии

² https://ru.wikipedia.org/wiki/История_Центральной_Азии

хувирч улмаар дэлхийн хүчирхэг гүрнүүдийн геополитикийн огтлолцолын төв болж байна.

Төв Ази нь газрын тос, байгалийн хийгээр Ойрх Дорнодын дараа орох ихээхэн баялаг нөөцтэйд тооцогддог бүс нутаг учир ЗХУ задарсны дараа дэлхийн нөлөө бүхий орнуудын ашиг сонирхол давхцаж өөр өөрсдийн онцлогтой “Зөөлөн хүчний бодлого” явуулах болсон. ОХУ-ын хувьд олон жилийн уламжлалт, олон талт харилцаандаа түшиглэж байгаа бол Турк улс бүс нутгийн хүн амын түрэг гарлыг ашиглахыг эрмэлзэж, Хятад өсөн нэмэгдэж буй эдийн засгийн чадавхаараа түрий барьж, АНУ геостратегийн ашиг сонирхлоороо тус тус Төв Азийн бүс нутагт нөлөөгөө тогтоохын төлөө өрсөлдөж байна.

Нэгэн үе Москвагийн Өрнөдийн бүрэлдэхүүн хэсэг болох гэсэн санаархалтай холбоотойгоор Төв Ази нь ОХУ-ын гадаад бодлогын хувьд орхигдсон бүс нутаг байсан хэдий ч сүүлийн 10 гаруй жилийн туршид байр сууриа сэргээж бэхжүүлэх бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж Хятадтай тэнцэх хэмжээний түвшинд барихыг эрмэлзэж байна. ОХУ-ын хувьд Төв Азийн бүс нутаг эдийн засгийн талаасаа хямд ажиллах хүчний нөөц төдийгүй том зах зээл юм. Бүс нутгийн иргэд барууны соёлтой оросоор дамжин танилцсан, Казахстан, Кыргызийн зарим томоохон хотын хүн амын дийлэнх нь, Узбекистан, Тажикистан, Туркменстанд цөөнгүй тооны орос хэлтэн иргэд байдаг гэдгээрээ бүс нутагт оросын нөлөө хүчтэй хэвээр байна. Орос руу чиглэсэн хөдөлмөрийн цагаачлал, оросын их, дээд сургуулиудад боловсрол эзэмших гэсэн эрмэлзэл зэргээс үүдэн орос хэлний ач холбогдол хэвээр хадгалагдсаар байгаа нь Москвагийн хувьд маш том давуу тал юм. Цэрэг-улс төрийн хүрээнд ОХУ-аас Төв Азид явуулж буй бодлого нь юуны өмнө гуравдагч орны цэргийн оролцоог багасгах үүднээс бүс нутгийн хамтын аюулгүй байдлын системийг Москвад түшиглэн байгуулах, одоо байгаа цэргийн объектуудын статусыг хэвээр хадгалахад чиглэж байна. Үүний нэг нотолгоо нь АНУ-ын цэргийг Афганистанаас гарах үйл явцыг анхааралтай ажиглаж, Төв Азийн орнуудад цэрэг үлдээхгүй байхыг анхааруулахын зэрэгцээ бүс нутгийн орнуудтай цэргийн хамтарсан хээрийн сургуулийг эрчимтэй явуулахаар төлөвлөж байна.

БНХАУ-ын эдийн засгийн хурдацтай өсөлт Төв Азийн бүс нутгийн байгалийн баялаг, эрчим хүчний нөөцийг ашиглах шаардлагыг аяндаа үүсгэж байгаагаас гадна хятадын бүтээгдэхүүнийг борлуулах том зах зээл, Европ руу гарах транзит тээврийн гол маршрут юм. Гэвч бүс нутгийн ард иргэдийн хятадаас болгоомжлох үзэл санаа ямар нэгэн хэмжээгээр саад тотгор болж байгаа тул Бээжингийн зүгээс соёлын болон хүмүүнлэгийн арга замаар өөрийгөө таниулахыг хичээж байна.

АНУ-ын хувьд юуны түрүүнд Төв Азийн бүс нутгийн орнуудын боловсролын зах зээлийг эзлэх замаар хүүхэд, залуучуудаар дамжуулан нөлөөгөө нэмэгдүүлэх хэтийн бодлого баримталж байна гэж болно. АНУ, Казахстаны Алма-Ата хотод Казак-Америкийн, Кыргызийн Бишкек хотод Төв Азийн Америкийн их сургуулийг тус тус нээж ирээдүйн америкт талтай элитүүдийг бэлтгэж байна. Үүнээс гадна бүс нутгийн хэмжээнд Вашингтоны дэмжлэгтэй олон тооны сан ажиллаж байгаа ажээ. Гэвч газар нутгийн алслагдмал байдал, ОХУ, БНХАУ-ын газар зүйн байрлалын давуу тал АНУ-ын шууд нөлөөг хязгаарлаж байна гэж болно.

Ийнхүү дэлхийн нөлөө бүхий орнуудын Төв Азийн бүс нутгийг чиглэсэн, өөрсдийн өнцгөөс хандсан ашиг сонирхол нэмэгдэж, давхцахын хэрээр Еврази, Ойрх Дорнодын

бүс нутгийн дунд аюулгүй байдлын буфер болж ирсэн энэ бүс нутаг өөрийн онцлогтой аюулгүй байдлын олон сорилттой тулгарсан хэвээр байна.

Төв Азийн аюулгүй байдлын зарим сорилтууд

Төв Азийн бүс нутгийн аюулгүй байдалд цаашид сөргөөр нөлөөлж тогтворгүй байдал үүсгэж болзошгүй гол аюул, заналхийлэлд газар нутгийн маргаан, хар тамхины наймаа, шашны экстремизм, эрчим хүчний хомсдол, үндэстэн хоорондын болон дотоодын зөрчил зэрэг хүчин зүйлийг тооцож болно. Эдгээрээс хөрш зэргэлдээ бүс нутгийн улс орнууд, улмаар дэлхий дахины тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хамгийн эрсдэл өндөртэй зарим сорилтыг авч үзье.

Нэгдүгээрт, Төв Азийн орнуудын хил хязгаар, газар нутгийн маргаан бүрэн шийдвэрлэгдээгүй, цаашид удаан хугацаанд орших хандлагатай байгаа нь нэгэн том сорилт болж байна. Үүнийг бүс нутгийн таван орон олон жилийн туршид хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд улс төр, нийгэм, эдийн засгийн нэгдмэл системд байсантай холбон тайлбарлаж болох юм. Одоогийн Төв Азийн улсуудын хилийг хуучин ЗХУ-ын удирдлагууд 1920-иод оны дундуур хиймлээр тогтоосон учир нийтээр хүлээн зөвшөөрч нарийн тогтоосон хил хязгаар үндсэндээ байгаагүй, угсаатны отог овог холимог (*үндэстнээр ялгасан хил хязгааргүй*) болсон зэрэг нь ЗХУ-ын задарсны дараа шинээр тусгаар тогтносон орнууд, түүний дотор Узбекистан, Кыргыз, Тажикистан улс хоорондын газар нутгийн маргаан, үндэстэн хоорондын зөрчлийн шалтгаан болсоор байна. Тухайлбал, Узбекийн 40-50 мянган иргэн амьдардаг Сох, Шахимардан гэдэг хоёр суурин болон 20 гаруй мянган тажик иргэн амьдардаг Ворух суурин (*Тажикистаны Согди мужийн харьяа*) Кыргызд байдаг бол кыргызийн 600 орчим иргэн амьдардаг Барак тосгон Узбекийн нутаг дэвсгэрт оршдог. Харьяат улсын гол нутаг дэвсгэрээс тасарсан угсаатны томоохон бүлгүүд ийнхүү хөрш орны нутагт суурьшин амьдрахдаа улсын хил нэвтрэхээс эхлээд эдийн засаг, нийгмийн харилцаатай холбоотой олон хурц асуудалтай тулгарч байгаа нь үндэстэн хоорондын мөргөлдөөн гарах байнгын эрсдэлийг дагуулж байна.

Бүс нутгийн үржил шим бүхий газар тариалангийн бүс нутаг болсон “Ферганы хөндий” газар нутгийн маргааны гол төв “Дарьтай торх” болоод байна. Кыргызийн Ош, Тажикистаны Согди, Узбекистаны Ферган, Намаган, Андижан мужууд энэ хөндийд төвлөрдөг. Исламын шашны нөлөө хүчтэй нэвтэрсэн, олон үндэстнээс бүрдсэн хүн амын хэт төвлөрөл үүссэн зэргээрээ Ферганы хөндий Төв Азийн бүс нутгийн хамгийн онцлогтой бас үндэстэн хоорондын мөргөлдөөний голомт болох эрсдэлтэй бүс нутаг юм.

Зураг 1. Ферганы хөндий



Сургамж үлдээсэн зарим баримтыг дурдахад 1990 онд Ошд болсон Кыргыз-Узбекийн хоорондын мөргөлдөөний үед нутгийн узбекууд автономит эрхтэй болох, узбек хэлийг албан ёсны хэл болгох шаардлага тавьж зөрчлийг улам хурцатгасны улмаас 300-600 хүний амь үрэгдэж байсан³ бол 1991 онд Кыргызэд оршин суугч Тажик үндэстнүүд 10 мянган га газар шаардсанаар Баткенскийн мөргөлдөөнийг үүсгэж⁴ үүнээс үүдэн Тажикистан, Кыргыз, Узбекистаны хилийн маргаан дээд цэгтээ хүртэл хурцдаж байжээ. “Узбекистаны исламын хөдөлгөөн” гэгч зэвсэгт бүлэглэл 1999-2000 онд Тажикистаны хойд хэсгээс Узбек, Кыргызийн нутаг руу удаа дараа зэвсэгт халдлага үйлдэж бүс нутгийн аюулгүй байдалд ноцтой эрсдэл үүсгэж байв.

Төв Азийн бүс нутгийн хүн амын тогтвортой өсөлт, тухайн бүгд найрамдах улсын нийт хүн амын дунд бусад үндэстний эзлэх хувь ирээдүйд сөргөлдөөнийг даамжруулах бас нэгэн хүчин зүйл болж болзошгүй юм. Төв Азийн хүн амын өсөлт (үүнд *зөвхөн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудын хүн амын өсөлтийг авч үзэв*) 2020 оны байдлаар 1,66 хувь буюу жилд дунджаар 1 сая 172 мянга байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт болно. НҮБ-ын 2020 онд гаргасан судалгаагаар тус бүс нутгийн нийт хүн амын тоо 74,5 сая байгаагаас Узбекистан-45, Казахстан-25, Тажикистан-13, Кыргыз болон Туркменистан тус бүр 8,5 хувийг эзэлж байна⁵. Харин газар нутгийн маргаантай хөрш орнуудын нийт хүн амын 10-14 хувийг узбекүүд эзэлдэг бол Узбекистан дахь тажик үндэстний тоо 1,6 сая буюу 5 хувь орчим байдаг.

³ БХЭШХ, “Төв Азийн бүс нутгийн аюулгүй байдлын хэтийн төлөв, Монгол Улсын батлан хамгаалах бодлогог үзүүлэх нөлөө” х-33

⁴ Charles Reckhangel-“Ferghana Valley: A.Tinderbox For Violence” 2010

⁵ ria.ru/20100611/245118780.html История межэтнических отношений в Киргизии.

Хүснэгт 1.Төв Азийн орнуудын хүн амын дунд Узбек үндэстний эзлэх хувь

	Узбек үндэстнүүдийн тоо /мянган хүн/	Эзлэх хувь
Кыргызд амьдардаг Узбекиуд (2020 оны байдлаар)	964 379	14,8
Тажикистанд амьдардаг Узбекиуд (2010 оны байдлаар)	926 000	12,2
Казахстанд амьдардаг Узбекиуд (2020 оны байдлаар)	620 324	3,29
Туркменистанд амьдардаг Узбекиуд (2010 оны байдлаар)	500 000	10

Дээр дурдсанчлан хүчтэй авторитар дэглэмтэй нэгдсэн засаглал дор олон арван жилийн турш хутгалдан амьдарсан угсаатны томоохон бүлгүүд ийнхүү хөрш орны нутагт суурьшин амьдарч байгаа нь газар нутгийн маргаанаас үүдэлтэй зөрчил үүссэн тохиолдолд энэ нь үндэстэн хоорондын мөргөлдөөн болон даамжрах аюулыг бий болгож байгаа юм. Ахуйн хэрэглээний усны эх үүсвэрийн төлөөх иргэд хоорондын жижиг маргаан даамжирч хөрш орнуудад оршин суугаа үндэс нэгтнүүдийхнээ эрх ашгийг өмгөөлөн хамгаалах, улмаар үүссэн зөрчлөөр далимдуулан газар нутгийн маргааныг нэгмөсөн шийдвэрлэх гэсэн улс хоорондын мөргөлдөөн болон хувирч болзошгүй эрсдэл-сорилт Төв Азийн бүс нутагт цаашид удаан хугацаанд орших төлөвтэй байна.

Хоёрдугаарт, “Эрчим хүчний хомсдол”-оос үүдэлтэй усны болон эрчим хүчний нөөцийн төлөөх өрсөлдөөн, тэмцэл нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд олон жилийн туршид хөгжлийн нэгдмэл стратеги, төлөвлөгөөгөөр зохицуулагдаж ирсэн бүгд найрамдах улсуудын хооронд шинэ сорилт үүсгээд байна. Амударья, Сырдарья мөрний гол эх үүсвэрүүд дээр баригдаж байгаа Тажикистаны Рогуны УЦС, Кыргызийн Камбаратийн УЦС-уудтай холбоотой маргаан бүрэн шийдвэрлэгдээгүй байна. Сырдарья мөрний урсацын 75,2 хувь нь Кыргызд үүсч Узбекистан, Тажикистан, Казахстаны нутгаар урсаж Аралын тэнгист цутгадаг бол Амударья мөрний урсцын 74 хувь нь Тажикистанд үүсч Афганистан, Узбекистаны хилийн дагуу урсаж, Туркменистаны нутгаар дамжин дахин Узбекистаны нутгаар дайран Аралын тэнгист зутгадаг. Үүнээс эдгээр хоёр мөрөн Төв Азийн бүс нутгийн орнуудын хөдөө аж ахуй, газар тариалангийн гол эх үүсвэр болоод зогсохгүй байгаль экологийн тэнцвэртэй байдалд маш чухал үүрэгтэй болохыг харж болно. Цаашид дэлхийн дулаарал болон хүний оролцоотой хүчин зүйлүүдээс шалтгаалан Амударья, Сырдарья мөрнүүдийн урсгал татарч бүс нутгийн байгаль экологийн тэнцвэртэй байдал, ард иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлж эхэлбэл түр намжаад байгаа усны маргаан дахин сэргэж бүс нутгийн тогтвортой байдалд аюул учруулах нь тодорхой.

Гуравдугаарт, Өнөөгийн нөхцөлд Төв Азийн аюулгүй байдлын асуудлыг Афганистанаас ангид авч үзэх нь нэн өрөөсгөл ойлголт болно. АНУ, НАТО-гийн толгойлсон эвслийн цэргийн хүчин Афганистанаас бүрмөсөн гарч байгаа нь Төв Азийн бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөлөх бас нэгэн чухал хүчин зүйл болж байна. Сүүлийн үед тус улсад өрнөж буй үйл явдал, судлаачдын байр суурийг харахад нөхцөл байдал эерэг гэхээсээ илүүтэйгээр Төв Ази, Европыг чиглэсэн дүрвэгсдийн шинэ давлагаа үүсэх, улс дамнасан гэмт хэрэг өсөх, хар тамхины наймаа өргөжих, терроризмын аюул нэмэгдэх гэх мэт олон сөрөг үр дагавартай байх бололтой. Талибан хөдөлгөөний зүгээс Төв Азийн орнуудын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх ямарваа нэгэн үйлдэл хийхгүй,


харин ч Исламын улс бүлэглэл гэх мэт террорист байгууллагуудтай хатуу тэмцэнэ гэдгээ илэрхийлж байгаа ч хяналтаа тогтоосон газар нутагтаа исламын шашны хатуу дэг журам тогтоож эхлээд байна. Афганы засгийн эрх талибуудын гарт дахин (1996-2001 онд талибууд засгийн эрхэнд байв) шилжснээр энэ улс богино хугацаанд исламын шашны радикализмын төв болон хувирч ч болзошгүй юм. Ингэснээр Исламын улс, Аль-Каида гэх мэт террорист бүлэглэлүүдийн хоргодох түшиц газар болон хувирч үйл явдал Сирийн хувилбараар өрнөх аюултай билээ. Энэ нь Төв Азийн бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх маш ноцтой хүчин зүйл юм. Юуны түрүүнд хууль бүс зэвсэгт бүлэглэл, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлгүүдийн хил дамнасан гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаа эрс идэвхжиж, одоо ч бүрэн хянаж чадахгүй байгаа хар тамхины худалдаа, хэрэглээ, контрбандын асуудал улам газар авна. Үүнд хамгийн түрүүнд Тажикистан өртөх нь тодорхой юм.

НҮБ-ын “2020 оны Афганистаны опиумын судалгаа”-гаар тус улсын хар тамхины тариалалтын талбайн хэмжээ 2019 оныхоос 37 хувиар өсч 244 мянган гектарт тариалсан опиумын хэмжээ 6300 тоннд тус тус хүрсэн байна⁶. Дэлхийн хар тамхи, мансууруулах бодисын 90 орчим хувийг Афганистанаас нийлүүлдэг гэсэн тооцоо байдаг. Олон улсын терроризм, исламын хэт даврагч бүлэглэлүүд, салан тусгаарлагчдыг санхүүжүүлэх гол эх үүсвэр болсон хар тамхи, мансууруулах бодисны томоохон үйлдвэрлэгч болох Афганистан улсаас АНУ, НАТО-гийн цэргийн хүчин гарсан нь цаашид Төв Азийн орнуудаар дамжуулан Европт гарган худалдаалдаг энэ төрлийн наймааны сүлжээ, урсгалыг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй юм. Афганистанаас хар тамхи зөөвөрлөдөг гурван үндсэн чиглэл байна. Үүнд:

- Афганистан-Иран-Турк-Зүүн өмнөд Европ-Баруун болон Төв Европ;
- Афганистан- Төв Ази (Тажикистан, Кыргыз, Казахстан)-ОХУ-Европ;
- Афганистан-Пакистан-Ойрхи Дорнод,Зүүн өмнөд Ази, Африк;

гэсэн гурван том урсгалаар жилдээ нийтдээ 350 тн орчим хар тамхи Афганистанаас зөөвөрлөгддөг байна.

⁶ Интернет-портал СНГ. Население Центральной Азии вырастет более чем на миллион в 2020 году

Зураг 2. Азиас гаралтай хар тамхины нийлүүлэлтийн урсгал (тонн)⁷

Төв Азийн бүс нутагт олон арван мянган хүн хар тамхины байнгын хэрэглэгч болсны зэрэгцээ түүний худалдаа, контрбандын хэрэгт оролцож байгаа нь хүн амын ядуурал, төр засгийн үйл ажиллагаа сул, авлигад автсан байдал зэрэгтэй холбоотой. Дээрх нөхцөл байдлаас үүдэн бүс нутагт хар тамхины контрбандын асуудал өргөжих хандлагатай байгаа нь үүнийг дагасан исламын экстремизм, сепаратизм, терроризмтэй холбоотой хууль бус элдэв бүлэглэл, хөдөлгөөн идэвхжих таатай орчныг бүрдүүлж болзошгүй юм.

Төв Ази бол дэлхийн зарим бүс нутагтай харьцуулахад исламын экстремизм, сепаратизм, терроризмын нөлөөнд тодорхой хэмжээнд өртөөд байгаа, цаашид улам тархаж болзошгүй бүс нутгуудын нэг юм. Бүс нутгийн хэмжээнд олон улсын шинжээчдийн тооцоолж байгаагаар исламын хэт даврагчдаас бүрдсэн 20 орчим террорист шинжтэй хүчин үйл ажиллагаа явуулж байна. Тэдний гол зорилго нь исламын шашинт хэт хуучинсаг үзлийг баримталсан “халифат” улс байгуулан салан тусгаарлах явдал юм. Үүний тулд тэд хүчтэй, хөрөнгө мөнгөтэй байх хэрэгтэй ба хар тамхи, зэвсгийн хууль бус наймаагаар энэ зорилтоо гүйцэлдүүлж байна⁸.

Төв Азийн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг террорист байгууллагуудад 1979-1989 онд ЗХУ-Афганистаны дайнд оролцсон хөлсний дайчид олон байдаг бөгөөд тэд Чечений дайнд маш идэвхтэй оролцож байв.

⁷ Afghanistan opium survey 2020

⁸ https://www.unodc.org/images/afghanistan//Maps/WDRmap2010_2_p45.jpg

Хүснэгт 2. Төв Азид үйл ажиллагаа явуулдаг террорист байгууллагууд⁹

№	Нэр	Байгуулагдсан он	Хамрах бүс	Үйл ажиллагааны зорилго
1.	“Дорнод Туркестан” чөлөөлөх байгууллага	1990 он	Хятадын Шинжаань, Кыргыз, Турк	Дорнод Туркестаны тусгаар улс байгуулах
2.	Дорнод Туркестан исламын хөдөлгөөн	1990 он	Хятадын Шинжаань, Кыргыз, Афганистан, Казахстан, Пакистан	Шинжаань дахь хятадын хүчирхийллийг зогсоож, Төв Ази, Шинжааны нутаг дэвсгэрийг хамарсан исламын тусгаар улс байгуулах
3.	Узбекистаны исламын хөдөлгөөн	1990 он	Узбекистан, Тажикистан, Кыргыз, Афганистан, Иран, Пакистан	Шариатын хуульд захирагдах Исламын улс байгуулах
4.	Хизб ут тахрир /Эрх чөлөөний исламын нам/	1953	Узбекстан	Исламын Халифат улс байгуулах
5.	Талибан	1994 он	Афганистан	Халифат улс байгуулах
6.	Аль Кайда	1988 он	Афганистан	Халифат улс байгуулах
7	Исламын улс бүлэг	2013 он	Афганистан, Ойрх Дорнод	Халифат улс байгуулах

2011-2018 онд Төв Азийн гаралтай 4000 гаруй хөлсний дайчин Сири, Иракт Исламын улс бүлэглэлд, Афганистанд Талибаны талд байлдаж байсан гэдэг судалгаа байна¹⁰.

**Хүснэгт 3. Хилийн чанад дахь зэвсэгт тэмцэлд оролцсон
Төв Азийн гаралтай иргэдийн тоо¹⁰**

Улс	Оролцсон хөлсний дайчдын тоо
Тажикистан	1400-1899
Кыргыз	500-863
Узбекистан	200-1500
Казахстан	300-350
Туркменистан	300

Төв Азийн гаралтай иргэд хөлсний дайчин болоход шашны итгэл үнэмшил, үзэл бодлоос илүүтэй ядуурал, ажилгүйдлээс үүдэлтэй эдийн засгийн сонирхол давамгайлдаг байдаг ч байж болзошгүй юм. Исламын улс бүлэглэлийн хөлсний дайчин 2016 оны байдлаар сард 400-1200 ам.долларын цалин авахаас гадна, эхнэрт нь 50 ам.доллар, хүүхэд тус бүрт 25 ам.долларын тэтгэмж олгож байжээ¹¹. Афганистанаас АНУ, НАТО-гийн цэргийн хүчин гарсны дараа тэдний эсрэг талибанчуудтай хамтран байлдаж байсан хөлсний дайчид “ажилгүй болоод” хаачих вэ? гэсэн асуудал мөн анхаарал татна. Афганистаны Талибан хөдөлгөөний санхүүжилтээр эвслийн цэргийн эсрэг ажиллагаа явуулдаг болсон гэгддэг “Узбекистаны исламын хөдөлгөөн” зэвсэгт бүлэглэлийн террорист ажиллагаа Төв Азийн

⁹ <https://www.wilsoncenter.org/>: Talking up terrorism in central Asia.

¹⁰ <https://www.cnbc.com/2016/01/20/isis-cuts-fighters-salaries>

¹¹ Д.Шүрхүү: Төв Азийн бүс нутгийн хэтийн төлөв ба Монгол Улс Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд 14.3

бүс нутагт 1999-2000 оны үеийнх шигээ дахин идэвхжиж эхэлбэл бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй. Үүний зэрэгцээ өнөөгийн мэдээллийн эрин үед интернэтийн сүлжээ ашиглагчдын тоо эрс нэмэгдэж байгаагийн хэрээр исламын шашны экстремист чиглэлтэй янз бүрийн байгууллага, хөдөлгөөний зүгээс эгнээгээ өргөжүүлэх, санхүүгийн эх үүсвэр олох гэсэн тодорхой зорилготой мэдээллийг олон нийтийн сүлжээгээр идэвхтэй явуулах болсон нь аль хэдийнээ аюулын хэмжээнд хүрээд байна.

Нөхцөл байдал хэрхэн өрнөхөөс үл хамааран үүсч болзошгүй аюулыг сөрөх шинэ стратеги (*магадгүй нэгдмэл бодлого*) Төв Азийн орнуудад шаардлагатай бөгөөд үүнд Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага болон ШХАБ-ын оролцоо, зохицуулалт хэр байхаас их зүйл хамаарна. Харамсалтай нь Төв Азийн орнуудын ашиг сонирхлын зөрчил, зарим нөлөө бүхий улс төрчдийн хувийн амбицаас үүдэлтэй хойрго хандлага зэрэг нь хамтын аюулгүй байдлын нэгдмэл системийг бүрдүүлэхэд саад болсон хэвээр байна. Бүс нутгийн аюулгүй байдалд ямар нэгэн асуудал үүсэхэд Төв Азийн улсууд өөрсдөө л буруутан байдаг бөгөөд энэ нь голчлон ашиг сонирхол, бодлогын үл нийцэл, хоёр орны харилцааны бэрхшээлтэй байдлаас шалтгаалдаг. Үүнээс үүдэн бүс нутгийн хамтын ажиллагааны үндсэн чиглэлүүд түүний дотор аюулгүй байдлын чиглэлээр шинэ түвшинд хамтарч ажиллах, зөвхөн бүс нутгийн таван “ИСТАН”-ыг нэгтгэсэн байгууллагыг байгуулж чадалгүй өнөөг хүрчээ.

Дүгнэлт

Төв Азийн орнуудын газар нутгийн маргаан, усны болон эрчим хүчний нөөцийн төлөөх өрсөлдөөн, Афганистаны өнөөгийн цагийн байдал зэрэг нь бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж буй хэдий ч ойрын ирээдүйд мэдэгдэхүйц сөрөг өөрчлөлт гарахгүй, улс төрийн нөхцөл байдал урьдчилан таамаглахуйц хэмжээнд байна.

Монгол Улсын хувьд Төв Азийн бүс нутгийн тогтвортой байдал нь аюулгүй байдлын талаасаа нэн чухал бөгөөд шууд үзүүлэх сөрөг хүчин зүйлс одоогоор байхгүй. Харин эдийн засгийн талаасаа хэдийгээр Зүүн хойд Азийн хэмжээнд хүрэхгүй ч баруун бүсийн хөгжилд чухал ач холбогдолтой хэвээр байна.



Г.МЭНДСАЙХАН
ҮАБЗ-ийн ССХ-ийн
ОУБНСС-ийн Эрдэм
шинжилгээний ажилтан

ИХ ГҮРНҮҮДИЙН ОЙРХ ДОРНОД ДАХЬ БОДЛОГО СТРАТЕГИ

Abstract: The US National Security Strategy states that Russia and China are the main challenges to US security, prosperity, and interests, and the great power rivalry has returned to the international arena. More than 50 percent of the world's proven oil reserves and more than 45 percent of natural gas reserves are in the Middle East region. Geographically surrounded by three continents, five seas, and important shipping points such as the Suez Canal, the Bab al-Mandeb Strait, and the Strait of Hormuz, the region has long been a competition area for great powers. After World War II, US influence began to dominate the region, and with the end of the Cold War, Washington became unrivaled external power. In recent years, however, changes in the international and regional environment have shaken US hegemony, rival powers are entering the new space of influence. Russia has become an important player in regional security, and China's economic ties have expanded rapidly. The United States, on the other hand, is trying to strengthen its relations with the allies and maintain its influence in the region.

Түлхүүр үг: Их гүрнүүдийн өрсөлдөөн, Арабын Хавар, Бүс ба Зам

Оршил

“АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги” баримт бичигт Америкийн аюулгүй байдал, хөгжил дэвшил, ашиг сонирхолд сорилт авчирч буй гол хүчин зүйл нь ОХУ, БНХАУ болсныг онцолж Их гүрнүүдийн өрсөлдөөн олон улсын тавцанд эргэн ирснийг илэрхийлжээ. Дэлхийд одоогоор илрүүлээд байгаа нийт газрын тосны нөөцийн 50 гаруй, байгалийн хийн 45 гаруй хувь нь Ойрх Дорнодын бүс нутагт оршдог. Мөн газар зүйн хувьд гурван тив, таван тэнгисийн дунд, далайн тээвэрлэлтийн чухал цэгүүд болох Суэцийн суваг, Баб аль-Мандебын хоолой, Хормузын хоолойгоор хүрээлэгдсэн тул уг бүс нутаг хүчирхэг гүрнүүдийн өрсөлдөөний талбар байсаар ирсэн билээ. Дэлхийн II дайны дараагаас бүс нутагт АНУ-ын нөлөөллийн давамгайлал тогтож эхэлсэн бөгөөд


Хүйтэн дайн төгсгөл болсноор Вашингтон өрсөлдөгчгүй ноёрхох болсон. Гэвч сүүлийн жилүүдэд бүс нутагт төдийгүй олон улсын тавцанд гарсан өөрчлөлтүүдээс үүдэн АНУ-ын дангаар ноёрхох байдал ганхаж өрсөлдөгч гүрнүүдийн нөлөө үүссэн шинэ орон зайд нэвтрэх боллоо. Бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд ОХУ нөлөө бүхий чухал оролцогч болж, БНХАУ-ын эдийн засгийн харилцаа эрчимтэй өргөжсөн. Харин АНУ холбоотны харилцаагаа дахин бэхжүүлж нөлөөгөө тогтоон барих оролдлогууд хийж байна.

АНУ. Ойрх Дорнодын бүс нутаг дахь АНУ-ын нөлөө, байр суурь буурах болсонд олон хүчин зүйлс нөлөөлсөн. Эдгээрээс хамгийн голлох шалтгаануудыг дурдвал:

Нэгдүгээрт, “Исламын Улс” бүлэглэл шахагдан гарснаар терроризмын аюул занал эрс буурсан, АНУ-д “занарын хувьсал” гарч эрчим хүчний хувьд Ойрх Дорнодоос хамааралтай байхаа больсон (График 1), БНХАУ-ын хүчирхэгжилт Ази тив рүү анхаарлаа түлхүү хандуулах шаардлага үүсгэсэн зэргээс хамаараад АНУ Ойрх Дорнодоос хүчээ татаж эхэлсэн. Энэ нь хүчний хоосон орон зай үүсгэж өрсөлдөгч гүрнүүд бүс нутаг дахь сөргөлдөөнийг ашиглан өөртөө давуу тал бий болгох боломж үүсгэжээ.

График 1. АНУ-ын газрын тосны олборлолт, импорт, экспортын харьцуулалт (өдөрт, сая.баррелиар)

График 1. АНУ-ын газрын тосны олборлолт, импорт, экспортын харьцуулалт (өдөрт, сая.баррелиар). Эх сурвалж: US Energy Information Administration




Эх сурвалж: US Energy Information Administration

Хоёрдугаарт, Ойрх Дорнодыг тэр чигт нь эмх замбараагүй байдалд автуулсан 2011 оны “Арабын Хавар” гэгдэх бослого хөдөлгөөнд АНУ ардчилсан үзэл суртал дээр тулгуурлан босогчдын талыг баримтлах болсон нь бүс нутгийн авторитар дэглэмт улс орнуудын итгэлийг алдахад хүргэсэн. Ерөнхийлөгч Барак Обама 30 жил АНУ-ын бүс нутаг дахь бодлогыг дэмжиж ирсэн Египетийн Ерөнхийлөгч Хосни Мубаракыг огцрохыг шаардаж байсныг, Сири, Ливийг иргэний дайнд хөтлөн ямархуу байдалд оруулсныг тэд мартдаггүй. Уг үл итгэлцлээс улбаатай ан цав бүс нутгийн орнуудыг бусад их гүрнүүдтэй ойр дотно харилцаа үүсгэх үндэс суурийг тавьсан. Гуравдугаарт, өрсөлдөгч гүрнүүдийн цэрэг, эдийн засгийн хүч нөлөө, чадавх Ойрх Дорнодод идэвхтэй

бодлого явуулж АНУ-д сорилт авчрах хэмжээнд хүртлээ өсөн нэмэгдсэн. Одоогоос 20 жилийн өмнө л гэхэд ОХУ, БНХАУ хил орчмоосоо даван идэвхтэй гадаад бодлого явуулах бололцоогүй байлаа. Өдгөө Ойрх Дорнод, Африк төдийгүй Латин Америкт хүртэл нөлөөгөө тэлж чадсан байна.

Хэдийгээр дээрх хүчин зүйлсээс хамааран АНУ-ын нөлөө харьцангуй буурсан ч бидний улс төр, батлан хамгаалахын жин нөлөө, бүс нутгийн хүчирхэг гүрнүүдтэй тогтоосон уламжлалт холбоотны харилцаа нь АНУ-д тэргүүллийн байр сууриа хадгалах боломж олгож байна. Тухайлбал АНУ-ын зэвсэгт хүчин Бахрейн, Кувейт, Йордан, Катар, Оман, Саудын Араб, Турк, АНЭУ-д их бага хэмжээгээр байрлаж байна(Газрын зураг 1). Эдгээрээр дамжуулан бүс нутагт төрөл бүрийн цэргийн үйл ажиллагаа явуулах чадавхтай. Нөгөө талд ОХУ Сирид, БНХАУ зэргэлдээ орших Жибутид тус бүрдээ ганц цэргийн баазтай байгаа нь хүчний харьцангуй байдлын тод илрэл юм. Түүнчлэн Ираны аюул занал оршин байгаа цагт АНУ, Израйль, Саудын Араб тэргүүтэй булангийн орнуудын харилцаа нягт хэвээр байна. Энэ мэт давуу талууд АНУ-ыг өрсөлдөгч нараас нь олон алхмын урд байлгах боловч алсдаа давуу талыг нь хадгалах баталгаа болж чадахгүй.

**Газрын зураг 1. Ойрх Дорнод, Афганистанд байрлаж буй
АНУ-ын цэргийн тоо (2020 оны байдлаар)**



Эх сурвалж: US Congressional Research Service

Одоогоор АНУ-д өрсөлдөгчдөө бүс нутгаас шахан гаргаж өмнөх өрсөлдөгчгүй давамгайллын статус квот эргүүлэн авчрах боломж, эрмэлзэл аль аль нь байхгүй. Вашингтон дахь улс төрийн хүрээнийхэн бүс нутгийн бугшсан асуудлуудаас АНУ-ыг татан гаргах нь зүйтэй гэдэг дээр бүрэн санал нийлсэн. Чухамхуу хэрхэн хамгийн зөв хувилбараар гарах талаар зөвлөлдцгөөж байна. Ойрх Дорнодын асуудалд дахин идэвхтэй оролцох бодлого баримталбал ард иргэдийн зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулах улс төрийн уур амьсгал мөн бүрдчихсэн. Тиймээс шийдвэр гаргагчдад аль

болох бага нөөц бололцоогоор өрсөлдөгч гүрнүүдийн нөлөөг тогтоон барих, холбоотнуудтайгаа харилцаагаа сайжруулах, сөргөлдөөнийг энх тайван, дипломатын арга замаар шийдвэрлэх бодлого баримтлах шаардлага үүсч байна.

Ерөнхийлөгч Ж.Байден холбоотнуудтайгаа харилцаагаа сайжруулан ОХУ, БНХАУ-тай өрнүүлэх өрсөлдөөндөө тэднийг татан оролцуулна гэдгээ илэрхийлсэн. Европын орнуудад ОХУ-тай, Япон, Өмнөд Солонгост БНХАУ болон Хойд Солонгостой холбоотой аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд байдаг тул эдгээр холбоотон нь АНУ-аас амархан нүүр буруулахгүй. Харин Ойрх Дорнод дахь холбоотнуудын ихэнх нь тус бүрийн ашиг сонирхлоосоо хамаараад өрсөлдөгч гүрнүүдийн тал руу хэлбийх хандлагатай байна. Бүс нутгийн асуудлуудад гүн хутгалдахаас зайлсхийхийн зэрэгцээ холбоотны харилцаагаа бэхжүүлж давамгайллаа хадгалах хүнд сорилтын өмнө АНУ ирээд байна.

ОХУ

Ойрх Дорнодын бүс нутагт нөлөөгөөрөө АНУ-ын дараа орох их гүрэн бол ОХУ юм. Ерөнхийлөгч В.Путины Сирийн иргэний дайнд интервенц хийх шийдвэр олон талаар амжилт олж ЗХУ задарснаас хойш алдагдаад байсан Москвагийн байр суурийг эргүүлэн авчрахад хүргэсэн.

ОХУ-ын Зэвсэгт хүчний тусламжтайгаар Ерөнхийлөгч Башар Асад эрх мэдлээ хадгалж харьцангуй тогтвортой байдал бий болгож чадсан. Үүнийг ардчиллын үзэл санаанд хэт хөтлөгдөн бүс нутагт эмх замбараагүй байдлыг өдөөсөн Вашингтоны алдаатай бодлогыг засан залруулсан прагматик, оновчтой үйлдэл хэмээн олон улсад өндрөөр үнэлж байна¹. Зарим судлаач ОХУ-ын “Их гүрний” статусыг сэргээсэн үйл явдал ч гэж үздэг. Хамгийн бодит үүссэн давуу тал бол газар дундын тэнгистэй залгаа Латакиа хотод агаарын, Тартуст тэнгисийн цэргийн бааз тус тус байгуулсан явдал юм (Газрын зураг 2). НАТО-гийн умард хязгаарт тулан ирсэн тус бааз стратегийн өндөр ач холбогдолтой. Түүнчлэн Ойрх Дорнодод өрнөөд буй хямрал, зөрчлүүдийг энх тайвны замаар шийдвэрлэх зорилго бүхий яриа хэлэлцээрүүдэд дундыг баримтлан оролцох бүрэн боломжтой чухал тоглогчийн байр сууринд очиж чадлаа.

¹ Steven.A, Major Power Rivalry in the Middle East, The Council on Foreign Relations, Mar.2021. URL: https://cdn.cfr.org/sites/default/files/report_pdf/dp-cook-no.-2.pdf

Газрын зураг 2. ОХУ-ын Сири цэргийн баазуудын байршил



Эх сурвалж: Gulf

Энэ мэт давуу талуудыг бий болгож чадсан Москвагийн дараах алхам бол бүс нутгийн улс орнуудтай харилцаагаа өргөжүүлэх замаар нөлөөгөө улам бүр тэлэх юм. Ингэхдээ АНУ ба түүний холбоотон улсуудын хооронд үүссэн ан цавыг ашиглан харилцааг нь улам доройтуулах, цаашлаад боломжтой бол өөрийн талд эргүүлэх оролдлогуудыг хийж байна. Тухайлбал, төрийн эргэлтээр шашны хэт даврагчдыг унагаж эрх мэдлийг гартаа авсан Египетийн Ерөнхийлөгч Абдел Фаттах аль-Сисиг Вашингтоны зүгээс эрүүдэн шүүх үйл ажиллагаа явуулж хүний эрхийг зөрчсөн хэмээн буруушаадаг². Харин ОХУ, Египет ямар нэгэн үзэл санаа, зарчмаас илүүтэйгээр тогтвортой байдлыг чухалчилдгаараа төстэй бөгөөд сүүлийн жилүүдэд хоёр улсын харилцаанд ахиц дэвшил гарах болсон. 2013-2019 оны хооронд Египет ОХУ-аас нийт гурван тэрбум ам.долларын зэвсэг, байлдааны онгоц, нисдэг тэрэг худалдаж авсан³. Энэ нь 1970-аад оноос хойших хамгийн том худалдан авалтад тооцогдоно. Мөн ОХУ-ын бүс нутаг дахь дараагийн цэргийн баазаа Египет улсад байрлуулахаар хэлэлцэж буй цуурхал тараад байна⁴.

Үүнтэй төстэй нөхцөл байдал АНУ-Туркийн харилцаанд ажиглагдана. Туркийн аюулгүй байдлын томоохон асуудал болох “Курдистаны Хөдөлмөрийн нам”-ын салбар “Ардын хамгаалах хүчин”-тэй Ерөнхийлөгч Б.Обама Сирийн иргэний дайнд хамтран ажиллах шийдвэр гаргасан. Үүнээс гадна 2016 оны төрийн эргэлтийг зохион байгуулсан гэгдэх Фетулла Гуленийг шилжүүлэн өгөхийг Ерөнхийлөгч Т.Р. Эрдоган хүссэн боловч АНУ татгалзсан хариу өгсөн⁵ гээд хоёр улсын хооронд үл ойлголцох асуудал олон бий. Уг үүсээд буй ан цав НАТО-гийн гишүүн Турк улс гол өрсөлдөгч ОХУ-аас “S-400” агаарын довтолгооноос хамгаалах цогцолбор худалдан авах гэрээ үзэглэх болсны голлох шалтгаан юм. Энэ бүхэн Москвагийн ашиг сонирхолд хамгийн ихээр нийцэж байна.

Бүс нутгийн сөргөлдөгч талуудын төлөөллийн дайн Сирид идэвхтэй явагддаг. Нэг талаас Иран улс Сирид байнгын цэргийн бааз байгуулж Ливийн Хезболла бүлэглэлд чөлөөтэй зэвсэг нийлүүлэх боломжийг эрэлхийлж байхад нөгөө талаас дайсагнагч Израйль, Саудын Араб зэрэг улс үүнийг нь таслан зогсоох эрмэлзэлтэй байна. Тиймээс Иранд нөлөөлж чадах цорын ганц хүч ОХУ-ыг түших хэрэгцээ шаардлага дээрх орнуудад тулгардаг. 2015 онд интервенцээс хойш Ерөнхийлөгч В.Путин, Ерөнхий сайд Биньямин Нетаньяху нар нийт 11 удаа уулзаж, цаг үеийн асуудлаар тогтмол утсаар ярьж байсан нь хоёр улсын харилцааг ахисан түвшинд авчирсан⁶. Түүнчлэн хоёр тал Сирид цэргийн үйл ажиллагаа явуулахдаа харилцан мэдээлэл солилцож санамсаргүй мөргөлдөөн үүсэхээс зайлсхийх арга хэмжээ авч байжээ. Ижил ахиц дэвшил ОХУ, Саудын Арабын харилцаанд гарсныг Эзэн хаан Салманы 2017 онд Москвад хийсэн түүхэн дэх анхны айлчлалаас харж болно⁷.

² US joins West in rare criticism of Egypt on human rights abuses, Al Jazeera. 2021.03.12. URL: <https://www.aljazeera.com/news/2021/3/12/us-joins-west-in-rare-criticism-of-egypt-on-human-rights-abuses>

³ Stockholm International Peace Research Institute, “TIV of Arms Exports to Egypt, 2013–2019,” generated February 8, 2021, http://armstrade.sipri.org/armstrade/html/export_values.php.

⁴ Steven.A, Major Power Rivalry in the Middle East, The Council on Foreign Relations, Mar.2021. URL: https://cdn.cfr.org/sites/default/files/report_pdf/dp-cook-no.-2.pdf

⁵ Trump: US not considering Fethullah Gulen's extradition to Turkey. Aljazeera. 2018.11.17. URL: <https://www.aljazeera.com/news/2018/11/17/trump-us-not-considering-fethullah-gulens-extradition-to-turkey>

⁶ Netanyahu, Putin Discuss Iran's Role In Syria. Radio Free Europe. 2019.02.27. URL: <https://www.rferl.org/a/netanyahu-to-meet-putin-in-moscow-amid-strained-ties/29793202.html>

⁷ Patrick.W. Saudi king's visit to Russia heralds shift in global power structures. The Guardian. 2017.10.05. URL: <https://www.theguardian.com/world/2017/oct/05/saudi-russia-visit-putin-oil-middle-east>

Ойрх Дорнодын улс орнуудад АНУ-аас өөр аюулгүй байдлын асуудал дээр хамтран ажиллах гадны оролцогч байдаггүй байсан бол өдгөө ОХУ орлож чадахуйц чухал байр сууринд гарч ирлээ. АНУ-аас ялгаатай нь ОХУ-д дайсагнах улс бүс нутагт байхгүй. Ашиг сонирхол нь огтлолцож буй бүх улстай чөлөөтэй хамтран ажиллаж чаддаг. Геополитикийн тэлэлт хийх нэгдүгээр зорилтоо биелүүлсэн. АНУ-ын холбоотнуудтай харилцаагаа өргөжүүлж нөлөөгөө тэлэх дараа дараагийн алхмууд нь амжилт олсоор байна.

БНХАУ

Ойрх Дорнод дахь Хятадын бодлого, стратеги эдийн засгийн ашиг сонирхол дээр түлхүү суурилсан байна. “Бүс ба зам” санаачилгын хүрээнд БНХАУ идэвхтэй үйл ажиллагаа явуулж Ойрх Дорнодын улсуудтай хийсэн худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээгээрээ тэргүүлж эхэллээ⁸. Уг санаачилгын “Далайн торгоны зам”-ын шугам бүс нутгийн далайн тээврийн цэгүүдээр дайрч өнгөрнө. Тиймээс тус цэгүүдтэй хиллэдэг Саудын Араб, Египет, АНЭУ, Иран зэрэг улсын боомтыг хөгжүүлэх төсөлд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Мөн Хятадын газрын тосны импортын тал орчим хувийг Ойрх Дорнодын улс орнууд бүрдүүлдэг тул энэ бүс нутагт өндөр ач холбогдол өгдөг⁹.

Одоогоор “Бүс ба зам” санаачилгын хүрээнд бүс нутгийн 21 улс Хятадтай хамтран ажиллахаа илэрхийлээд байна. Эдгээрээс Египет, Саудын Араб, Иран, АНЭУ-тай “Иж бүрэн стратегийн түншлэл”, Турк улстай “Хамтын ажиллагаа, стратегийн түншлэл”, Израйль улстай “Иж бүрэн инновацын хамтын ажиллагаа”-г байгуулжээ. Инновацын хамтын ажиллагааныхаа хүрээнд Израйль улстай батлан хамгаалахын технологийн чиглэлд гүнзгий харилцаа үүсгэж чадсан. Хөрөнгө оруулалтын тал дээр Бээжин ашиг сонирхолд нь нийцэж л байвал АНУ болон Барууны орнууд шиг улс төрийн шинэчлэл хийх, авлигын эсрэг бодлого явуулах гэх мэт янз бүрийн шаардлага тавиад байдаггүй ба энэ нь бүс нутгийн авторитари дэглэмт улсууд Хятадтай харилцаагаа гүнзгийрүүлэх бас нэг шалтгаан болж байна¹⁰.

БНХАУ, Ираны стратегийн түншлэл АНУ-ын ашиг сонирхолд сөргөөр нөлөөлдөг хамгийн том хүчин зүйл юм. Ерөнхийлөгч асан Д.Трампын эдийн засгийн хориг арга хэмжээ Ираныг туйлдуулж байхад Бээжин газрын тосны импортоо зогсоолгүй орлогын гол эх үүсвэр болж байсан. Мөн Хятадын зүгээс Ираны төмөр зам, далайн боомт, 5G интернэт сүлжээ, харилцаа холбооны салбарт 25 жилийн дотор нийт 400 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж хариуд нь газрын тос хямдралтай үнээр худалдан авах гэрээ байгуулсан¹¹. Мөн Хормузын хоолойд байрлах Жаск далайн боомтыг Хятадад ашиглуулах хэлэлцээр хийхээр төлөвлөж байна. Боомтыг хар тамхи, терроризм, хүний наймаа гэх мэт хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд ашиглана гэх боловч бодит байдал дээр хамтарсан цэргийн бэлтгэл сургуулилт хийх, тагнуулын мэдээ солилцох зэрэгт ашиглана гэх хардлага байдаг¹². ОХУ, БНХАУ, Иран сүүлийн жилүүдэд

⁸ China is largest foreign investor in Middle East. MEMO. 2017.07.24. URL: <https://www.middleeastmonitor.com/20170724-china-is-largest-foreign-investor-in-middle-east/>

⁹ Daniel.W. Top 15 Crude Oil Suppliers to China. World's Top Exports. Dec.2020. URL: <https://www.worldstopexports.com/top-15-crude-oil-suppliers-to-china/>

¹⁰ Steven.A, Major Power Rivalry in the Middle East, The Council on Foreign Relations, Mar.2021. URL: https://cdn.cfr.org/sites/default/files/report_pdf/dp-cook-no.-2.pdf

¹¹ Eyck.F. Influence Without Entanglement in the Middle East. Foreign Policy. 2021.02.25. URL: <https://foreignpolicy.com/2021/02/25/influence-without-entanglement-in-the-middle-east/>

¹² Anthony.H, China in the Gulf: A New Partnership with Iran?, CSIS, 2020.07.15. URL: <https://www.csis.org/analysis/>

Энэтхэгийн далайд тэнгисийн цэргийн хамтарсан бэлтгэл сургуулилт тогтмол хийх болсон. Бүс нутгийн улсуудаас Иранд л энэ төрлийн бэлтгэл сургуулилтыг АНУ-ын өрсөлдөгч гүрнүүдтэй хийх бололцоо бий.

Бүс нутаг дахь АНУ-ын холбоотон орнууд Хятадад их хэмжээний газрын тос нийлүүлэхийн зэрэгцээ бусад салбарт мөн хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Саудын Араб хятад хэлийг ерөнхий боловсролын болоод их дээд сургуулийн сурагч, оюутнуудад гуравдагч хэл болгон заах хөтөлбөр 2020 онд баталсан¹³. АНУ-ын тогтмол шахалтад орж байсан ч Кувейт, АНЭУ, Саудын Араб 5G интернэт сүлжээний дэд бүтцийн төсөлд “Huawei” компанийг сонгон ажиллуулахаар болсон. Ковид-19 вирусийн “Синофарм” үйлдвэрийн вакцинд яаралтай горимд хэрэглэх зөвшөөрөл олгосон анхны улс АНЭУ байв. Дубайн захирагч Шейх Аль Мактум уг вакциныг тариулж буй зургаа нийтэлж ард иргэдээ хамрагдахын уриалж байлаа. Түүнчлэн Шинжаан Уйгарын Исламын шашинтнуудын эрхийг зөрчсөн асуудал эд хөндөгдөж байх үед Исламын шашны лидер Саудын Араб улсын угсаа залгамжлагч Ханхүү Мухаммед бин Салман Бээжинд айлчлан “Үндэсний аюулгүй байдлаа хадгалахын тулд Хятад улс терроризм, экстремизмийн эсрэг арга хэмжээ авах нь зүйтэй” хэмээн байр сууриа илэрхийлсэн. Хэдэн жилийн өмнө л Турк улс Шинжаан Уйгар дахь угсаа нэгтнүүдийнхээ хүчтэй дэмжигч дуу хоолой байсан. Гэвч эдийн засгийн хямрал нүүрлэж Хятадын хөрөнгө оруулалтыг эрэлхийлэх болсон Ерөнхийлөгч Тайип Эрдоган уг асуудал дээр чимээгүй байгаад зогсохгүй Шинжаан Уйгараас дүрвэн ирэгсдийг хэдэн зуугаар нь баривчлан нутаг буцаах болсон байна¹⁴. Энэ мэтчилэн АНУ, Европын Холбооны талд орж Хятадыг шүүмжлэх улс орон Ойрх Дорнодоос гарч ирээгүй.

Израйлийн технологийн салбарт Хятад улс жил бүр хэдэн зуун сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж байна. Д.Трампын засаг захиргаа Израйлийн талаас Хятадтай хийх худалдааны харилцаа дээрээ хяналт тавьж хөрөнгө оруулалтын хязгаар тогтоохыг хүссэн ч төдийлөн нөлөө үзүүлээгүй. Мөн Хятадын төрийн өмчит компани Израйлийн Хайфа боомтыг 25 жил түрээслэх гэрээ байгуулсан бөгөөд тус боомтод АНУ шалгалт хийх хүсэлт гаргасан ч Израйлийн зүгээс мөн адил татгалзсан хариу өгсөн¹⁵.

АНУ, ОХУ-аас улсаас ялгарах Хятадын нэг онцлог нь улс хоорондын зөрчил, шашны урсгалуудын тэмцэл, иргэний дайн гэх мэт бүс нутагт тогтмол өрнөж буй үйл явдлуудад гүнзгий хутгалддаггүй. Эдийн засгийн чадавх, бололцоо дээрээ тулгуурлан өөртөө давуу тал олж авахыг эрмэлздэг байна. Энэ ч бүрэн утгаараа хэрэгжиж бүс нутгийн нөлөө бүхий бүх улсын анхаарлыг татсан түншийн хэмжээнд авчирчээ.

Дүгнэлт

Ойрын хугацаанд Москвад бүс нутгийн орнуудтай эдийн засгийн харилцаагаа дорвитой өргөжүүлэх боломж байхгүй. Сирийн интервенцээс үүссэн давуу талаа ашиглан нөлөөгөө тэлэх нь тэдний цаашид баримтлах бодлогын үндэс юм. Эсрэгээрээ Бээжинд аюулгүй байдлын асуудал дээр Ойрх Дорнодын улс орнуудад санал болгох зүйл байхгүй ч

china-gulf-new-partnership-iran

¹³ Hind.B, What's really behind Saudi Arabia's inclusion of Chinese as a third language?, The New Arab, 2020.01.29. URL: <https://english.alaraby.co.uk/analysis/saudi-arabias-inclusion-chinese-third-language>

¹⁴ Joanna.K, 'I Thought It Would Be Safe': Uighurs In Turkey Now Fear China's Long Arm. 2020.03.13. NPR. URL: <https://www.npr.org/2020/03/13/800118582/i-thought-it-would-be-safe-uighurs-in-turkey-now-fear-china-s-long-arm>

¹⁵ Arie.E. Israel Rejects US Plan To Inspect Chinese Harbor At Haifa. Breaking Defense. 2021.02.03. URL: <https://breakingdefense.com/2021/02/israel-rejects-us-plan-to-inspect-chinese-harbor-at-haifa/>

худалдаа, хөрөнгө оруулалтаар харилцаагаа өргөжүүлэх боломж байна. Хоёр улс Израйль, Турк, Саудын Араб гэх мэт АНУ-ын бүс нутаг дахь гол холбоотнуудтай нягт харилцаа үүсгэж чадсан нь хамгийн том амжилт юм. Тэдний эцсийн зорилго нь АНУ-ын ноёрхолд цэг тавьж олон туйлт дэг журам тогтоох. Үүний хүрээнд Персийн буланд төдийгүй бусад бүс нутагт АНУ-ын цэргийн хүчний давамгайллыг тэнцвэржүүлэх шаардлагатай. Ойрх Дорнодод дипломатын, эдийн засгийн, бүүр цаашлаад цэргийн хүч нөлөөгөө тогтоох нь дээрх зорилтын зүг тавих алхмууд болно. Нөгөө талд АНУ-ын бүс нутаг дахь цэрэг, улс төрийн хүч нөлөө үлэмж их хэвээр байна. Үүнийгээ хадгалахын зэрэгцээ өрсөлдөгч гүрнүүдийн нөлөөг тогтоон барих нь Вашингтоны бодлого, стратегийн чиглэл байх болов уу. Ингэхдээ нөөц бололцоогоо Ойрх Дорнодод нэмэгдүүлж хүч хаях бус уламжлалт холбоотны харилцаагаа дипломатын арга замаар бэхжүүлэх бодлого баримтлах төлөвтэй байна.

-
1. National Security Strategy of the United States of America, The White House, Dec.2017. URL: <https://trumpwhitehouse.archives.gov/wp-content/uploads/2017/12/NSS-Final-12-18-2017-0905.pdf>
 2. Obama presses Hosni Mubarak to make ‘right decision’ and step down, France24. 2011.02.05. URL: <https://www.france24.com/en/20110205-obama-presses-hosni-mubarak-leave-office>
 3. Matthew.W. U.S. Military Bases and Facilities in the Middle East. American Security Project. 2018.06. URL: <https://www.americansecurityproject.org/wp-content/uploads/2018/07/Ref-0213-US-Military-Bases-and-Facilities-Middle-East.pdf>
 4. Steven.A, No Exit: Why the Middle East Still Matters to America, Foreign Affairs, November/December 2020, URL: <http://foreignaffairs.com/articles/united-states/2020-10-13/no-exit>.
 5. Steven.A, Major Power Rivalry in the Middle East, The Council on Foreign Relations, Mar.2021. URL: https://cdn.cfr.org/sites/default/files/report_pdf/dp-cook-no.-2.pdf
 6. US joins West in rare criticism of Egypt on human rights abuses, Al Jazeera. 2021.03.12. URL: <https://www.aljazeera.com/news/2021/3/12/us-joins-west-in-rare-criticism-of-egypt-on-human-rights-abuses>
 7. Stockholm International Peace Research Institute, “TIV of Arms Exports to Egypt, 2013–2019,” generated February 8, 2021, http://armstrade.sipri.org/armstrade/html/export_values.php.
 8. Trump: US not considering Fethullah Gulen’s extradition to Turkey. Aljazeera. 2018.11.17. URL: <https://www.aljazeera.com/news/2018/11/17/trump-us-not-considering-fethullah-gulens-extradition-to-turkey>
 9. Netanyahu, Putin Discuss Iran’s Role In Syria. Radio Free Europe. 2019.02.27. URL: <https://www.rferl.org/a/netanyahu-to-meet-putin-in-moscow-amid-strained-ties/29793202.html>
 10. Patrick.W. Saudi king’s visit to Russia heralds shift in global power structures. The Guardian. 2017.10.05. URL: <https://www.theguardian.com/world/2017/oct/05/saudi-russia-visit-putin-oil-middle-east>
 11. China is largest foreign investor in Middle East. MEMO. 2017.07.24. URL: <https://www.middleeastmonitor.com/20170724-china-is-largest-foreign-investor-in-middle-east/>

12. Daniel.W. Top 15 Crude Oil Suppliers to China. World's Top Exports. Dec.2020. URL: <https://www.worldstopexports.com/top-15-crude-oil-suppliers-to-china/>
13. Eyck.F. Influence Without Entanglement in the Middle East. Foreign Policy. 2021.02.25. URL: <https://foreignpolicy.com/2021/02/25/influence-without-entanglement-in-the-middle-east/>
14. Anthony.H, China in the Gulf: A New Partnership with Iran?, CSIS, 2020.07.15. URL: <https://www.csis.org/analysis/china-gulf-new-partnership-iran>
15. Hind.B, What's really behind Saudi Arabia's inclusion of Chinese as a third language?, The New Arab, 2020.01.29. URL: <https://english.alaraby.co.uk/analysis/saudi-arabias-inclusion-chinese-third-language>
16. Joanna.K, 'I Thought It Would Be Safe': Uighurs In Turkey Now Fear China's Long Arm. 2020.03.13. NPR. URL: <https://www.npr.org/2020/03/13/800118582/i-thought-it-would-be-safe-uighurs-in-turkey-now-fear-china-s-long-arm>
17. Arie.E. Israel Rejects US Plan To Inspect Chinese Harbor At Haifa. Breaking Defense. 2021.02.03. URL: <https://breakingdefense.com/2021/02/israel-rejects-us-plan-to-inspect-chinese-harbor-at-haifa/>



Д.БАТМӨНХ
ҮАБЗ-ийн ССХ-ийн Эдийн
засгийн секторын Эрдэм
шинжилгээний ажилтан

ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

Abstract: *Researchers intensively study national security, including economic security. The article provides an insight into national security and development issues, including economic security, and how the country's development affects security.*

For researchers, the importance of defining criteria for measuring safety continues to be the focus of attention. To assess economic security, we not only take macroeconomic indicators, but it is also important to take into account indicators of economic development.

However, to date, we have not been able to ensure economic security in a country with poor economic development. For example, Mongolia's gross national income per capita in 2018 will be 1.4 times lower than the world's gross national income per capita, or more than \$ 4,800. In other words, our current economic growth cannot be sufficient to ensure the country's economic security. In order to reach the world average, we need to increase our GDP by 1.5 times from the highest level of 17 percent in 2012, which is sufficient to ensure economic security.

Түлхүүр үг: Эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил

Тус нийтлэлд эдийн засгийн аюулгүй байдлын талаар тодорхой ойлголтыг бий болгохоос гадна улс орны хөгжлийн асуудал аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж буй талаар санал бодлоо хуваалцах юм. Үндэсний аюулгүй байдлыг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхой тусгасан байдаг. Харин эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлтүүдийн босго утгыг тодорхой болгох чиглэлээр эрдэмтэд, судлаачид ихээхэн хувь нэмэр оруулж ирсэн билээ. Улмаар Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн асуудал эдийн засгийн аюулгүй байдалтай хэрхэн уялдаж байгаа, эдийн засгийн аюулгүй байдлын босго утгад ямар үзүүлэлтүүдийг оруулж болох тухай авч үзнэ.

Эдийн засгийн аюулгүй байдлын ач холбогдлын талаар УИХ-ын гишүүн, аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга асан (Ж.Энхбаяр, 2017) хэлэхдээ “Монгол Улсын анхны ардчилсан Үндсэн хууль батлагдан гарснаас хойш 26 жилийн хугацаанд бидний туулж ирсэн амаргүй замдаа хуримтлуулсан туршлага, өнөөдөр олон улсад болон дотоодод үүсээд байгаа зарим талаасаа мухардмал гэж хэлж болохоор шинэ нөхцөл байдал нь эдгээр хууль, тогтоомжийг эргэн харах, цаашид боловсронгуй болгохыг зүй ёсоор шаардах боллоо”. Мөн “Ийм нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогынхоо залгамж чанарыг хадгалан, цаг ямагт төгөлдөржүүлэх, түүнд нөлөөлж буй олон талт хүчин зүйлсийг тогтмол тандан судалж, дүн шинжилгээ хийх, энэ үндсэн дээр болзошгүй эрсдэл, сорилт, аюул, заналыг урьдчилан харж, тэдгээрийг даван туулах зорилго бүхий судалгаа, шинжилгээний ажлыг байнга явуулж байх нь ихээхэн чухал асуудал юм. Үүнд манай орны эрдэмтэн судлаачид, мэргэжлийн хүмүүсийн санаа бодол, үнэлэлт, дүгнэлт ихээхэн ач холбогдолтой байх нь хэн бүхэнд ойлгомжтой зүйл юм” гэж цохон тэмдэглэсэн байна.

Судлаачид аюулгүй байдлын талаар тэр дундаа эдийн засгийн аюулгүй байдлыг эрчимтэй судалж ирсэн бөгөөд хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох асуудал өнөөг хүртэл анхаарлын төвд байна. Энэ нь эдийн засгийн аюулгүй байдлыг үнэн зөв дүгнэх боломжийг олгодог. Эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн талаар ярихын өмнө эдийн засгийн аюулгүй байдал үүнтэй холбоотой эдийн засгийн хөгжлийн тодорхойлолтыг авч үзье.

Монгол хэлний тайлбар толинд “аюул” гэдэг үгийг гамшиг зовлонг учруулж болох хор хөнөөл, “аюулгүй” гэдэг нь аюул байхгүй айж эмээх, сандрах түгшүүргүй гэж тайлбарласан байдаг бол орос хэлнээ “безопасность” буюу “аюулгүй” гэдэг нь аюулгүй, осолгүй, энх амар гэсэн үгээр илэрхийлэгдэж байхад англи хэлнээ “security” гэсэн үг нь хамгаалалт бэхлэлт, найдвартай чанар, бүрэн бүтэн байдал гэсэн утгыг агуулж байдаг. Аюул нь хувь хүн, нийгмийн бүлэг, ард түмэн, төр улсын амьдралд хор хохирол учруулах, хөгжлийн боломжийг хязгаарлах, үгүй болгох боломж бүхий бодитой орших эсвэл болзошгүй үзэгдэл, үйл явц болно гэж судлаач (Д.Энхчимэг, Т.Мөнх-Оргил, 2021) нарын “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам онол, арга зүй, туршлага, шинжилгээ, боломж” бүтээлд тусгажээ.

Ж.Бор, В.Чулуунбат нарын “Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс” бүтээлд “төр, нийгэм, бие хүний (иргэний) аюулгүй байдал гэдэг нь түүхэн тодорхой нөхцөлд гадаад, дотоодын бодит болон болзошгүй аюулаас үндэсний язгуур эрх ашиг найдвартай хамгаалагдсан байдал” гэж тодорхойлсон байна.

Түүнчлэн аюул ослын хүчин зүйл нь харьцангуй зүйл гэдгийг зөвшөөрөх шаардлагатай бөгөөд учир чухам юунд байна гэвээс тэдгээр нь түүхэн тодорхой нөхцөл, нийгмийн хөгжлөөс хамааралтай байдаг. (Ж.Бор, В.Чулуунбат, 2012)

Шинжлэх ухааны доктор, профессор О.Үржингийн бүтээл, судалгааны ажилд “аюулгүй байдал”-ыг ерөнхий ухагдахуунд харилцан хамаарал бүхий гурван төлөв байдлаар илэрхийлжээ. Үүнд:

1. Аюулаас ангид, өөрөөр хэлбэл аюул байхгүй байдал;
2. Аюулаас хамгаалагдсан байдал;

3. Хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн байдал

Эхний болон хоёр дахь төлөв байдал нь дээр дурдсан “аюулгүй байдал” үзэл санаа нэг юм. Харин гурав дахь төлөв болох “хөгжлийн нөхцөл бүрдүүлсэн” нь “хөгжил” аюулгүй байдлын нэг гол үзүүлэлтийн тодорхойлогч болдог байна.

Харин “Хөгжил” гэдэг үгийг Монгол хэлний их тайлбар тольд¹ нийгмийн шинжлэх ухаанд урагш давших, хөгжин дэгжих явдал, нийгмийн дэвшлийн зүй тогтлууд гэж тодорхойлсон бол Кембрижийн² толь бичигт “development” нь хэн нэгэн болон ямар нэгэн зүйлийн өсөлт эсвэл өөрчлөгдөх үйл явц гэж тодорхойлсон байна.

Улс орны хөгжлийн асуудлуудыг хөндөхөд эдийн засгийн хөгжил асуудлууд салшгүй холбоотой. Учир нь эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтгүй улс орны хөгжлийн түвшинг тодорхойлох боломжгүй юм. Үүнтэй адил эдийн засгийн хөгжил нь эдийн засгийн өсөлтийн функцээс өөр зүйлээр тодорхойлж болохгүйтэй адил.

Britannica толь бичигт³ эдийн засгийн хөгжил (economic development)-ийг хялбар үгээр тайлбарлахдаа бага орлоготой улсаас орчин үеийн аж үйлдвэржсэн эдийн засагтай улс болон хувирах үйл явц хэмээн дурдсан байна. Зарим тохиолдолд тухайн тодорхойлолтыг эдийн засгийн өсөлттэй ижил утгатай хэрэглэгддэг. Ерөнхийдөө эдийн засгийн өсөлт нь тоон утгаас гадна чанарын өөрчлөлтийг мөн дотроо агуулдаг.

Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлтийг илэрхийлдэг гол тоон үзүүлэлт болох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт нь нэг жилийн хугацаанд байнга өсөх үйлдвэрлэлийн хэмжээг хэлдэг бол эдийн засгийн хөгжил гэдэг нь эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлох тоон үзүүлэлтийн өөрчлөлтөөс гадна чанарын хувьд дэвшил гарах (эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, шинэ салбар, шинэ үйлдвэрлэл, шинэ технологи, шинээр ажлын байр бий болох гэх мэт) хэмээн тодорхойлжээ.

Харин аюулгүй байдлын тухай ойлголт нь олон чухал шинж чанарыг дотроо агуулсан байдаг бөгөөд тухайн орны хөгжилтэй аюулгүй байдлын асуудал нь шууд холбоотой байдаг байна. Өөрөөр хэлбэл, сул хөгжил бүхий орны аюулгүй байдал нь баталгаатай биш, харин улс орны хөгжлийн түвшин өндөр бол аюулгүй байдал нь баталгаатай гэж ойлгож болох юм. Тиймээс Монгол Улсын аюулгүй байдал, түүний дотор эдийн засгийн аюулгүй байдлын асуудлаар ярихдаа Монгол Улсын хөгжил дэвшлийн тухай ярихаас өөр аргагүй юм гэж Монгол Улсын Ерөнхийлөгч асан (Н.Энхбаяр, 2002) хэлжээ.

Эдийн засгийн хөгжлийн хэмжигдэхүүнийг эрдэмтэн, судлаачид дараах байдлаар авч үзжээ.

Хөгжлийн судлаач А.Бат-Оргилын тодорхойлсноор хөгжлийг олон улсад дараах үзүүлэлтээр хэмжиж байна. Тухайлбал,

- Хүн амын худалдан авах чадвараар тооцсон (PPP) нэг хүнд ногдох ДНБ,
- Хүний хөгжлийн индекс
- Аз жаргалын индекс
- НҮБ-ын Мянганы хөгжлийн зорилтууд

¹ Эх сурвалж: Монгол хэлний их тайлбар толь (mongoltoli.mn)

² Эх сурвалж: ECONOMIC DEVELOPMENT | definition in the Cambridge English Dictionary

³ Эх сурвалж: Economic development | Britannica

- НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилт болно.

Судлаач эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдийн хамгийн чухал зорилго нь ядуурлыг бууруулж, амьдралын чанарыг сайжруулах гэж үзсэн бөгөөд хөгжлийн гол хэмжих үзүүлэлтэд хөгжлийн индексийг авч үзжээ. (А.Бат-Оргил, 2018)

С.Даваасүрэн өөрийн “Хөгжлийн экономика” лекцийн эмхтгэлд “эдийн засгийн хөгжил” гэдэг нь эдийн засгийн өсөлтөөс гадна өөрчлөлтийг багтаасан ойлголт хэмээн дурдсан байна. Энд хөгжлийн үйл явцад эдийн засгийн өсөлтийг бодвол чанарын хэмжигдэхүүнүүд чухал үүрэгтэй. Чанарын ялгаа нь үйлдвэрлэлийн сайжирсан техник болон хүчин зүйлсийн сайжирсан үзүүлэлтүүдээр илрэн гарч ирдэг. Мөн түүнчлэн эдийн засгийн хөгжил нь институцийн хөгжил, үнэлгээ болон хандлагын өөрчлөлтөд илрэн гарна. Иймээс эдийн засгийн хөгжлийг “бүх нийгмийн системийн урагш чиглэсэн хөдөлгөөн”-өөр тодорхойлж болно. Үүнд хөгжлийн эдийн засгийн хэмжүүрийн тухайд дараах үзүүлэлтийг дурдсан байна.

- Нэг хүнд ногдох ДНБ ба ҮНБ
- ҮНБ-д секторын эзлэх хувийн жин
- Нялхсын эндэгдэл
- Нэг хүнд ногдох хүнсний бүтээгдэхүүний калорийн хэмжээ
- Боловсролын түвшин (бичиг үсэг тайлагдсан байдал)-гээр илэрхийлэх үзүүлэлтүүдийг гаргасан
- Ядуурал
- Орлогын тэгш бус байдал
- Ажилгүйдэл зэрэг үзүүлэлтийг дурдсан байна.

Хөгжиж буй орнуудын нийтлэг жишээн дээрээс дараах хүчин зүйлийг тодорхойлжээ. Үүнд

- Улсын хэмжээ ба орлогын түвшин
- Эдийн засгийн бүтэц
- Аж үйлдвэрийн бүтэц
- Улс ба хувийн секторын харьцаа
- Ядуурлын түвшин
- Ажилгүйдэл хөдөлмөр эрхлэлт
- Хүн амын өсөлт
- Бүтээмжийн түвшин
- Хүний хөгжлийн индекс (С.Даваасүрэн, 2002)

Мэдээж эдгээр олон онолын үзэл баримтлалыг нэгтгэсэн нэг системчилсэн эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт болон босго утгыг гарган ирэхэд хүндрэлтэй юм. Гэвч манай эрдэмтэн, судлаачид өөрийн судалгааны ажлуудад тодорхой параметрээр

эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт болон босго утгуудыг гаргасан байна. Үүнд, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судлаач, доктор Л.Нямцэрэн “Шинэ эриний сорил: Монгол Улсын хөгжлийн нэн тулгамдсан асуудал”, доктор Д.Энхчимэг, Т.Мөнх-Оргил нарын “Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам”, “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал ба Батлан хамгаалах чадавхын өсөлтөд хийсэн дүн шинжилгээ”⁴ (Д.Тунгалаг, 2020) “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикын зарим асуудал” зэрэг бүтээлд эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт болон босго утгуудыг үндсэндээ ижил тодорхойлсон байна.

**Хүснэгт 1. Эдийн засгийн аюулгүй байдалд үнэлэлт өгч буй
нийтлэг шалгуур үзүүлэлт, босго утга**

№	Шалгуур үзүүлэлт	Босго буюу шалгуур
1	ДНБ-ий өсөлт, хувь	5
2	Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрийн эзлэх жин, хувь	70
3	Аж үйлдвэрийн салбарт машин зохин бүтээх үйлдвэрийн эзлэх жин, хувь	20
4	ДНБ-д шинжлэх ухаан, судалгааны ажлын зардлын эзлэх жин, хувь	2
5	ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх жин, хувь	-5
6	Инфляцын түвшин, хувь	20
7	ДНБ-д импортын эзлэх жин, хувь	30
8	Нийт экспортод түүхий эдийн эзлэх жин, хувь	60
9	Хүнсний хэрэглээнд импортын эзлэх жин, хувь	30
10	Нефтийн хэрэглээнд импортоор авч буй хувь, хувь	35
11	Цахилгаан эрчим хүчний хэрэглээнд импортоор авч буй хувь, хувь	30
12	Гурилын хэрэглээнд импортоор авч буй хувь, хувь	30
13	ДНБ-д гадаад өрийн эзлэх жин, хувь	30
14	Ядуурлын түвшин (амьжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой хүн амын эзлэх жин), хувь	10
15	Хүн амын дундаж наслалт, нас	70
16	Эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин, хувь	100
17	Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин, хувь	100
18	Орлого хуваарилалтын харьцаа (хүн амын бүлгийн хамгийн баян 10 хувь ба хамгийн ядуу 10 хувийн дундаж орлого харьцаа)	8-10 дахин

Эх сурвалж: (Д.Энхчимэг, Т.Мөнх-Оргил, 2021), (Д.Тунгалаг, 2020), (Л.Нямцэрэн, 2013)

Харин доктор Д.Энхчимэгийн судалгааны ажилд эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтүүдийг илүү дэлгэрэнгүй авч үзсэн байдаг бөгөөд дараах хүчин зүйлийг тооцож гаргажээ.

Хүснэгт 2. Эдийн засгийн аюулгүй байдлын дэлгэрэнгүй шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Босго утга
Бүтцийн		
1	ДНБ-д импортын эзлэх жин, хувь	30
2	Импортын бүтэц: орноор, нэг орны эзлэх хувь, хувь	<30

⁴ Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал ба Батлан хамгаалах чадавхын өсөлтөд хийх дүн шинжилгээ, (Эрдэм шинжилгээний төслийн ажлын тайлан). ҮБХИС. БХЭШ. -УБ.,2001

3	Нийт экспортод түүхий эдийн эзлэх жин, хувь	60
4	Нийт экспортод эцсийн бүтээгдэхүүний эзлэх жин, хувь	50
5	Экспортын бүтэц: орноор, нэг орны эзлэх хувь, хувь	<40
6	Аж үйлдвэрийн салбарт боловсруулах үйлдвэрийн эзлэх жин, хувь	60
7	ДНБ-д уул уурхайн эзлэх хувь,	<50
	Уул уурхай, олборлолтын хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь	
	ДНБ-д уул уурхайн олборлолтын эзлэх хувь	
8	Аж үйлдвэрийн салбарт машин зохион бүтээх үйлдвэрийн эзлэх жин, хувь	30
9	Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин, хувь	100
10	ДНБ-д шинжлэх ухаан, судалгааны ажлын зардлын эзлэх жин, хувь	2
Технологийн		
11	ДНБ-ий жилийн өсөлт, хувь	5
12	Нэг хүнд ногдох ДНБ, (Дэлхийн банкны атласын аргаар тооцсон нь, ам.доллар)	>1000
13	ДНБ-д элэх улсын нэгдсэн төсвийн ашиг/алдагдал, хувь	-2
14	ДНБ-д эзлэх улсын төсвийн нийт ардал, хувь	40
15	ДНБ-д нийт гадаад өрийн эзлэх жин, хувь	60
16	Нийт гадаад өр/экспорт, харьцаа	150
17	ДНБ-д Засгийн газрын гадаад өрийн эзлэх жин, хувь	25
18	Инфляцийн түвшин, хувь	10
19	Гадаад валютын нөөц (импортын хэрэгцээг хангах түвшин) сараар	3 сар
20	ДНБ-д ГШХО-ын эзлэх жин, хувь	30
	Нийт ХО-д уул уурхай, олборлолтын салбарын ХО-ын эзлэх хувь	
21	Хүнсний хэрэглээнд импортын эзлэх жин, хувь	25-30
22	Нефтийн хэрэглээнд импортоор авч буй хувь	30
23	Цахилгаан эрчим хүчний хэрэглээнд импортын эзлэх хувь	30
24	Эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин, хувь	100
25	Гурилын хэрэглээнд импортоор авч буй хувь	25-30
26	ДНБ-д батлан хамгаалах зардлын эзлэх жин, хувь	2
27	Ядуурлын түвшин (хамралтын хүрээ), хувь	30
28	Орлого хуваарилалтын хурьцаа (хүн амын бүлгийн хамгийн баян 10 хувь ба хамгийн ядуу 10 хувийн дундаж орлогын харьцаа)	8-10 дахин
29	Эрхзүйн хувьд татварын ачаалал, хувь	7.5
30	Ажилгүйдлийн түвшин, хувь	5-6
Хүний хөгжлийн индекс		
31	Хүн амын дундаж наслалт, нас	70
32	Хүн амын өсөлт, хувь	2-3
33	Хүн амын бичиг боловсролын түвшин, хувь	100
34	Гадаад иргэн харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохистой түвшин, хувь	3.5
35	Хүний хөгжлийн индексийн коэффициент	1

Эх сурвалж: (Д.Энхчимэг, Т.Мөнх-Оргил, 2021)

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд илтгэлдээ УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга асан (Н.Баяртсайхан, 2002) эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтэд хөгжлийн зорилтуудыг авч үзсэн бөгөөд босго утга нь шийдвэрлэх зорилтын түвшинг байхаар тодорхойлжээ.

Хүснэгт 3. Зорилтод тулгуурласан эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур

№	Шалгуур үзүүлэлт	Суурь он	Зорих түвшин
Бүтцийн			
1	Экспорт дахь түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний харьцаа	...	50 хувь
2	Үндэсний үйлдвэрлэгчдийн дотоод зах зээлд өрсөлдөх чадвар: Импортын ДНБ-д эзлэх хувь	...	50 хувь
3	Импортын бүтэц: Орноор, нэг орны эзлэх хувь	...	<30 хувь
4	Экспортын бүтэц: Орноор, нэг орны эзлэх хувь	...	<30 хувь
5	Боловсруулах үйлдвэрийн ДНБ-д эзлэх харьцаа	...	30 хувь
Технологийн			
6	Шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулж буй хөрөнгө ДНБ-д харьцуулсан хувиар	...	2-3 хувь
Санхүүгийн			
7	ДНБ-ий жилийн өсөлт	...	5-7 хувь
8	Инфляцийн түвшин, жилийн эцэст	...	Нэг оронтой тоонд байх
9	ДНБ-д нийт өрийн эзлэх жин	...	60 хувь
10	Орлогын ялгаа (жингийн коэффициентээр)	...	0.1
11	Төсвийн алдагдал ДНБ-д харьцуулсан хувь	...	3 хувь доош
12	Ядуурлын түвшин	...	7 хувь
13	Гадаад валютын нөөц (сая ам.доллар)	...	1 жилийн импорт
14	Нэг хүнд ногдох ДНБ оны үнээр (ам.доллар)	...	1000 ам.доллар
Хүний хөгжил			
15	Хүн амын дундаж наслалт	...	70
16	Хүн амын өсөлт	...	2-3 хувь
17	Хүн амын боловсролын түвшин: Бичиг үсэг тайлагдсан байдал	...	100 хувь
18	Эрүүл мэндийн үйлчилгээ (нэг их эмчид ногдох хүний тоо)	...	
19	Ажилгүйдлийн түвшин	...	1-2 хувь хүргэх

Эх сурвалж: (Н.Баяртсайхан, 2002)

Дээрх бүх шалгуур утгууд нь тус бүрдээ үндэслэлтэй бөгөөд эдийн засгийн аюулгүй байдлыг илтгэх үзүүлэлтүүд юм. Гэхдээ зарим шалгуур үзүүлэлтүүдийн утга нь тухайн улс орны аюулгүй байдлыг хангаж чадаж байгаа эсэх талаар судлаачид өнөөг хүртэл нэгдмэл байр суурьтай болж чадаагүй байна.

Иймээс эхлээд эдийн засгийн хөгжлийг олон улсад хэрхэн яаж ангилдаг талаар товч авч үзье. НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO), Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Moody's, Fitch олон улсын зээлжих зэрэглэл тогтоодог байгууллага улс орнуудыг эдийн засгийн хөгжлийн түвшингээр нь дараах байдлаар ангилж өгсөн байна.

НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO):

НҮБ нь Дэлхийн II дайны дараа байгуулагдахдаа улс орнуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор байгуулагдсан бөгөөд улс орнуудын хөгжлийн асуудал, ядуурал, тэгш бус байдал мөн анхаарлын төвд нь байдаг байна. Энэ хүрээнд жил бүр тайлан гаргадаг бөгөөд улс орнуудын хөгжлийн түвшин, ядуурал зэргийг зөв бодитой тодорхойлохын тулд ангилах шаардлага үүсчээ. Ийм учраас тус байгууллагаас Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварын индекс (Competitive Industrial Performance Index) үзүүлэлтүүдийг хөгжлийн түвшнээр нь дараах байдлаар ангилсан байна (Хүснэгт 4). Үүнд:

1. Тэргүүлэх (Top),
2. Дунджаас дээш (Upper Middle),
3. Дундаж (Middle),
4. Дунджаас доош (Lower Middle),
5. Доод хэсэг (Bottom)-ийн улс

Хүснэгт 4. Улс орны хөгжлийн ангилал, босго утга

Тэргүүлэх	Дунджаас дээш	Дундаж	Дунджаас доош	Доод хэсэг
>0.09	0.099-0.04	0.039-0.0174	0.01739-0.0078	0.00778<

Эх сурвалж: UNIDO, *Classifications of countries based on their level of development: how it is done and how it could be done.*

Дэлхийн банк

Дэлхийн банк улс орнуудын хөгжлийн түвшинг ангилахдаа Үндэсний орлого (ҮО) эсвэл нэг хүнд ногдох үндэсний нийт орлого, Үндэсний нийт бүтээгдэхүүн (ҮНБ) ба ДНБ-ний хэмжээг ашигладаг байна (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Дэлхийн банкны улс орнуудын хөгжлийн ангилал, босго утга

Бага орлоготой (Low-income)	Дунджаас бага орлоготой (Lower-middle income)	Дунджаас дээш орлоготой (Upper-middle income)	Өндөр орлоготой (High-income)
Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (оны үнэ US\$) < \$1026	\$1026 - \$3,995	\$3,996 - \$12,375	\$12375 <

Эх сурвалж: *New country classifications by income level: 2019-2020, World bank*

Олон улсын валютын сан (IMF)

Олон улсын валютын сан Дэлхийн банктай ижил аргачлал ашиглаж улс орны хөгжлийн түвшинг тогтоодог. Гэхдээ Олон улсын валютын сан улс орнуудын мөнгө санхүүгийн чадамжтай байдлыг түлхүү үнэлдэг байна. Олон улсын валютын сангийн ангиллаар тэргүүлж буй хөгжилтэй улсын хувьд санхүү, эдийн засгийн хувьд интегралчлагдсан улс бөгөөд харьцангуй санхүүгийн чадамжтай улс гэж үздэг байна.

Харин хөгжиж буй улсын хувьд санхүүгийн хувьд хөгжилтэй орноос илүү хамааралтай улс юм (Хүснэгт 6). Хятад улс санхүү эдийн засгийн хувьд тэргүүлэгч улсын тоонд ордог боловч бие даасан санхүү, зээлийн бодлого хэрэгжүүлдэг тул хөгжилтэй улстай интегралчлагдаагүй байна. Энэ байдал нь Хятад улсыг хөгжиж буй улсын эгнээнд оруулсан байна.

Хүснэгт 6. Олон улсын валютын сангийн улс орнуудын хөгжлийн ангилал

Тэргүүн хөгжилтэй улс (Advanced)	Хөгжиж буй улс (Emerging and developing)				
	Ази	Европ	Латин Америк болон Карибын	Ойрх дорнод болон төв Ази	Сахар болон Африк
39 улс	30 улс	16 улс	30 улс	32 улс	45 улс

Эх сурвалж: IMF, *Classifications of countries based on their level of development: how it is done and how it could be done.*

Даяаршсан өнөө үед улс орнуудын эдийн засаг нэг нэгнээсээ ихээхэн хамааралтай болсон бөгөөд өөрийн циклээ дагаад савлагаа ихтэй. Үүнээс үүдээд дэлхийн эдийн засаг донсолдог бөгөөд энэ нь улс орнуудын ДНБ-ний өсөлт бууралтаас илэрхий харагддаг байна. Тэгэхлээр тогтвортой нэг түвшний өсөлтийг бий болгох үндэслэлгүй юм. Энэ талаар судлаачдын бүтээлд дараах байдлаар тодорхойлжээ. “Зах зээлийн эдийн засаг үргэлж хөдөлгөөнд ордог бөгөөд уналт, зогсонги байдал, сэргэлт, өсөлтийн үе шатыг дамжиж байдаг тул эдийн засгийг өсгөж, тогтворжуулахын тулд төр эдийн засгийн арга механизмыг хэрэглэдэг. Зах зээлийн эдийн засгийн мөчлөгт зөвхөн гадаад, дотоод хүчин зүйлүүд дангаар нөлөө үзүүлдэггүй. Эдгээр хүчин зүйл янз бүрийн хослолоор эдийн засагт нөлөө үзүүлдэг.” (Б.Юмаажав, Т.Мөнх-Оргил, Д.Мөнхбат, 2018)⁵

Зураг 1. ДНБ-ний өсөлтийн динамик, хувь



Тухайлбал, эдийн засгийн хөгжлийг илтгэх гол үзүүлэлтэд ДНБ-ий өсөлтийг таван хувь гэж авч үзсэн байдаг. Зарим судлаач үүнийг тогтвортой таван хувьд барих гэж үздэг.


⁵ “Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж буй зарим асуудлууд” ном. УБ-2018. Ху. 10.

Иймээс уг үзүүлэлтээс илүү эдийн засгийн хөгжлийг илтгэх нэг гол үзүүлэлт болох “худалдан авах чадвараар тодорхойлсон нэг хүнд ногдох ДНБ” эсвэл “нэг хүнд ногдох үндэсний нийт орлого”-ыг ашиглан тодорхойлбол илүү оновчтой юм (Зураг 1).

Дэлхийн II дайны дараа олон улс оронд тусгаар тогтнолоо олж авснаар хөгжлийн эдийн засгийн судлагдахуун эрчимтэй хөгжих болсон байна. Хөгжлийн эдийн засгийн асуудлаар Белл 1989 онд өөрийн “*New Palgrave: A Dictionary of Economics*” тойм өгүүлэлд “Пионер” буюу анхдагчид, “Хоцрогсод” буюу түрүүлж хөгжсөн улсуудыг гүйцэж хөгжих улс гэж ялгасан байдаг⁶. Энэ үүднээс хандвал хөгжиж буй улсыг гүйцэж очихын тулд өнөөгийн байгаа хөгжлийн хурдаа эрс нэмэгдүүлэх ёстой болж байна. Учир нь эдийн засаг хөгжсөн улс хөгжиж буй улсыг гүйцэж ирэхийг хүлээгээд байж байхгүй нь тодорхой.

Иймээс эдийн засгийн аюулгүй байдлын үзүүлэлтийг ДНБ-ий өсөлтийн хувиар бус олон улсад эдийн засгийн хөгжлийг үнэлдэг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогоор тооцсон үзүүлэлтийг авч үзвэл дараах байдалтай байна.

Зураг 2. Эдийн засгийн өсөлтийн аюулгүйн босго



Эх сурвалж: Дэлхийн банкны улс орны ангилалд тулгуурлан тооцоолов

Дүгнэлт, зөвлөмж

Улс орнуудын хөгжлийн ангилалд нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын хязгаар утга нь жил бүр шинэчлэгдэж байдаг. Өөрөөр хэлбэл, дэлхийн эдийн засгийн нөхцөл, тухайн орны эдийн засгийн өсөлт зэргээс хамаарч босго утга нь өсөх буурах хандлагатай тул хөвөгч үзүүлэлт юм. Үүнээс үүдээд эдийн засгийн аюулгүй байдлын

⁶ Classifications of Countries Based on Their Level of Development: How it is Done and How it Could be Done (Nielsen, Publications, 2011), IMF Working Paper, February 2011

хязгаар утгыг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын дундаж хязгаар утгаар илэрхийлж болно. Тухайлбал, 1990 оноос хойш Монгол Улс эдийн засгийн шилжилт хийж дотоодын үйлдвэрүүдээ нураасан нь эдийн засгийн аюулгүй байдал алдагдахад хүргэсэн байна. Харин 2000 оноос эдийн засаг тодорхой хэмжээгээр өссөн нь эдийн засгийн аюулгүй байдлын маш өндөр эрсдэлтэй ангиллаас эрсдэлтэй ангилалд оруулсан байна.

Гэхдээ өнөөг хүртэл бид эдийн засгийн хөгжлийн хувьд буурай орон буюу эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж чадаагүй хэвээр байна. Тухайлбал, Монгол Улсын нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 2018 онд дэлхийн улс орнуудын нэг хүнд ногдох үндэсний нийт орлогоос 1.4 дахин бага буюу 4800 гаруй ам.доллараар доогуур байна. Өөрөөр хэлбэл өнөөгийн бидний эдийн засгийн өсөлт нь улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах хэмжээний хөгжлийн өсөлт байж чадахгүй. Бид дэлхийн дундаж үзүүлэлтэд хүрэхийн тулд 2012 оны ДНБ-ий хамгийн өндөр үзүүлэлт болох 17 хувийн өсөлтөөс 1.5 дахин өсч байж эдийн засгийн аюулгүй байдлын хүрэлцэхүйц нөхцөлийг хангах юм (Зураг 2).

Иймээс эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтэд макро эдийн засгийн үзүүлэлтүүдээс гадна эдийн засгийн хөгжлийн гол үзүүлэлт болох эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтийг авч үзэхдээ өсөлтийн хувийг бус харин хүрсэн түвшин авч үзэх нь илүү оновчтой юм.

Мөн эдийн засгийн аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтэд эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүдийг мөн оруулах бөгөөд тэдгээрийн шалгуур үзүүлэлтийн хязгаар утгуудыг тооцох нь эдийн засгийн аюулгүй байдлын нөхцөл байдлыг илүү бодитой гаргаж ирэх боломж бүрдэнэ.

Эдийн засгийн аюулгүй байдлын судалгаа тэр дундаа эдийн засгийн хөгжлийн судалгаанд засгийн газраас хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил нь их эрэг нөлөө үзүүлж байна. Үүнтэй адил ойрын хугацаанд бусад мега төслүүдийн хэрэгжилтийг хурдасгах хэрэгтэй байгааг харуулсан. Өөрөөр хэлбэл эдийн засгийн аюулгүй байдлын хөгжлийн шалгуур үзүүлэлтэд шууд эерэг нөлөө үзүүлж байна.

-
1. Nielsen, L. (2011). Classifications of countries based on their level of development: how it is done and how it could be done. New York: IMF.
 2. Nielsen, L. (2011, February 1). Publications. Retrieved from International Monetary Fund: <https://www.imf.org/en/Publications/WP/Issues/2016/12/31/Classifications-of-Countries-Based-on-their-Level-of-Development-How-it-is-Done-and-How-it-24628>
 3. Worldbank. (2019, July 01). New country classifications by income level: 2019-2020. Retrieved from World bank blogs: <https://blogs.worldbank.org/opendata/new-country-classifications-income-level-2019-2020>

4. А.Бат-Оргил. (2018). Хөгжлийн тухай онолууд Монголын хөрсөнд. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
5. Б.Юмаажав, Т.Мөнх-Оргил, Д.Мөнхбат. (2018). Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж буй зарим асуудлууд. Улаанбаатар: ҮБХИС-ийн Хэвлэх үйлдвэр.
6. Д.Тунгалаг. (2020). Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал. Улаанбаатар.
7. Д.Энхчимэг, Т.Мөнх-Оргил. (2021). Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам онол, аргазүй, туршлага, шинжилгээ, боломж. Улаанбаатар: "Соёмбо Принтинг" ХХК.
8. Ж.Бор, В.Чулуунбат. (2012). Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. Улаанбаатар: ТЕГ-ын хэвлэх хэсэгт.
9. Ж.Энхбаяр. (2017). Өмнөх үг Ж.Эхбаяр (Монгол Улсын Их хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга). Монгол Улсын аюулгүй байдлын салбар-алманах 2017, (р. 4). Улаанбаатар.
10. Л.Нямцэрэн. (2013). Шинэ эриний сорилт: Монголын хөгжлийн нэн тулгамдсан асуудлууд. Улаанбаатар: Сансудай ХХК.
11. Н.Баяртсайхан. (2002). Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд. In Ү.-и. А. албар, Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал (pp. 14-43). Улаанбаатар.
12. Н.Энхбаяр. (2002). "Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын асуудал" бага хурлыг нээж хэлсэн үг. *Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал*, (pp. 6-13). Улаанбаатар.
13. С.Даваасүрэн. (2002). *Хөгжлийн экономикс*. Улаанбаатар: Жиком ХХК.



Б.ОТГОНСҮРЭН Ph.D
ҮАБЗ-ийн ССХ-ийн
ОУБНСС-ийн Эрхлэгч

БНХАУ-ЫН БАЙГАЛИЙН ХИЙН ХООЛОЙН СТРАТЕГИ БҮС НУТАГТ

Abstract: The economic development is considered extremely important for the maintenance of the political and social stability in China. Its economic security depends on the equilibrium of three variables: economic growth, energy security, and environmental protection.


China's energy strategy and its overseas investments are subjects of an intense debate. Central Asia is a neighbour region, rich in oil and natural gas reserves, which seems the most likely to play an important role in the Chinese strategy to reduce its dependence on energy supplies from the Middle East. China's interests in the region; its energy security strategy, respectively the energy diplomacy and its investments in Central Asia, and the interactions with main supporter countries in the energy field.

Нэг. БНХАУ-ын байгалийн хийн хэрэглээ

БНХАУ-ын байгалийн хийн хэрэглээ 2008-2019 он хүртэлх сүүлийн 10 жилд тасралтгүй өсч байна. Энэ нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIII, XIV таван жилийн төлөвлөгөөний гол зорилт болох ногоон эдийн засаг (绿色经济 хят.) хөгжүүлэх, хотжилтыг нэмэгдүүлэх, нүүрстөрөгчийн хийн ялгаруулалтыг багасгах замаар агаарын бохирдлыг бууруулах зэрэг дотоод хэрэгцээ шаардлагаас үүдэлтэй юм.

Гэвч Хятадын нийт байгалийн хийн хэрэглээний дийлэнх хувийг импортоор хангаж байдаг. Иймээс нэг эх үүсвэрт импортын хараат байдлаас зайлсхийхийн тулд импортын эх үүсвэрээ төрөлжүүлэх сонирхолтой байна. Харин Хятадын байгалийн хийн салбарын бодлого хөгжлийн болон аюулгүй байдлын хүчин зүйлстэй салшгүй холбогдож байдаг.

Зураг 1. БНХАУ-ын байгалийн хийн импорт




Эх сурвалж: Organization of the Petroleum Exporting Countries www.OPECDATA.com

Хятадын Төрийн өмчит байгалийн хий, газрын тосны компани, Төрийн Зөвлөлийн Хөгжил Шинэчлэлийн Хороо, Байгалийн баялаг, эрчим хүчний яам Стратеги судалгааны төвөөс хамтран 2019 онд “БНХАУ-ын байгалийн хийн хөгжлийн тайлан” (China Natural Gas Development Report 2019) гаргасан байна. Тус тайланд дурдсанаар, Гаалийн ерөнхий газраас мэдээлснээр 2018 оны байдлаар байгалийн хийн импорт 90 сая.тонн хүрч өнгөрөгч оны мөн үеэс 31.9 хувиар өссөн байна. Үүнээс хийн хоолойгоор дамжуулан 53.7 сая.м³ байгалийн хий импортолсон нь өнгөрөгч оны мөн үеэс 20 хувь өссөн үзүүлэлттэй буюу нийт импортын 40.5 хувийг эзэлж байна¹. 2019 онд 47.9 тэрбум.м³ байгалийн хий импортолжээ.

Хятадын байгалийн хийн импортыг бүс нутгаар авч үзвэл Евразийн бүс нутгаас Казахстан, Туркменистан, Узбекистан зэрэг улс эх газраар БНХАУ-д байгалийн хийн дийлэнхийг нийлүүлдэг. Төв Азийн энэ гурван улсын дараа нийлүүлэлтийн хэмжээгээр Мьянмар ордог. Хятадад байгалийн хий нийлүүлэгч орнууд тасралтгүй өсөн нэмэгдсээр 2016 онд 16 улсаас авч байсан бол 2018 онд 26 улсаас байгалийн хий импортлох болсон².

Зураг 2. БНХАУ-ын Төв Азийн орнуудаас авсан байгалийн хийн импорт



Эх сурвалж БНХАУ-ын үйлдвэрлэл, мэдээллийн сайт

¹ China natural gas development report 2019 <http://biee.org.cn/ueditor/php/upload/file/20190903/1567476202249928.pdf>

² БНХАУ-ын байгалийн хийн импорт төрөлжиж байна. 中国天然气进口源更加多元 http://www.xinhuanet.com/energy/2019-08/01/c_1124823224.htm

<https://www.chyxx.com/industry/202004/849190.html>

Гол нийлүүлэгч бүс нутгаар авч үзвэл, Хятадын байгалийн хийн импортын сүлжээ Баруун Хятадын Төв Азийн сүлжээ, баруун өмнөд Хятад, зүүн хойд Хятадын Орос Хятадын хоолой гэсэн үндсэн хэсгээс бүрддэг. Төв Азийн шугам нь зурагт үзүүлсэн А, В, С маршрутаар Туркменистанаас Узбекистаны төв хэсгээр дамжин Казахстаны өмнөд хэсгээр Хятадын Шиньжааны Хоргос боомттой холбогдон Хятадын зүүн хэсгийн II, III шугамтай холбогдон цааш 1833 км зам туулан 27 муж хот, засаг захиргааны онцгой бүс Хонконг, шууд харъяат хотын 500 сая гаруй хүний хэрэглээнд очдог ажээ³.

Харин D шугам буюу Туркменистаны Фушинаас Шиньжааны У Чиатай холбогдох шугамаар жилд 30 тэрбум.м³ байгалийн хий нийлүүлэх хүчин чадалтай хоолой баригдаж буй юм. (Зураг 3.)

Зураг 3. Төв Азийн БНХАУ-тай холбогдох байгалийн хий, газрын тосны хоолой



Эх сурвалж: DocumentsMedia/Occasional/China-Central_Asia_Energy_Transit_Community.pdf <https://www.energycharter.org/fileadmin/>

Дээрх шугамаар 2019 онд Төв Азиас 45 тэрбум.м³ байгалийн хий импортолсон нь нийт хоолойгоор тээвэрлэн авдаг байгалийн хийн импортын 90 хувийг эзэлсэн байна. Үүнээс Туркменистан 33 тэрбум. м³ буюу дийлэнх экспортыг хийжээ. (Хүснэгт 1).

Туркменистаны байгалийн хийн илрүүлсэн нөөц 19.5 их наяд.м³ байгаа нь дэлхийн байгалийн хийн нөөцийн 10.1 хувийг эзэлж дэлхийд нөөцийн хэмжээгээр дөрөвдүгээрт орж байна. Газрын тосны илрүүлсэн нөөц 2.3 тэрбум.тн, тооцоолж буй нөөц 50 их наяд.м³ гэж үздэг. Туркменистаны талаас 2030 он гэхэд 2500 их наяд.м³ байгалийн хий олборлож 1800 их наяд.м³ экспортлох зорилт дэвшүүлсэн.

Мөн түүнчлэн Туркменистан нь Хятад Төв Азийг холбосон “Эрчим хүчний торгоны зам” (能源丝绸之路 хят.) -ын эхлэл юм. 2009 онд энэ замыг нээснээс хойш өнөөг хүртэл Хятад ойролцоогоор Туркменистанаас 2400 их наяд.м³ байгалийн хий импортолжээ.

³ 2019年中亚天然气管道向国内输气超479亿方2019 онд 47.9 тэрбум.м³ байгалийн хий импортолжээ http://www.gov.cn/xinwen/2020-01/06/content_5466863.htm

Хоёр улсын засгийн газар “Хятад, Туркменистаны эдийн засгийн түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хоёр улсын ААН-үүдийг эрчим хүчний салбарт хамтран ажиллахыг дэмжихийн зэрэгцээ нефть боловсруулах, шинэ эрчим хүч, автомашин үйлдвэрлэл, дижитал аж үйлдвэр, орчин үеийн хөдөө аж ахуй зэрэг салбарт хамтын ажиллагаа өрнүүлэхээр шамдаж буй ажээ.

Хоёр талын худалдаанд 2010 оноос өмнө Хятадын тал алдагдал хүлээж байгаад Туркменистаны байгалийн хийн экспорт нэмэгдэхийн хэрээр алдагдал буурч байна. 2011 оноос эхлэн Хятад улс Туркменистаны хамгийн том худалдааны түнш байж ирэв.

Хүснэгт 1. Төв Азиас Хятад руу импортлох байгалийн хийн хоолой

	Ашиглалтад орсон	Эхлэх цэг	Хилээр нэвтрэх цэг	Барилга эхэлсэн	Урт км	Багтаамж
Төв Ази А шугам	2009. 12	Гадайм Туркменистан	Хоргос боомт ШУӨЗО	2007	1833км	15 тэрбум м ³
Төв Ази В шугам	2010.10	Гадайм Туркменистан	Хоргос боомт ШУӨЗО	2007	1833 км	15 тэрбум м ³
Төв Ази С шугам	2014.05	Гадайм Туркменистан	Хоргос боомт ШУӨЗО	2012	1840 км	25 тэрбум м ³
Төв Ази D шугам	-	Туркменистан Фушин	У чна ШУӨЗО	2014	1000 км	30 тэрбум м ³

Эх сурвалж: Хятадын 2019-2025 оны шингэрүүлсэн хийн зах зээлийн судалгаа <https://www.chyxx.com/industry/202004/849190.html>

Дээрх нөхцөл байдлаас үзвэл, Хятадын байгалийн хийн импорт Төв Азийн бүс нутаг тэр дундаа Туркменистанаас хараат байдаг аж. Энэ нь дараах бэрхшээлийг үүсгэдэг. Тухайлбал,

Хятадын байгалийн хийн хэрэглээ асар хурдацтай өсч байгаа ч импортоос хамааралтай хэвээр байна. Ялангуяа нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх XIII таван жилийн төлөвлөгөөнд дурдсан инноваци, ногоон эко хөгжил хэмээх зорилтын дагуу нүүрсний хэрэглээг үе шаттай бууруулах болсныг зарласны дараа байгалийн хий хэрэглээ тасралтгүй өсч байна гэж Хятадын судлаачид үздэг. Гэвч гол нийлүүлэгч Туркменистан тогтвортой ханган нийлүүлж чадахгүй байгаа нь Хятадын дотоодод хомстол үүсгэх эрсдэлтэй байдаг.

Улс төрийн тогтворгүй байдал, засаглалын чанарын нөлөө. Импортлогч улсуудад улс төрийн шилжилт явагдаж дуусаагүй улс төрийн бүлэг, фракцуудын ялгаатай байр суурь, ашиг сонирхол нь хамтын ажиллагаанд бэрхшээл авчирдаг. Тухайлбал, 2010 он Кыргызстанд гарсан өнгөт хувьсгалын улмаас Кыргыз, Узбекистаны хооронд үүссэн зөрчлийн улмаас Хятадын Төв Азийн бүс нутаг дахь хөрөнгө оруулалт удааширсан.

Бүс нутаг дахь их гүрнүүдийн манлайллын төлөөх өрсөлдөөн намжаагүй байна. Хятад, Орос улс энэ бүс нутагт өрсөлдөгчид болдог. Тухайлбал, Хятад Орос тус бүр Туркменистантай байгалийн хий импортлох гэрээ байгуулсан. Төд удалгүй 2008 онд Орос шалтгаангүйгээр байгалийн хийн үнэ болон транзит тээврийн үнээ нэмсэн.

Эдийн засаг, санхүүгийн улбаатай саад бэрхшээлүүд бий. Дэлхийн зах зээл дээрх байгалийн хийн үнийн хэлбэлзлийн улмаас нийлүүлэгч тал транзит тээврийн үнээ нэмэхийг шаарддаг. Ингэснээр нэгэнтээ хэлэлцэн тохирсон бүтээгдэхүүний үнэ, чанар,

хэмжээний асуудлаар талуудын хооронд ямагт үл ойлголцол үүсч байдаг. Улс төр, засаглал тогтворгүй байдгаас түүнийг даган хууль эрх зүйн орчин ч байнга өөрчлөгдөж байдаг нь бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг удаашруулж байдаг.

Техникийн шинжтэй маргаан урт хугацаандаа оршсоор байдаг. Олон улсад мөрдөгдөж буй стандартын дагуу дамжуулах хоолойн технологи нь байгалийн хий болон гарын тосны хоолойн хэмжээ чанарт асар их нөлөөлж байдаг. Хоолойн даралт нь хоолойн аюулгүй байдал, явах маршрутыг, технологи нь тээвэрлэлтийн явц дахь алдагдлаа тооцоолоход шийдвэрлэх хүчин зүйл болдог. Гэвч бүтээн байгуулалтын явцад талуудын технологийн асуудлаарх үл ойлголцол, зөрүүтэй байр суурь, ашиг сонирхлын улмаас хоолойн бүтээн байгуулалтын ажил зогсох, саатах тохиолдол түгээмэл оршсоор байна.

Орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгардаг. Нефтийн болон хийн хоолойн асуудал ихэвчлэн хөрөнгө оруулагч улс, хүлээн авагч улсын Засгийн газар, ААН-ийн хамтын ажиллагаа байхаас бус орон нутгийн төлөөллийг ямар нэг байдлаар төдийлөн хамруулдаггүй. Засгийн газар нь хэдийгээр орон нутгийн засгийн газартаа гадаад бодлого, хамтын ажиллагаагаа танилцуулдаг ч орон нутгийн иргэдтэй тулж ажилладаггүй. Ихэвчлэн иргэд нь орон нутгийн засгийн газартаа авлига хээл хахуульд автсан хэмээн итгэх итгэл сул байхын дээр орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн ялгаатай байдал бүтээн байгуулалтын үйл явцад багагүй саад учруулдаг. Хятадын аюул гэх ойлголт ч өдгөө олон улсад хүчтэй хэвээр байгаа тул хилийн чанад дахь Хятадын хөрөнгө оруулалт, иргэдийн аюулгүй байдал хангагдаагүй хэвээр байна.

Орчны бохирдлоос улбаатай асуудал бий. Хийн болон нефтийн хоолойноос үүдэлтэй гол бохирдол нь хоолойноос шүүрч гоожсоноос шалтгаалсан ургамал амьтан болон далайн усыг бохирдуулах асуудал байдаг. Хятадын хийн хоолойн импортоо авдаг хилийн бүс нутаг төдийгүй, экспортлогч зарим улсын экосистем нь сул байхын зэрэгцээ улс орнууд энэ асуудалд төдийлөн дорвитой анхаарал тавьдаггүй учир байгаль хамгаалагчид болон орон нутгийн сайн дурынхан, экологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын эсэргүүцэлтэй тулгарч байдаг.

Уламжлалт бус аюулгүй байдлын эрсдэл нөлөөтэй хэвээр байна. Хятадын байгалийн хийн хоолойн гол нийлүүлэгч бүс нутагт терроризм, экстремизм, сипаратизм буюу “гурван муу хүч”-ний аюул байгаа цагт хийн хоолойд эдгээр аюул занал учрах эрсдэл өндөр хэвээр байна. Иймээс харьцангуй тайван бүс нутгаас хийн хоолой импортлох сонирхол Хятадын талд байх нь дамжиггүй юм. Хятадын зүгээс хилийн чанад дахь хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаа хамгаалах сонирхлоо сүүлийн жилүүдэд тууштай илэрхийлэх болсон. Ийм ч учир ШХАБ-ын хүрээнд байгалийн хийн салбарт хамтран ажиллаж буй орнуудтай аюулгүй байдлын хамтын ажиллагаагаа бэхжүүлэх сонирхолтой байдаг⁴.

Хоёр. БНХАУ-ын байгалийн хийн салбарт баримтлах бодлого

БНХАУ-ын “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөө буюу 2035 хүртэлх урт хугацааны зорилт” (中华人民共和国国民经济和社会发展第十四个五

⁴ Securing Energy Flows from Central Asia to China and the Relevance of the Energy Charter Treaty to China https://www.energycharter.org/fileadmin/DocumentsMedia/Occasional/China-Central_Asia_Energy_Transit_Community.pdf

年规划和2035年远景目标纲要 хят.) -д тусгаснаар эрчим хүчний салбарт хувьсгал хийж, аюулгүй эрчим хүчний систем бий болгож чулуулгийн бус эрчим хүчний салбарыг бүсчилэн төрөлжүүлэн төвлөрүүлж хөгжүүлэх ажээ.


Ингэснээр 2025 онд гэхэд эрчим хүчний чулуулгийн бүтээгдэхүүнийг 20 хувиар 2030 он гэхэд 30 хувиар тус тус бууруулна.

Нүүрс үйлдвэрлэлийн салбарыг эрчим хүчний төрөлжиж төвлөрсөн салбар болгож, нүүрсний хэрэглээг зохистойгоор хязгаарлана.

(Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөө)

Энэхүү бүсчилсэн хөгжлийг дараах байдлаар төсөөлж байна. Тухайлбал, төв болон зүүн бүсэд салхи, нарны эрчим хүчийг төрөлжүүлэх бол баруун өмнөд бүс нутагт далай дээрх усан цахилгаан станц байгуулах ажээ. Мөн түүний зэрэгцээ, далайн эргийн дагуух бүс нутагт цөмийн эрчим хүч үйлдвэрлэх бүтээн байгуулалт өрнүүлнэ. Ингэснээр төрөлжсөн олон эх үүсвэр бүхий ногоон эрчим хүчний сүлжээтэй болж чулуулгийн бус эрчим хүчний эх үүсвэр 20 хувиар өснө гэж тооцоолж байна.

Зураг 4 . БНХАУ-ын эрчим хүчний хэрэглээний бүтэц 2050⁵



Энэхүү бодлогоос бидний сэдэвтэй холбогдон анхаарал татаж буй асуудал бол бүс нутаг дамнасан байгалийн хийн тээвэрлэлтийг боловсронгуй болгож хийн хоолойн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, сүлжээ байгуулна гэж дурдсан явдал юм. Улмаар 2021-2026 онд хэрэгжих таван жилийн төлөвлөгөөний хугацаанд хөрөнгө оруулах төслийн тусгай жагсаалтад Хятад Оросын шинээр байгуулах байгалийн хийн зүүн маршрут орсон байна.

⁵ Б. Отгонсүрэн, Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын хүрээн дэх хамтын ажиллагаа “Стратеги судлал” сэтгүүл 2017

Зураг 5. БНХАУ-ын хийн хоолойн шугамын төвлөрөл

Эх сурвалж: http://www.petrochina.com.cn/ptr/trqygd/commonlist_norig.shtml



Дээрх зурагт үзүүлсэнчлэн Хятадын байгалийн хийн импортын хэрэглээ хүн ам, үйлдвэрлэл төвлөрсөн эдийн засгийн үзүүлэлтээр тэргүүлэгч зүүн өмнөд Хятадын бүс нутагт чиглэдэг байна. Чиглэлийн хувьд авч үзвэл баруун хойноос зүүн тийш чиглэсэн буюу Хятадын нутаг дэвсгэрээр багагүй урт зам туулж эцсийн хэрэглэгчид хүрдэг тул нэгэнт хийн хоолойн бүтээн байгуулалт, дамжин өнгөрөх тээвэрт хангалттай зардал төлж буйн хувьд эцсийн хэрэглэгчид хүргэхэд дөт, альтернатив маршрутаар байгалийн хийг импортлох сонирхол байх нь дамжиггүй юм.

Иймд, Хятадын байгалийн хийн салбарт баримтлах бодлого, үйл ажиллагааны хэтийн төлөвийг багцалж үзье.

Нэгдүгээрт, XIV таван жилийн төлөвлөгөөний хугацаанд Хятад байгалийн хийн олборлолтыг нэмэгдүүлж олон эх сурвалжит импорт бий болгоход хүч хаяж ажиллана.

Хоёрдугаарт, Хятадын макро эдийн засгийн чанар ахиж, хотжилтын цар хүрээ тэлснээр байгалийн хий зэрэг ногоон эрчим хүч нүүрс төрөгчийн ялгарал багатай эрчим хүчний эрэлт өсч байна. Иймд байгалийн хийн салбарт асарт том орон зай бий болж байна⁶.

Гуравдугаарт, БНХАУ-ын дарга Си Зиньпин 2020 онд болсон НҮБ-ын 75 жилийн ойн хуралдаанд "Хятад 2030 он хүртэл нүүрс төрөгчийн ялгаруулалтын хэмжээг нэмэхгүй хязгаарлана, 2060 он гэхэд зохист хэрэглээнд хүргэнэ" гэжээ⁷. Эдгээр амлалт төрийн бодлогод тусгалаа олж байгалийн хийн эрчим хүчний салбарт эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх бодит алхам, түлхэц болж байна.

Дөрөвдүгээрт, Ингэснээр “байгалийн хийн нөөцтэй бол хаан, нийлүүлдэг бол эзэн” хэмээх байр сууринаас өдгөө төрөлжсөн өрсөлдөөний үе шат буюу газар зүйн байршлын давуу тал, яриа хэлэлцээний идэвх, технологи, хөрөнгө оруулалтын давуу талаа ашиглан энэ салбарт хамтран ажиллахын төлөөх өрсөлдөөний төлөв ажиглагдаж

⁶ “十四五”期间天然气发展有五大机遇 XIV таван жил байгалийн хийн салбарт боломж авчирна. https://www.sohu.com/a/440312612_115495

⁷ 碳达峰、碳中和的经济学解读 Нүүрс төрөгчийн оргил үе, зохист хэмжээг эдийн засгийн үүднээс харвал http://www.xinhuanet.com/politics/2021-06/22/c_1127586321.htm

байна.

Тавдугаарт, Байгалийн хийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хадгалалт, борлуулалтын сүлжээ хурдацтай хөгжиж үйлдвэрлэл нь дэд бүтцийн салбараа дагуулан хөгжүүлснээр байгалийн хийн салбар өөрөө эдийн засгийн хөгжлийн түлхэгч хүч болж байна.

Эцэст нь Хятадын бүс нутагт явуулж буй харилцаа хамтын ажиллагаа ялангуяа эрчим хүчний салбарын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд дараах дүгнэлт өгч болно. Үүнд:

- Төв Ази бол Хятадын хөрш орон, бүс нутагт баримтлах гадаад бодлого болон олон талт хамтын ажиллагаан дахь ашиг сонирхлын тэргүүлэх чиглэл мөн. Энэ бүс нутагт худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлж аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэх сонирхол Бээжинд байна. Өөрөөр хэлбэл, Бээжин эдийн засгийн эрх ашиг аюулгүй байдлын эрх ашигт үйлчлэх ёстой гэж үздэг.
- БНХАУ-ын Төв Азийн бүс нутагт явуулж буй бодлого нь юун түрүүн дотоод аюулгүй байдал буюу баруун Хятад болох Шиньжаан Уйгурын Өөртөө Засах Орон (цаашид ШУӨЗО гэх)-ы тогтвортой байдлыг хангахад чиглэдэг. Үндэс угсаа, хэл, соёл, шашны үнэт зүйл нэгтэй Төв Азийн бүс нутгаас “гурван муу хүч” буюу терроризм, хэт даврах үзэл, салан тусгаарлах аюул Ойрх Дорнодоос Төв Азиар дамжин орж ирэх аюул Бээжингийн болгоомжлолыг ямагт төрүүлж байдаг. Баруун Хятадын тогтвортой байдалгүйгээр Хятадын аюулгүй байдал хангагдаж, эдийн засгийн тогтвортой хөгжил үргэлжлэх боломж хомс юм.
- Бээжин урт хугацаанд баруун Хятадын эдийн засгийн хөгжилд анхаарч, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх замаар нийгмийн тогтвортой байдлыг хангах бодлого хэрэгжүүлж ирсэн. ШУӨЗО-ны хуурай газрын хилийн боомтыг түшиглэн баруун Хятадыг “Бүс ба зам” санаачилгын зам тээврийн зангилаа болгосон. Чөлөөт бүсээр дамжуулан худалдаа, эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлж байна. Гэхдээ энэ худалдаа, эдийн засгийн харилцаа нь “түүхий эдийг бэлэн бүтээгдэхүүнээр арилжих” уламжлалт таваарын худалдааны загвараас хэтрэхгүй байна. Хятадын хувьд илүүдэл өргөн хэрэглээний бэлэн бүтээгдэхүүнээ богино зайд, хямд үнээр эрчим хүчний бүтээгдэхүүнээр арилжих нь ашигтай байдаг.
- Төв Азид ЗХУ задран унасны дараа үүссэн орон зайд Хятад их хэмжээний хөрөнгө оруулалт, аюулгүй байдлын хамтын ажиллагаагаар дамжуулан бүс нутагт нөлөөгөө тогтоох, бэхжүүлэх бодлого явуулж байна. Оросын зүгээс Хятадын энэ түрэлтийг сайшаахгүй ч богино хугацаандаа Хятадтай эдийн засгийн хүчин чадлаар өрсөлдөх боломжгүй ч урт хугацаандаа Төв Ази дахь нөлөөллийн төлөө өрсөлдөөн Хятад, Оросын харилцаанд сөв суулгах магадлал бий.

1. China natural gas development report 2019 <http://biece.org.cn/ueditor/php/upload/file/20190903/1567476202249928.pdf>
2. Securing Energy Flows from Central Asia to China and the Relevance of the Energy Charter Treaty to China http://www.petrochina.com.cn/ptr/trqygd/commonlist_norig.shtml
3. Organization of the Petroleum Exporting Countries www.CEICDATA.com
4. БНХАУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөө
5. БНХАУ-ын Худалдааны яам, Хөрөнгө оруулалтын тайлан 2019 Казахстан
6. 中华人民共和国商务部投资指南 2019 哈萨克斯坦
7. БНХАУ-ын Худалдааны яам, Хөрөнгө оруулалтын тайлан 2019 Кыргызстан
8. 中华人民共和国商务部投资指南 2019 吉尔吉斯斯坦
9. БНХАУ-ын Худалдааны яам, Хөрөнгө оруулалтын тайлан 2019 Узбекистан
10. 中华人民共和国商务部投资指南 2019 乌兹别克斯坦
11. БНХАУ-ын Худалдааны яам, Хөрөнгө оруулалтын тайлан 2019 Тажикстан
12. 中华人民共和国商务部投资指南 2019 塔吉克斯坦
13. БНХАУ-ын Худалдааны яам, Хөрөнгө оруулалтын тайлан 2019 Туркменистан
14. 中华人民共和国 商务部投资指南 2019 土库曼斯坦
15. 欧亚地区的能源结构Евроазийн бүс нутгийн эрчим хүчний бүтэц тайлан
16. 中国在中亚：政策的演变 柳丰华 北京大学国家关系学院博士后，中国社会科学院俄罗斯东欧中亚研究所研究员Хятадын Төв Ази дахь “Бодлогын маневр” Лю Фэнхуа, БНХАУ-ын Нийгмийн ШУА-ийн Орос, Алс Дорнод судлалын хүрээлэн
17. 商务部召开例行新闻发布会（2018年5月31日）БНХАУ-ын Худалдааны яам хэвлэлийн бага хурал 2018 он.
18. Б. Отгонсүрэн, Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын хүрэн дэх хамтын ажиллагаа Стратеги судлал сэтгүүл 2017
19. БНХАУ, ШХАБ-ын гишүүн орнуудын худалдаа <http://www.mofcom.gov.cn/xwfbh/20180531.shtml>
20. “十四五”期间天然气发展有五大机遇 XIV таван жилийн төлөвлөгөө байгалийн хийн салбарт боломж авчирна. “ https://www.sohu.com/a/440312612_115495
21. 15.碳达峰、碳中和的经济学解读 Нүүрстөрөгчийн оргил үе, зохист хэмжээг эдийн засгийн үүднээс шинжихүй
22. Хятадын 2019-2025 оны шингэрүүлсэн хийн зах зээлийн судалгаа <https://www.chyxx.com/industry/202004/849190.html>
23. 中国天然气进口气源更加多元 БНХАУ-ын байгалийн хийн импорт төрөлжиж байна. http://www.xinhuanet.com/energy/2019-08/01/c_1124823224.htm
24. 2019年中亚天然气管道向国内输气超479亿方 2019 онд 47.9 тэрбум.м³ байгалийн хий импортолжээ. http://www.gov.cn/xinwen/2020-01/06/content_5466863.htm



С. ЧАНДМАНЬ, Г. ӨНӨРЖАРГАЛ

ҮАБЗ-ийн ССХ-ийн ОУБНС-ийн
Эрдэм шинжилгээний ажилтан

ХӨРШ ОРНУУДАЙ ХАРИЛЦАХ ЭДИЙН ЗАСГИЙН ТЭНЦВЭРГҮЙ ХАРИЛЦАА

Abstract: *The National Security Concept of Mongolia states that, “Mongolia will develop friendly neighbourly relations and wide-ranging cooperation with the Russian Federation and the People’s Republic of China. Concomitantly, strive for regional peace and stability and balanced relations as a whole, taking into account national interests and historical traditions of relations”. In addition, Mongolia’s foreign policy concept highlights the priority of neighboring countries as Mongolia’s leading foreign affairs orientation.*

In terms of political relations, Mongolia has developed balanced relations with Russia and China, but has not been able to establish balanced relations at the economic level. Mongolia’s economic relations with its two neighbors are unbalanced, and foreign trade is highly dependent on one sector, therefore making it vulnerable. China alone accounted for 75 percent of Mongolia’s total exports in 2020 and 45.5 percent of imports, with Russia accounting for 33.3 percent of total imports and 0.8 percent of exports. The share of Russia in Mongolia’s exports has averaged 1-2 percent in recent years, but in 2019 it started dropping below 1 percent.

The economic structure of neighboring countries suggests that foreign trade with China will continue to dominate. Therefore, in order to improve the structure of foreign trade, it is necessary to develop and diversify exports and support different non-mining exports. Without implementing the above mentioned steps, it will be difficult to balance foreign trade with neighboring countries and trade with third countries.

Түлхүүр үг: БНХАУ, ОХУ, Эдийн засаг, Гадаад худалдаа, Хөрөнгө оруулалт

Гадаад харилцаа, хамтын ажиллагаанд хөрш орнууд тэргүүлэх байр суурьтай болох нь

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.4-т “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ” хэмээн заасны дээр Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд хөрш орнуудыг тэргүүлэх чиглэл хэмээн тодотгосон байдаг.

Энэ хүрээнд хөрш орнуудтайгаа сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлж, ОХУ болон БНХАУ-тай Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоож, харилцааны түвшингээ ахиулсан. Мөн өндөр дээд хэмжээний айлчлал, уулзалтуудыг тогтмол хийж, эдийн засаг, нийгэм соёл, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа ч эрчимтэй өрнүүлэн байна.

Эдүгээ хоёр хөрш оронтой улс төрийн өндөр түвшний ойлголцол, найрсаг харилцаатай байгаа бөгөөд шийдвэрлэгдээгүй, маргаантай том асуудал байхгүй, язгуур ашиг сонирхлоо харилцан хүндэтгэх тохиролцоотой. Монгол-Хятад-Орос таван удаагийн дээд хэмжээний уулзалт хийж, гурван талт харилцааг хөгжүүлэх боломж бүрдсэн.

Монгол Улс “Хөгжлийн зам” санаачилгыг хэрэгжүүлэх замаар Хятад, Оросын хооронд байрлах өөрийн газар нутгийн давуу тал, хил дамнасан тээвэр, худалдааг ашиглах өөрийн орны эдийн засгийг хөгжүүлэхийг эрмэлзэж байна.

БНХАУ болон ОХУ-тай хийж буй гадаад худалдааны бүтэц ялгаатай байдаг

Улс төрийн харилцааны хувьд ОХУ, БНХАУ-тай Иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд эн тэнцүү харилцаж байгаа хэдий ч эдийн засгийн хувьд тэнцвэртэй харилцааг хараахан бий болгож чадаагүй байна. Монгол Улсын гадаад худалдаанд хоёр хөршийн эзлэх жинг тоон үзүүлэлтээр нь харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1. 2019 оны Монгол Улсын гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд

Улс	Нийт бараа эргэлт	Экспорт	Импорт	Тэнцэл
	Мянган ам.доллар			
БНХАУ	8,809,592.6	6,772,775.5	2,036,817.1	4,735,958.4
ОХУ	1,797,956.0	68,093.3	1,729,862.7	-1,661,769.4


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Манай хоёр хөрш улс нь гадаад худалдааны нийт эргэлтэд хамгийн өндөр дүнг эзэлж байгаа бөгөөд БНХАУ-тай 8.8 тэрбум, ОХУ-тай 1.8 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. Энэ нь нийт бараа эргэлтийн 77.2 хувийг эзэлж байна.

Монгол Улсын нийт импортын 33.3, экспортын 0.8 хувь нь ОХУ-д ногджээ. Монгол Улс ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүний 90, эрчим хүчний 20 хувийг тус тус импортолдог. Монголоос орос руу экспортлосон бүтээгдэхүүний 79.14 хувь нь эрдэс баялаг, үлдсэн нь мах, махан бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн түүхий эд эзэлжээ. Монгол

Улсын экспортод ОХУ-ын эзлэх хувь олон жилийн турш дунджаар 1-2 хувь байсан бол 2019 онд нэгээс бага хувийг эзлэх болов.


Зураг 1. Монгол Улсын ОХУ, БНХАУ-тай хийсэн гадаад худалдаа (2012-2020)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээрх үзүүлэлтээс харахад, талууд эдийн засаг, худалдааны харилцааг шинэ агуулгаар баяжуулах шаардлагатай байна. Хэрэв Монгол Улс боловсруулаагүй түүхий эдээ хямд үнээр нийлүүлсээр байвал тэнцвэргүй байдал улам лавшрах тул эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилтыг шат дараатай хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Зураг 2. Монгол Улсын экспорт, импортын бүтэц 2020 оны байдлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Схемд дүрсэлснээс үзвэл Монгол Улсын нийт экспортын 75.0, импортын 45.5 хувийг Хятад улс дангаараа эзэлж байна. Бид түүхий нефть, төмрийн хүдэр, зэс болон цайрын баяжмал зэрэг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспортын 90 орчим, үхэр, адууны шир, бог малын арьс болон ямааны угаасан ноолуурыг 100 хувь БНХАУ-д экспортод гаргаж байгаа нь манай нийт экспортын 93.4 хувийг эзэлж байна. Тэр дундаа уул уурхайн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь өндөр байгаа нь Монгол Улсын эдийн засгийг нэг салбараас хэт хараат болгож байгаа юм.

Хүснэгт 2. ОХУ-ын Монгол Улстай хийсэн худалдаа (тэрбум ам.доллар)

	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 Он
Экспорт	1,489	1,851	1,572	1,460	1,084	0,895.6	0.676	1,606	1,734	1,383
Импорт	0,089	0,064	0,041	0,040	0,044	0,35.90	1,219	0,043	0,033	0,038

Эх сурвалж: ITC Trade Map, Russian-trade.com

Өнгөрөгч 2020 онд ОХУ-тай хийсэн гадаад худалдааны бараа эргэлт 1,42 тэрбум ам.доллар байв. Үүнээс ОХУ-аас 1,38 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн импортолсон нь өмнөх онтой харьцуулбал 20,26 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Монгол Улсаас 38,3 сая ам.долларын бараа бүтээгдэхүүн экспортолсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 14,13 хувиар буурчээ. Энэ асуудалд төр засгийн хэмжээнд анхаарал хандуулан 2020 оноос ЕАЭЗХ болон Монгол Улсын хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байгаа билээ. Уг хэлэлцээрийг байгуулснаар Холбооны гишүүн таван орны зах зээлд бараа бүтээгдэхүүн нийлүүлэх боломж бүрдэх тул манай улсын үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд хууль эрх зүйн боломжийг урьтал болгон судлууртай байна.

Хүснэгт 3. ОХУ-ын гадаад худалдаанд Монгол Улсын эзлэх хувь


	2018 он (хувиар)	2019 он (хувиар)	2020 он (хувиар)
Гадаад худалдаа	0,2398	0,2653	0,2504
Экспорт	0,3571	0,4103	0,4112
Импорт	0,0182	0,0138	0,0166

Эх сурвалж: Russian-trade.com

Монгол Улс ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүний 90 хувь, эрчим хүчний 20 хувийг¹ импортолж байна. Монгол Улсын экспортод ОХУ-ын эзлэх хувь олон жилийн турш дунджаар 1-2 хувь байгаагаас гадна манай гадаад худалдааны нийт алдагдлын 70 орчим хувь зөвхөн ОХУ-тай хийж буй худалдаанд ногддог. 2019 онд ОХУ-тай нийт 1.79 тэрбум ам.долларын худалдаа хийснээс Монгол Улсын экспорт 68 сая ам.доллар, импорт 1.72 тэрбум ам. долларт хүрч, худалдааны тэнцэл 1.66 тэрбум ам.долларын алдагдалтай гарав. ОХУ-тай хийж буй худалдаа нь Монгол Улсын нийт худалдааны эргэлтийн 13 хувьтай тэнцэж байна.

¹ Монгол Улсын эрчим хүчний нийт хэрэглээ 6965 сая кВт.цаг байдгаас 20 хувь буюу 1373 сая кВт.цаг цахилгааныг ОХУ-аас импортолдог. Эрчим хүчний хэрэглээний жилийн дундаж өсөлт 5,1 хувь байгаа явдал цаашид ОХУ-аас нэмж эрчим хүч импортлоход хүргэж байна.

Зураг 3. Экспортын гол түнш улсууд, дүнд эзлэх хувиар /2019/



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Монгол Улсын гадаад худалдааны түнш улсуудын тоо жилээс жилд нэмэгдэж 2019 онд нийт 76 улсад экспорт хийсэн байна. Манай улсын экспортын бүтцэд 1992 онд БНХАУ 17.8, ОХУ 58.5 хувийг тус тус эзэлж байсан бол 2019 онд БНХАУ-ын эзлэх хэмжээ 88.9, харин ОХУ-ын эзлэх хэмжээ 0.9 хувьд хүрч, хоёр хөршийн байр эсрэгээр солигджээ. Энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болоод Гадаад бодлогын үзэл баримтлалын хоёр хөрштэй хамаарал бүхий зүйл заалт улс төрийн харилцааны хувьд Иж бүрэн стратегийн түншлэлийн хэмжээнд хөгжин нийцэж байгаа мэт боловч түүний илрэл болох эдийн засгийн үзүүлэлтийг хойд хөршийн хувьд анхаарах шаардлагатай байна.

Ийнхүү гадаад худалдаанд Хятадтай хийж буй худалдаа давамгайлж байгаа тул бүтцийг нь дэлгэрүүлж харуулав. “Монгол Улс, БНХАУ-ын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал”-д хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, худалдааны хэмжээг жилээс жилд нэмэгдүүлнэ гэж заасан. 2014 онд шинэчлэн байгуулсан “Монгол Улс, БНХАУ-ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг 2014-2020 онд хэрэгжүүлж найрсаг, эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар худалдааны эргэлтийг 2020 онд 10 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавьсан юм.

Монгол-Хятадын худалдааны хэмжээ 1990 онд 33.6 сая ам.доллар байсан бол 2018 онд 8.47 тэрбум ам.долларт хүрсэн нь 28 жилийн дотор 252 дахин нэмэгдсэн байна. Энэ нь хоёр орны худалдааны хэмжээ дээд цэгт хүрсэн үзүүлэлт юм.


**Хүснэгт 4. Монгол Улс БНХАУ-тай хийсэн гадаад худалдаа
(сая ам.доллар, экспорт, импортоор)**

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Худалдааны эргэлт	5529	6841	5300	4962	6720	8474	8809	7403
Экспорт	3706	5073	3910	3901	5307	6505	6789	5493
Импорт	1822	1767	1389	1061	1412	1969	2060	1910

Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

2020 оны байдлаар нийт бараа эргэлтийн 57 хувь буюу нийт экспортын 72.5, импортын 35.8 хувь нь Хятад улсад ногдож байна.

Зураг 4. БНХАУ-тай хийсэн гадаад худалдаа (2011-2020 он, эзлэх хувиар)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо, 2020

2020 оны байдлаар БНХАУ-тай 6.1 тэрбум ам.долларын худалдаа хийсэн нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 58.1 хувийг эзлэв. БНХАУ-аас импортолсон барааны 6.1 хувийг цахилгаан эрчим хүч, 7.7 хувийг ачааны тэрэг, 86.3 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлжээ.

Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй барааны бүтцийг харвал, чулуун нүүрс, алтны өсөлтөөс голлон хамаарч зэсийн баяжмал, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефть, цайрын хүдрийн баяжмал, жонш, молибдений баяжмал, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнүүд нь нийт экспортын 88.6 хувийг бүрдүүлж байгаа бол угаасан ноолуур, самнасан ноолуур, хонины ноос нь нийт экспортын 4.6 хувийг эзэлж байна. Тухайлбал, Монгол Улсаас төмрийн хүдрийг 99.9, чулуун нүүрсний 98, зэсийн баяжмалын 100, молибдений баяжмалын 70.2, хайлуур жоншны 75.8 хувийг тус тус БНХАУ руу экспортолж байна (УУХҮЯ, 2019). Ийнхүү Хятадын эдийн засгийн байдал, худалдан авалт, эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ямар байхаас Монгол Улсын эдийн засгийн байдал шууд хамаарч байна.

Нөгөөтэйгүүр, БНХАУ-ын нийт мах, махан бүтээгдэхүүний импортын 17, ноос ноолуурын түүхий эдийн 3, хүдрийн импортын 2 хувь нь Монгол Улсад ногдож байгаа (Trade map, 2018) нь Монголын экспортоос хамаарал багатайг илтгэж байна. Үүнээс дэлгэрүүлж харвал, БНХАУ угаагаагүй ноолуурын нийт импортын 91 хувь, коксжих нүүрсний импортын 28 хувь, хотын хог хаягдлыг шатаахад гарсан болон шаар импортын 64 хувийг Монголоос авдаг байна (Trade map, 2018).

Ийнхүү Монгол Улсын Хятад болон Оростой харилцах эдийн засгийн харилцаа тэнцвэргүй төдийгүй гадаад худалдаа нэг салбараас хамааралтай, эмзэг байдалтай хэвээр байна. Гэхдээ үүнийг богино хугацаанд тэнцвэржүүлэх аргагүйн дээр хөрш орнуудын эдийн засгийн бүтцээс харвал, цаашид ч гадаад худалдаанд Хятадтай хийх худалдаа давамгайлсаар байх дүр зураг харагдана. Учир нь,

1. Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүнүүд нь нүүрс, зэсийн хүдэр, алт, төмрийн хүдэр, газрын тос зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн байдаг. Гэтэл эдгээр уул уурхайн бүтээгдэхүүний гол хэрэглэгч зах зээл нь өмнөд хөрш БНХАУ бөгөөд эрэлтийн тоо хэмжээгээрээ дэлхийд тэргүүлдэг. Иймд газар зүйн дөт байрлалаа ашиглан тус том зах зээлд байр сууриа олох нь манай улсын хувьд чухал ач холбогдолтой байдаг.
2. ОХУ-ын хувьд нутаг дэвсгэр нь байгалийн баялаг ихтэй, дэлхийд гол экспортлогч орон болохоор зорьдог тул манай экспортын бүтээгдэхүүний зорилтот зах зээл биш харин зарим талаар өрсөлдөгч болдог.
3. Мөн далайд гарах гарцын хувьд ч Хятадын газар нутгаар дамжин өнгөрөх нь дөт байдаг.

Иймд ОХУ болон БНХАУ-тай хийж буй гадаад худалдааны бүтэц ялгаатай хэвээр байгаа нь цаашид ч үргэлжлэх болов уу. Гадаад худалдааны бүтцийг сайжруулахын тулд экспортын нэр төрлөө олшруулах, төрөлжүүлэх, уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих шаардлагатай байна. Ингэхгүйгээр хөрш орнуудтай хийх гадаад худалдаа, цаашлаад гуравдагч оронтой хийх худалдааг тэнцвэржүүлэхэд хүндрэлтэй юм.

Хөрөнгө оруулалт, хөнгөлттэй зээл тусламжийн хэмжээгээр Хятад тэргүүлж байна

Монгол Улс “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-даа эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалтын үүрэг, ач холбогдлыг дараах гурван байдлаар үнэлж байгаагаа тусгасан байна.


Нэгдүгээрт, гадаадын аль нэг орноос орж ирэх хөрөнгө оруулалт нь нийт гадаадын хөрөнгө оруулалтын 1/3-аас багагүй байх бодлого баримталж, гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлан, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

Хоёрдугаарт, гадаадын хөрөнгө оруулалтаар дамжуулан дотоодын капитал хуримтлалыг нэмэгдүүлж, удирдлагын ур чадвар, технологийг сайжруулснаар дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулна.

Гуравдугаарт, дотоодын аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг сайжруулснаар хилийн чанадад хөрөнгө оруулалт, худалдаа хийх дотоодын аж ахуйн нэгжүүдийг бий болгосноор экспортын баримжаатай эдийн засгийн өсөлтийг хангана гэжээ. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүйгээр гадаадын хөрөнгө оруулалтын зохистой бодлогыг хэрэгжүүлж чадвал богино болон урт хугацааны хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт чухал ач холбогдолтой байхаар хөгжлийн бодлогод тусгажээ. Гэвч бодит байдал дээр энэ бодлого хэрэгжихгүй байна.

2019 оны байдлаар Монгол-Хятадын хооронд хийсэн худалдааны хэмжээ 4.4 тэрбум ам.долларт хүрч нэмэгдээд байгаа ба 1990-2019 оны эхний хагас жилд Монгол Улсад бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо 14 мянга орчим байгаа бол үүний 50 хувь нь Хятад улсаас байна. Энэ хугацаанд БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалт 5.1 тэрбум ам.долларт хүрч, нийт гадаадын хөрөнгө оруулалтын 20.1 хувийг эзэлж байна(nda.gov.mn, 2019).

Зураг 5. ГШХО улсаар, дүнд эзлэх хувь, 2011 ба 2019



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Монгол Улсын хувьд ГШХО-ын орох урсгалын 70 гаруй хувийг уул уурхай, олборлох салбарт байгаа нь нэг салбарт хэт өндөр төвлөрөлтэй болгодог (Д.Ган-Очир, 2019). Ерөнхийдөө Монгол Улсын нийт хөрөнгө оруулалтын 80 орчим хувийг 2008-2012 оны хооронд хийсэн бөгөөд шинэ хөрөнгө оруулалтын хууль хэрэгжсэнээр 2013 оноос буурсан гэж үздэг (商务部国际贸易经济合作研究院, 2018年版).


2010 оны байдлаар БНХАУ-аас Монгол Улсад 5303 компани 2.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулж нийт хөрөнгө оруулалтын 50 орчим хувийг эзэлж байсан бол 2011 онд 35 хувь болж буурчээ (Б.Ариунзул, 2012). Энэ нь 2010 онд батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан нэг орны хөрөнгө оруулалт нийт гадаад хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй гэх заалтад хүрсэн.

Сүүлийн жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалт ихээхэн буурсан хэдий ч нийт дүнд Хятад, Хонконгоос оруулсан хөрөнгө оруулалт давамгайлж байна. Хөнгөлттэй зээл, тусламжийн эх үүсвэрийг 2018 оны байдлаар авч үзэхэд БНХАУ-ын Эксим банкны санхүүжилт нийт санхүүжилтийн 34, Японы Засгийн газар болон Жайкагийн санхүүжилт 25, Азийн хөгжлийн банк 21 хувийг тус тус эзэлжээ.

Харин 2018 оны байдлаар Монгол Улсад орсон БНХАУ-ын хөрөнгө оруулалт 4.6 тэрбум ам.долларт хүрсэн буюу нийт ГШХО-ын үлдэгдлийн 23.5 хувийг эзэлж байна (УУХҮЯ, 2019). Хятадын хөрөнгө оруулалтын 70 орчим хувийг геологи, уул уурхайн

эрэл хайгуул, олборлолт, 22 хувь худалдаа, нийтийн хоолны салбарт, 2.3 хувь барилгын салбарт ногдож байна (ГХЯ харилцааны лавлах, 2018).

Зураг 6. Монгол Улсад 1991-2017 онд олгосон хөнгөлттэй зээл улс орнуудаар (тэрбум ам.доллар)



Дээрх графикаас үзвэл Хятадаас Монгол Улсад олгож буй хөнгөлттэй зээлийн хэмжээ ч бусад зээл олгогчийн хэмжээнээс давсан байдалтай байна. Хоёр талын гадаад худалдаа нь уул уурхайн бүтээгдэхүүнийг өргөн хэрэглээний бэлэн бүтээгдэхүүнээр арилжсан бүтэцтэй болно. БНХАУ-ын хөрөнгө оруулалт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 32 хувийг эзэлж буй тоон үзүүлэлт байдаг ч, ЕХ-ны зарим орны “оффшор” компанийн хөрөнгө оруулалтыг эс тооцвол үндсэндээ 60 хувийг эзлэх хэмжээнд байна.

Дүгнэлт

Монгол Улсын гадаад бодлогын тэргүүн зорилтын хүрээнд хоёр хөрштэй харилцах харилцаанд эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангах талаар баримт бичгүүдэд тусгаж ирсэн ч БНХАУ худалдааны хамгийн том түнш, хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр болоод байна.

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн түүхий эдийн экспортоос хэт хамааралтай байдал нь нэг зах зээл болон үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай эдийн засгийн эмзэг байдлыг бий болгожээ. Түүнчлэн хоёр улстай харилцахад “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална” (Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.2.2) хэмээн заасан хөрөнгө оруулалтын хэмжээг хадгалж чадахгүй байна. Энэ нь Монгол Улсын эрдэс баялгийн гадаад зах зээл, дотоодын эдийн засгийн хүндрэл, хөрөнгө оруулалтын орчин зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой.

Хэдийгээр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал зэрэг бодлогын үндсэн баримт бичгүүддээ аливаа улстай тэнцвэртэй харилцах, хэт хараат байдалд орохоос сэрэмжилсэн зүйл, заалтууд тусгасан авч, хэрэгжилт төдийлөн хангалтгүй байна. Тиймээс цаашид баримт бичгүүдэд тусгасан заалтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Монгол Улс эдийн засгийн салбарт ОХУ, “Гуравдагч хөрш”-ийн улсуудын сонирхлыг бий болгохоор ажиллах хэрэгтэй. Ингэхдээ Хятадын одоо байгаа эдийн засагт эзлэх жинг бууруулах биш харин ОХУ болон “Гуравдагч хөрш”-ийн улсуудын оролцоог тэр түвшинд хүргэх юм.

-
1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, <https://www.legalinfo.mn/annex/details/8070?lawid=6163>
 2. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Гадаад худалдаа 2019, хуудас 10
 3. Торговля между Россией и Монголией, <https://russian-trade.com/reports-and-reviews/2020-02/torgovlya-mezhdu-rossiye-i-mongoliey-v-2019-g/>
 4. Bilateral trade between Mongolia and Russian Federation in 2020, <https://www.trademap.org/Bilateral.aspx?nvpm=1%7c496%7c%7c643%7c%7cTOTAL%7c%7c%7c2%7c1%7c2%7c1%7c1%7c%7c1%7c1%7c%7c1>
 5. Bilateral trade between Mongolia and China in 2020, <https://www.trademap.org/Bilateral.aspx?nvpm=1%7c496%7c%7c156%7c%7cTOTAL%7c%7c%7c2%7c1%7c2%7c1%7c1%7c%7c1%7c1%7c%7c1>
 6. Монгол Улсын эрчим хүчний яамны статистик мэдээлэл, <https://energy.gov.mn/content?t=3>
 7. Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны статистик мэдээ, <http://mmhi.gov.mn/public/files/id/36>
 8. 41 тэрбум юаний хөрөнгө оруулалттай 53 хамтын ажиллагааны гэрээ байгуулах төсөл, <http://nda.gov.mn/1567.html>
 9. Д.Ган-Очир, Хөрөнгө оруулалтын орчин: Тогтвортой байдал, Улаанбаатар, Монгол Банк, 2019
 10. Б.Ариунзул, Б.Индра,Ц.Энх-Уянга, Монгол дахь Хятадын хөрөнгө оруулалттай компаниудын өгөөж, Улаанбаатар, Стратеги судлал No.59, 2012
 11. Гадаад харилцааны лавлах 2018, mfa.gov.mn
 12. 商务部国际贸易经济合作研究院, 对外投资合作国别指南- 蒙古国, <http://www.caitec.org.cn/>



Е.И.ЛИШТОВАНЬИ
ОХУ-аас Монгол Улсад
суугаа ЭСЯ-ны зөвлөх

ОРЧИН ҮЕИЙН ОРОС–МОНГОЛЫН ХАРИЛЦАА

Орос, Монгол улс олон зууны түүхэн холбоотой. Энэ удаад тухайлсан түүхэн харилцааг гүнзгий өгүүлэх нь илүүц бөгөөд энэ нь түүх судлаачдын хэрэг билээ.

Гэсэн хэдий ч Орос-Монголын хамтын ажиллагааны орчин цагийн байдлыг илэрхийлэхийн тулд хоёр орны түүхэн харилцааны чухал үеүүдийг цухас дурдах нь зүйн хэрэг хэмээн үзэж байна.

Оросын эрх баригчид XVII зууны үед дорно зүг рүү ихэд анхаарал хандуулах болж мөн үед Орос болон Манж Чин гүрний сонирхол Монгол Улсад огтлолцож байв. Чингэхдээ Оростой хил залгаа бүс нутгийг судлах тусгайлан бэлтгэгдсэн судлаачид хэрэгтэй байлаа. Улмаар 1725 онд Эрхүү хотын Вознесенскийн сүмийн дэргэд Монголоор дамжин Бээжин хүрэх үнэн алдартны шашины ухуулагч нарыг бэлтгэх хэлний дамжаа хичээллэж хятад, манж хэлнээс гадна монгол хэл зааж эхэлжээ.

Судлаачид XIX зууныг Оросын монгол судлалын оргил үе гэдэгт санал нэгтэй байдаг. Санкт-Петербург болон Казаний их сургуулиудад монгол судлалын тэнхмүүд байгуулагдаж Н.М.Пржевальский, П.К.Козлов, Г.Н.Потанин, Н.М.Ядринцев зэрэг гарамгай эрдэмтдийн Азийн экспедицийн үе эхэлсэн байдаг. Оросуудын монгол түмний ахуй амьдрал, соёл уламжлал, эрхэлдэг аж ахуйтай танилцах үйл хэрэгт тэдгээр эрдэмтний оруулсан хувь нэмрийг үнэлж баршгүй билээ.

XIX зууны хоёрдугаар хагасаас нийслэл өргөөнд Оросын Ерөнхий консулын газар нээгдсэнээр Орос-Монголын харилцаа тогтворжиж хоёр орны улс төрийн харилцаанд чухал үйл явдал болов. Оросын хувьд Монгол Улсын чиглэлд баримтлах бодлогоо хэрэгжүүлэх боломжууд бий болов. Консулын газрын дэргэд орчуулагчийн дугуйлан нээгдсэнээр зуу гаруй мэргэжилтэн бэлтгэгдэн гарч байв.

Монгол Улс тусгаар тогтнолоо зарласан даруй буюу 1911 оноос эхлэн бүрэн эрхт байдлаа бодитоор олж авахад Оросын зүгээс бүх талын дэмжлэг үзүүлж байв. Улмаар 1912 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Орос, Монголын Найрамдлын хэлэлцээр

байгуулагдаж хоёр орны харилцан хүлээн зөвшөөрсөн анхны эрх зүйн баримт бичиг болов. Хэлэлцээр байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн гавьяатан бол И.Я.Коростовец бөгөөд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины 2014 оны есдүгээр сарын 3-ны Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр түүний дурсгалыг мөнхөлж Улаанбаатар хотод байрлах Оросын боловсрол, соёл, шинжлэх ухааны төвийн дэргэд хүндэтгэлийн хөшөө босгосон билээ.

1921 оны ардын хувьсгал ялсны дараахан мөн оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Монгол Улстай найрамдалт харилцаа тогтоох хэлэлцээр байгуулсан анхны улс нь ЗСБНХУ болсноор цаашид эрх тэгш, харилцан хүндэтгэлтэй харилцах бат бөх суурь болж өгөв. Өдгөө 100 жилийн ойг тэмдэглэж байгаа тус баримт бичиг нь хоёр орны бүрэн бүтэн байдлыг бататгасан төдийгүй тухайн цаг үедээ дипломат болон консулын харилцааны эрх зүйн үндэс болохын зэрэгцээ орчин үеийн эдийн засгийн хамтын ажиллагаа, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, улсын хилийн тухай зэрэг хэлэлцээрийн суурь болов. Товчхон хэлбэл өнгөрснийг орчин үетэй холбох гүүр гэж хэлж болох хэлэлцээр байв.

Орос, Монгол хоёр улс олон ээдрээтэй бартаат замыг хамтдаа туулах тавилантай байсан аж. Халхын голын дайнд Японы хүчийг хамтын хүчээр бут цохисон нь манай хоёр орны түүхэнд тодоор дурсагдах үйл явдал мөн. Улаан армийн анги нэгтгэлүүд 1939 онд Монголын цэрэг эрстэй мөр зэрэгцэн японы эзлэн түрэмгийлэгчдийг бут ниргэн Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдлыг хамгаалсан билээ.

Аугаа эх орны дайны он жилүүдэд Монгол, Оросын ард түмний найрамдал улам илүү батжив. Фашизмтай тэмцсэн хамгийн хүнд жилүүдэд тусалсан Монгол нөхөддөө Орос орон машид талархаж явдаг билээ. Зөвхөн 1941 оны жишээ баримтаас дурдвал 65 сая төгрөгийн дүн бүхий 140 чингэлэг туслалцааг Зөвлөлтийн дайчдад илгээж байв. "Внешторг" банкины дансанд 2,5 сая төгрөг, 100 мянган ам.доллар болон 300 кг алт шилжүүлж байв.

Ялтад 1945 оны хоёрдугаар сард болсон бага хурлаар ЗХУ-ын зүгээс зайлшгүй нөхцөл байдлын улмаас Японтой дайн зарлаж Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрөх асуудлыг хөндөв. Тухайн үед Дэлхийн II дайн болон хүйтэн дайны зааг дээр Монгол Улс тусгаар улс хэмээх статусыг олж авах цор ганц боломж байсан гэдэгтэй ихэнх судлаачид санал нэгддэг. Энэ бол Монгол Улсын хувь заяаг шийдвэрлэх "алтан" боломж байв. Хэрэвзээ тухайн үед Монгол Улсын статус-кво шийдэгдээгүй байсан бол одоо ямар байдалтай байх нь тодорхойгүй байх байв.

Дэлхийн II дайны хүнд үед ихээхэн хохирол амсаж байсан зарим улс орнууд одоо цагт дайны үр дүнг мушгин гуйвуулах, түүхэн үнэнг гажуудуулах оролдлого хийж байгаа нь харамсалтай. Гитлерын эсрэг эвсэлтэй тулалдаж явсан эсвэл нацистуудтай хамтарч байсан этгээдүүдийг ардын баатар, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний баатар мэтээр өргөмжлөх оролдлого тасрахгүй байна. Өрнөдийн орнуудад залуу үеэ түүхэн гажуудсан баримтаар боловсруулж байна.

Дайны дараагаар Монгол Улсын олон улсын бодлогод идэвхтэй оролцох эрмэлзлийг дэмжин Зөвлөлт засгаас Монгол Улсын НҮБ-д элсэх асуудлыг тал бүрээр дэмжиж байв. Үүний үр дүнд 1961 онд тус байгууллагын бүрэн эрхт гишүүн болсон юм.

Социализмын үеийн манай хоёр орны харилцааг илүү дутуу үггүйгээр маш сайн харилцаатай байсан гэж болно. ЗХУ болон бусад социалист орны туслалцаатайгаар Монгол Улс асар их амжилтад хүрсэн билээ. Тухайлбал, шинэ хот, тосгон, үйлдвэр комбинат, эрчим хүчний станцууд, уулын баяжуулах үйлдвэр, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн салбар хөгжиж, эрүүлийг хамгаалах болон боловсролын салбарын тогтолцоо шинэ түвшинд гарав. Тэр л үе их бүтээн байгуулалтын үе байсан бөгөөд өнөө цагийн үндэс суурь болон үлджээ.

Бид олон салбарт ул мөрөө үлдээж хамтын ажиллагааны арвин туршлага хуримтлуулсан билээ. Орос, Монголыг оюун санааны төдийгүй соёлын ойр харилцаа холбож байдаг. Монгол Улстай шууд болон дам байдлаар холбогдоогүй орос хүнийг олоход бэрх. Учир нь тухайн цаг үед барилгачин, геологич, эмч зэрэг мянга мянган оросууд монголд ажиллаж амьдарч, зарим нь алба хааж байхдаа нөхөрлөж сайн харилцаатай байсан тохиолдол цөөнгүй бий. Мөн хэдэн арван мянган монгол залуус Оросод дээд боловсрол эзэмшсэн байдаг. Энэ бол манай хоёр орны хамтын ололт амжилт юм. Бид хүнд хэцүү 1990-ээд оныг даван туулсан, харин одоо шинэ нөхцөл байдалд уялдуулан ашиг сонирхлын нийтлэг огтлолцлуудыг тодорхойлж хамтын ажиллагаагаа хөгжүүлэх үлдлээ.

Манай хоёр оронд болж өнгөрсөн суурь өөрчлөлтүүдтэй холбоотойгоор орчин үеийн олон улсын харилцааны энэ үед бид цаашид илүү нягт хамтран ажиллах болов. Хоёр орныг хагаралдуулахуйц улс төрийн шийдэгдээгүй асуудлууд бидэнд байхгүй билээ. Хилийн 3,5 мянган километр үргэлжлэх зурвас биднийг ойртуулж найрамдлын хил болж байна. Бид өмнөх шигээ хоёр улсын харилцааг нягт байлгах эрмэлзэлтэй.

Улс төрийн салбарт. Хоёр болон олон талт өндөр дээд хэмжээний уулзалтын механизм тогтмолжив. Манай хоёр орны төрийн тэргүүн нар Орос-Монгол-Хятад гэсэн гурван талт форматыг үр дүнтэй ашиглаж байгаа бөгөөд талууд өөрийн байр сууриа НҮБ-ын хүрээнд тодорхойлдог.

Холбооны зөвлөл болон УИХ-ын хамтын ажиллагаа төрийн болон эдийн засгийн бүтэц зохион байгуулалт, үндэсний аюулгүй байдлыг хангах, хүн амын нийгмийн хамгааллын зэрэг салбарын хууль тогтоох үйл ажиллагааны туршлага солилцох зорилгоор парламентын салбар хороод хамтран ажиллаж байна. ОХУ-ын бүс нутгуудын хууль тогтоох, төлөөлөгчдийн байгууллага болон Монгол Улсын аймгуудын ИТХ хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэхэд хоёр талаас хүчин чармайлт гаргаж төлөвлөгөөндөө тусгаж байгаа нь бүс нутаг болон хил орчмын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүд ялангуяа зэргэлдээ оршин буй аймаг, хотын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Худалдаа-эдийн засгийн салбарт. Орос, Монгол хоёр улсын гадаад худалдааны эргэлт 2020 оны байдлаар 1,4 тэрбум ам.долларт хүрэв. Худалдаанд жин дарж буй салбар бол Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” ХНН бөгөөд Монгол Улсын ачаа тээврийн салбарт хамгийн үр ашигтай ажиллаж буй байгууллагуудын нэг юм. Сүүлийн үед Европ-Хятад чиглэлийн транзит тээвэр өсөн нэмэгдэж байгаа нь Орос-Монгол-Хятад гурван улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хөгжүүлэхэд төмөр замын салбарт чухал үүрэг гүйцэтгэж буйн илрэл. 2019 онд баталсан “УБТЗ” ХНН-ийн техник хангамжийг 2030 он хүртэл шинэчлэн

хөгжүүлэх хөтөлбөр үргэлжилж байгаа бөгөөд төмөр замын дамжин өнгөрүүлэх, нэвтрэх чадамжийг жилд 54 сая тонн хүргэх эцсийн зорилготой ажиллаж байна.

Мөн Улаанбаатарын ТЭЦ 4-ийг “Уралын турбины завод” ХХК-тай хамтран шинэчлэх ажлыг амжилттай дуусгасан нь эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлж байгаагийн илрэл юм. Үүний үр дүнд тус станцийн хүчин чадал 89 МВт, харин ашиглалтын хугацаа 25 жил болсон билээ. Дараагийн ээлжинд ТЭЦ-3 станцийг “ИНТЕР РАО-Экспорт” ХХК-ийн тусламжтайгаар шинэчлэх ажил төлөвлөөд байна. Энэ онд багтааж гэрээ хэлэлцээр байгуулан ажлаа эхлүүлэхээр ажиллаж байна.

Түүнээс гадна хамтын ажиллагааны хэд хэдэн төсөл байгаагаас дурдвал Таван толгойн нүүрсний орд газарт түшиглэн ТЭЦ барьснаар говийн бүс нутагт үйлдвэрлэл эрхлэхэд цахилгаан, дулаанаар хангах зорилготой төсөл юм. Мөн Оросын “Роснефть” компанийн охин компани болох “Роснефть-Аэро” монголын түншүүдтэй хамтарсан компани байгуулж тус компаниар дамжуулан Улаанбаатарын шинэ нисэх буудалд онгоцны түлш цэнэглэх цогцолбор барьж ашиглалтад оруулахаар төлөвлөж хэлэлцээрийн түвшинд явж байна.

Мөн Монгол Улсын уул уурхайн салбарт хоёр улсын хамтын ажиллагаа эрчимжиж байна. Тухайлбал “Зарубежгеология” ХК болон уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр хамтран геолог-геофизик, инженер-геологийн судалгааны хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулав.

Хөдөө аж ахуйн салбарын хувьд монголын хөдөө аж ахуйн техникийн парк шинэчлэлтийг Оросын "Внешэконом" банкны зээлээр хэрэгжүүлж байгаа бөгөөд мал эмнэлгийн салбарт монголын малыг эрүүлжүүлэх Хөтөлбөрийг буцалтгүй тусламжийн үндсэн дээр хэрэгжүүлж байна.

Оросоос Хятад руу экспортлох байгалийн хийн транзит хоолойн ажлыг Монгол Улсын газар нутгаар барьж байгуулах төсөл дээр мөн хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Энэ оны нэгдүгээр сарын сүүлээр “Газпром” компанийн охин компани болох “Газпром Трансгаз Томск” ХХК тусгай зориулалтын “Газпровод Союз Восток” хэмээх хамтарсан компанийг Монгол Улсад бүртгүүлэв. Тус компанийн зорилго нь байгалийн хий дамжуулах транзит хоолойн зураг төсөл болон техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах явдал юм.

Бүс нутаг болон хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа. ОХУ-ын Алс Дорнод, Сибирь зэрэг холбооны тойргууд Монгол Улстай хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж өдгөө гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 70 гаруй хувийг эзэлж байна.

Газар зүйн байрлалын хувьд ойр бөгөөд хил залгаа Оросын засаг захиргааны нэгжүүд Монгол Улстай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, Тува, Алтайн хязгаар, Томск, Омск, Новосибирск хотууд болон Кемеров зэрэг муж Монгол Улсын Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан зэрэг аймагтай идэвхтэй түншилж байна. Өвөрбайгалийн хязгаарын хувьд Монгол Улсын Хэнтий зэрэг зүүн аймагтай 830 км хиллэж уламжлалт харилцаагаа хадгалсан хэвээр байна. Эрхүү муж болон Буриадын хувьд Монгол Улсын хойд болон төвийн аймгууд, Улаанбаатартай хамтын ажиллагаа

хөгжүүлж байгаагаас гадна Хакас, Татарстан, Якут зэрэг Бүгд Найрамдах Улсын зүгээс хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлээд байна.

Хүмүүнлэгийн хамтын ажиллагаа. Энэ салбарт Орос, Монголын ахмад үе илүү гүн бат суурийг тавьсан билээ. Манай хоёр талын харилцаанд боловсрол, шинжлэх ухаан, соёлын харилцаа үргэлжид онцгой байр суурь эзэлж ирсэн. Одоогийн байдлаар ОХУ-ын Боловсрол шинжлэх ухаан, дээд боловсролын яамнаас жил бүр оросын их дээд сургуулиудад боловсрол эзэмших 550 квотыг монголын оюутан залууст олгож байна.

Бидний хамтын үүрэг бол залуу үедээ эв эетэй эх оронч хүмүүжил суулгах юм. Манай хоёр орны ард түмний хувьд чухалд тооцогдох Халхын голын дайны ялалтын 80 жил, Дэлхийн II дайн буюу Аугаа эх орны дайны ялалтын 75 жилийн ой зэрэг хоёр их ойг хамтдаа тэмдэглэн өнгөрүүлээд байна.

Монголын цэргийн алба хаагчид Оросын мөрдэс нэгт алба хаагчидтай мөр зэрэгцэн Москва хотын Улаан талбайгаар ээлжит баярын парадад хөл нийлүүлэн алхав.

Ялалтын баярын өдрүүдэд Монгол Улсын нийслэл болон зарим хотод Орос, Монголын уран бүтээлчид хамтарсан тоглолт хийв. Бидний зол болоход И.Моисеевын нэрэмжит Оросын ардын дуу бүжгийн чуулга болон А.В.Александровын нэрэмжит Оросын армийн дуу бүжгийн чуулга зэрэг дэлхийд данстай хамт олны тоглолтыг коронавирусын цар тахлын дэгдэлтээс өмнө Улаанбаатар хотноо зохион байгуулав. Мөн 2021 онд нэрт төгөлдөр хуурч Денис Мацуевыг Монгол Улсад урин ирүүлэхээр төлөвлөж байна.

Монголын уран бүтээлчид Оросод зохион байгуулдаг олон улсын хөгжмийн наадмуудад амжилттай оролцсоор ирэв. Тухайлбал, 2019 онд ОХУ-д зохион байгуулсан П.И.Чайковскийн нэрэмжит олон улсын XVI тэмцээнд Монгол Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын гоцлол дуучин Э.Анхбаяр дөрөвдүгээр байрын шагнал хүртэв.

Өнгөрсөн зууны туршид манай хоёр орны харилцаа сайн хөршийн харилцаатай байж бүхий л салбарт харилцан туслалцаж ирэв. Бидний хамтдаа даван туулсан олон сорилт манай хоёр орны найрамдалт харилцааг бэхжүүлсээр байна. Энэ нь бусад улсуудад тэр бүр байдаггүй үнэ цэнэтэй харилцааны маш чухал хүчин зүйл билээ.

Орчин цагт манай хоёр орны харилцаа Иж бүрэн стратегийн түншлэл хөгжүүлэх шинэ түвшинд хүрэв. Найрсаг хөршүүд байхын үндэс болсон өргөн уудам хил хязгаар биднийг холбож байна. Хамтдаа хөгжин цэцэглэхэд түлхэц болохуйц хамтарсан шинэ төслүүдийг боловсруулж иргэд хоорондын харилцаа, шинжлэх ухаан, боловсрол, соёл болон бусад салбарын хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлсээр байна. Дипломат харилцаа тогтоосны 200 жилийн ойгоор бидний үр хойч өнгөрсөн 100 жилээсээ ч улам илүү үр бүтээлтэй, амжилт дүүрэн үджээ хэмээн итгэл дүүрэн хэлэх байх хэмээн бодном.

Фань Сяожү¹

Хятадын Орчин Үеийн Олон Судлалын
Академийн Зүүн Хойд Ази судлалын
хүрээлэнгийн захирал

ГЕОПОЛИТИКИЙН ТУШААГ ДАВАН ТУУЛЖ ХАМТДАА ХӨГЖИХ АРГА ЗАМЫГ ЭРЭЛХИЙЛЭХ НЬ: ЗХА-ИЙН БҮС НУТАГ БА МОНГОЛ ХЯТАДЫН ХАРИЛЦААГ ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

XXI зууны гурав дахь арванд шилжих мөчид хүн төрөлхтөн шинэ төрлийн цар тахалтай нүүр тулж, тахалтай үр нөлөөтэй тэмцэхийн зэрэгцээ эдийн засгаа сэргээж чадах эсэх нь улс орнуудын хэр эв нэгдэлтэй хамтран ажиллаж чадах эсэхээс бүрэн шалтгаалах болов. Гэвч бодит байдал дээр өөдрөг дүр зураг харагдахгүй байна. Дэлхийн цор ганц хэт их гүрэн болох АНУ нь ийм үед их гүрнүүдийн харилцааг улам ээдрээтэй болгож хямралын эсрэг хамтын ажиллагаанд саад тотгор учруулж байна.

Зүүн Хойд Азийн бүс нутаг нь хүйтэн дайн ул мөрөөр хуваагдмал бүс нутаг болсон бөгөөд АНУ болон Японы хэрэгжүүлж буй геополитикийн бодлого энэхүү сөргөлдсөн байр суурийг улам өрдөж байгаа нь бүс нутгийн энх тайван, тогтвортой байдалд аюул учруулж болзошгүй юм. Өдгөө Зүүн Хойд Азийн бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхийн тулд геополитикийн үзэл суртлын хүлээснээс гарч, бүс нутгийн улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ гарцыг эрэлхийлэх шаардлагатай байна.

Нэг. Өнөөгийн бүс нутгийн нөхцөл байдал

1. АНУ-ын шинэ засаг захиргааны авчирч буй өөрчлөлтүүд

Дөрвөн жилийн турш төр барьсан “сонгодог бус” Ерөнхийлөгч Д.Трампын дараа Ардчилсан намаас нэр дэвшигч Ж.Байден АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсон билээ. Трампын засаг захиргаа “Америк тэргүүнд” бодлого баримталж хэт нэг талыг барьсан худалдааг хамгаалах бодлого явуулсан нь гадаад харилцаанд томоохон толбо болж үлдсэн юм. Цаг үе Байдены засаг захиргаанд гадаад бодлогоо эргэн харж дахин нэг нягтлах боломж олгож байгаа ч Трампын засаг захиргааны гадаад харилцаанд үлдээсэн “өв” болон дотоодын улс төрийн хагарал, цар тахал зэрэг хүчин зүйл нь АНУ-ыг маневэрлах боломжийг улам хумьж байв. Америкийн зүгээс Хятадад хориг тавихад анхаарал хандуулж улмаар Хятадыг стратегийн өрсөлдөгч хэмээн нэрлэв. Байдены засаг захиргааны гадаад

¹ 2007 онд Бээжингийн их сургууль төгссөн. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, Японы гадаад бодлого, Хятад, Японы харилцаа болон Зүүн Хойд Азийн бүс нутгийн чиглэлээр судалгаа хийдэг. Англи, япон хэлтэй.

бодлого холбоотнууд болон олон талт хамтын ажиллагаанд анхаарлаа хандуулах төлөвтэй байна. АНУ нь Хятадыг стратегийн өрсөлдөгч хэмээхийн сацуу холбоотны харилцаагаа бэхжүүлж олон талт аюулгүй байдлын механизм бий болгохоор чармайж буй нь илэрхий Хятадыг сөрсөн шинж чанартай “Америк тэргүүнд” бодлого буюу дэлхий дээрх хамгийн хүчирхэг гүрний байр сууриа авч үлдэхийн тулд хүчирхэгжиж буй орнуудыг хамаг хүчээрээ нухчин дарах санаа юм. Бүс нутагт дэг журам тогтоохын тулд Байден засаг захиргаа Трампын үеийн Энэтхэг Номхон далайн стратегийг үргэлжлүүлэн АНУ, Энэтхэг, Япон, Австралийн дөрвөн талт (QUAD) аюулгүй байдлын хамтын ажиллагааг дэмжин өргөжүүлэхийг чармайж байгаа юм.

Бүс нутгийн орнуудын хувьд АНУ-ын бодлого өөрчлөгдөж буй нь Япон, Солонгос зэрэг холбоотонд өөрсдийн бодлогыг тохируулан маневрлах боломж өгч байна. Бодлогын өөрчлөлт нь стратегийн зорилтыг агуулж байдаг. Трампын засаг захиргаанаас Японд үзүүлж буй цэргийн зардлаа нэмэгдүүлэх, худалдааны алдагдлыг багасгах зэрэг шаардлага тавьж Японыг шахалтанд оруулж байсан нь хоёр талын холбоотны итгэлцэлд нөлөөлж Хятадтай харилцаагаа сайжруулахад чиглэсэн илүү прагматик бодлого баримталж эхэлжээ.

Харин Японы хувьд Байден төрийн эрхэнд гарснаас хойш Хятад Америкийн өрсөлдөөн ширүүсч Байден засаг захиргаа холбоотнууддаа ач холбогдол өгөх болсон. Иймээс Японы улс төрчдийн Хятадын өсөлтийг сөрсөн дуу хоолой идэвхжиж, Японы АНУ болон Хятадад баримтлах бодлогод өөрчлөлт орж эхэлсэн.

Цаашид Хятад улсын нэгдмэл хүч чадлаараа АНУ-ыг гүйцэх боловч АНУ, Япон Европын Холбооны нэгдсэн хүчийг гүйцэхэд хүндрэлтэй юм. Урт хугацаанд нь харвал тэд дангаар Хятадыг гүйцэх боломжгүй ч хэрэв алсдаа хамтарч чадвал Хятадыг тогтоон барих боломжтой гэсэн нийтлэг дүгнэлт байдаг.

Японы бодит үйлдлээс харахад Байден ажиллаж авсны дараа “Энэтхэг Номхон далайн стратегийг идэвхтэй дэмжсэн байр суурь илэрхийлж Японы Ерөнхий сайд Суга И анхны айлчлалаа Америкаас эхэлж Хятадыг ярианы гол сэдэв болгосон төдийгүй, Япон болон Их Британи, Франц зэрэг Европын улстай харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх болсон нь дээрх дүгнэлтийг нотолно. Энэхүү дүгнэлт нь хүч чадал дээр суурилсан прагматизмын бодит логик болох нь илэрхий байна.

Хэдийгээр Өмнөд Солонгос нь Америкийн холбоотон боловч тэдний арга барил Японоос өөр бөгөөд энэ нь тэдний ашиг сонирхол, гадаад бодлого стратегийн ялгаатай байдлыг илэрхийлж байдаг. Өмнөд Солонгосын бодлогоос харахад тэд Хятад Америкийн сэргөлдөөнийг хурцатгахгүй хүсдэггүй нь нөгөө талаар тэднийг сонголт хийхэд хүргэдэг талтай. Тиймээс Байден засаг захиргаа Өмнөд Солонгост анхаарал хандуулж улмаар QUAD-д элсэхийг ятгасан тухай мэдээлэл гарч байсан ч Өмнөд Солонгос тодорхойгүй бодлого баримталж, өөрийгөө Хятадыг сөрсөн блокт нэгдсэн мэт харагдуулахыг хүсээгүй юм. Эндээс Америкийн шинэ засаг захиргааны бодлогын өөрчлөлтийн явцад Өмнөд Солонгос өөрийн Хятадад баримтлах бодлогоо хадгалахыг хичээж байгааг харж болно.

Иймээс Япон улс Хятад Америкийн сэргөлдөөний тэргүүн эгнээнд байршдаг. Харин Өмнөд Солонгос, Солонгосын хойг болон эдийн засгийн хөгжлийн асуудалд илүүтэй анхаарал хандуулж байгаа нь үндэсний ашиг сонирхлоо хамгаалах зорилготой Мүн Жэ

Ины Засгийн газрын бие даасан гадаад бодлогыг илтгэн харуулж байна. Хэдийгээр Япон Өмнөд Солонгосын баримтлах бодлогын ялгаатай байдал болон хоёр улсын эртнээс улбаатай гүн гүнзгий зөрчил Америк, Япон, Өмнөд Солонгосын гурван талт хамтын ажиллагааг бэхжүүлэхэд саад болдог ч Америкийн зүгээс холбоотны харилцаан дахь тэргүүлэх байр сууриа ашиглан холбоотны цар хүрээгээ тэлэхийг эрмэлзэж байдаг.

2. Бүс нутагт тулгамдсан асуудал бол хөгжил, тогтвортой байдал

Зүүн Хойд Азийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа болон иргэд хоорондын харилцаа нь нутгийн эдийн засгийн хурдацтай өсөлтийн гол хөдөлгөгч юм. Гэсэн ч хүйтэн дайны улбаатай бүс нутгийн улсуудын хооронд орших удаан хугацаанд шийдэгдээгүй ээдрээтэй асуудлын улмаас улс төрийн харилцаа тогтворгүй хэвээр байхын сацуу олон улсын орчин дахь тодорхойгүй шинэ асуудлуудын улмаас тус бүс нутаг цэргийн мөргөлдөөн үүсэх эрсдэлд оршиж байдаг. Хамгийн тод томруун зөрчил бол Солонгосын хойгийн асуудал ба Япон болон хөрш орнуудын хооронд орших түүх болон газар нутгийн маргаан юм.

Өдгөө Америкийн шинэ засаг захиргааны геополитикийн давамгайллын төлөөх санаархал өндөлзөх болсноор Зүүн Хойд Азийн энх тайван, хөгжил цэцэглэлтэд шинэ сорилт тулгарч байна. Солонгосын хойг нь Зүүн Хойд Азийн халуун цэг билээ. Удаан хугацааны турш хойгт удаа дараа хурцадмал байдал үүсч бүс нутгийн бүх улс орны аюулгүй байдлын орчинд нөлөөлөх тогтворгүй хүчин зүйл болж ирэв. Солонгосын хойгийн асуудлын гол цөм нь Солонгосын хойгт удаан хугацааны туршид энх тайвны механизм байхгүйгээс үүдсэн цөмийн зэвсэгтэй холбоотой цогц асуудал юм. Сүүлийн жилүүдэд хойгийн байдал олонтаа хямрах болсон нь бүс нутгийн аюулгүй байдалд заналхийлж байна. Хямралыг намжаасан ч Умард Солонгосын цөмийн асуудал болон энх тайвны механизм бий болгоход дорвитой ахиц гарсангүй. Харин ч Умард Солонгос цөмийн болон пуужингийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр шинэ туршилт хийж Өмнөд Солонгос болон бусад улс удааны хугацааны турш Умард Солонгосын эсрэг хориг арга хэмжээ авч байгаа билээ. Ингэснээр Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангижруулж энх тайван тогтооход сорилт учирч буй юм.

Тиймээс асуудлыг шийдвэрлэхэд Америкийн хүсэл эрмэлзэл, чадавх түлхүүр үүрэгтэй байдаг. Хэрэв Америкийн зүгээс Солонгосын хойгийн асуудлыг геополитикийн үүднээс Зүүн Хойд Азийн холбоотны системээ бэхжүүлж, Хятадыг хязгаарлах бодлогынхаа арга хэрэгсэл гэж үзвэл бүс нутгийн асуудал ямагт ганцанги шийдэгдэхгүй үргэлжлэх болно.

Үүний зэрэгцээ Япон болон түүний хөрш орнуудын түүх, нутаг дэвсгэрийн маргаанд нь үндсэндээ дайны дараах асуудлууд байсан бөгөөд Америк хөндлөнгөөс оролцсоноор шийдвэрлэхэд илүү түвэгтэй болсон юм. Тухайлбал, Хятад, Японыг тойрсон Дяо Юй арлууд, зүүн хятадын тэнгисийн асуудлууд, 2010 онд Хятадын загасчлалын хөлөг онгоц Японы эргүүлийн онгоцтой мөргөлдсөн явдал болон 2012 онд Япон Дяо Юй арлыг “өмчилсөн” зэргээс улбаатай энэ бүс нутаг маргааны халуун цэг болоод буй.

Асуудлын мөн чанар нь Японы зүгээс Хятад Японы “асуудлыг түр хойш тавих” улс төрийн зөвшилцлийг сөрж асуудлыг дангаар шийдвэрлэхийг зорьж буйд оршино. Хятадын идэвхтэй хариу үйлдлийн дараа Япон зүгээс асуудлыг дипломат арга замаар

шийдвэрлэх идэвх буурч цэрэг, хууль хэрэгжүүлэх хүчнийг байршуулж улмаар Америкийн дэмжлэгийг авах замаар түүхэн газар нутгийн маргааныг аюулгүй байдлын асуудал болгож хувиргасан.

Сүүлийн жилүүдэд, Япон улс “Хятадын аюул” хэмээх үзэл суртал дэлгэрүүлж Японы олон нийтийн Хятадад хандах хандлагыг дордуулж Хятад, Японы дипломат яриа хэлэлцээгээр маргааныг зөөлрүүлэх боломжийг хумьж байна. Үр дүнд нь Япон Хятадад дайсагнах хандлага идэвхжиж байна.

Геополитикийн улбаатай бодлого, стратеги нь Зүүн Хойд Азийн зөрчилдөөнийг шийдвэрлэх бус улам ээдрээтэй болгож байна гэж дүгнэж болно. Уламжлалт аюулгүй байдлаас гадна шинэ төрлийн титэмт вирус нь уламжлалт бус аюулгүй байдлын түвшинд шинэ сорилтуудыг бий болгож байна. Вирус улс орон, үндэстэнг ялгалгүй тархаж ямар ч улс дангаараа вирустэй тэмцэх боломжгүй байна. Цар тахалтай тэмцэх явцад Засгийн газар ба ард иргэдийн хамтын ажиллагаа хариуцлага харилцан туслалцсан эерэг дүр зураг байсан ч олон нийтийн санаа бодлын талцал, вакцинаас хамгаалах үзэл идэвхжсэн зэрэг сөрөг дүр зургууд ч ажиглагдаж байсан. Вирус одоо ч амь бөхтэй оршиж тахал олон улсын улс төрд нөлөөлсөн хэвээр байгаа бөгөөд хүн төрөлхтөн тархалтыг хянаж чадах, хэвийн амьдралдаа эргэж орох эсэх нь олон улсын ирээдүйн дэг журам ямар болж тогтох зэрэг асуудал зөвхөн тухайн улсын авч хэрэгжүүлэх бодлого болон улсын ард иргэдийн хүчин чармайлтаас ихээхэн хамаарна. Иймээс геополитикийн үүднээс асуудалд хандах нь тахлын эсрэг тэмцэхэд сөрөг нөлөөтэй тул эв нэгдэлтэй хамтран ажиллаж байж энэ бүхнийг давна гэдэг нь хэн бүхэнд тодорхой юм. Үүнийг Зүүн Хойд Азийн орнууд илүү сайн ойлгож байна. Тухайлбал, цар тахлын эхэн үед Япон, Өмнөд Солонгос, Монгол зэрэг орны Засгийн газар ард түмнээс Хятадад үзүүлсэн туслалцаа нь эдгээр орны ард иргэдийг ойртуулж Зүүн Хойд Азийн орнууд зовлон зүдгүүрийг хамтдаа хуваалцаж чаддаг нийгэм гэдгийг бусдад ойлгуулж чадсан. Ингэснээрээ цар тахалтай тэмцэх, эдийн засгаа сэргээхэд тодорхой ахиц гаргасан. Гэвч бүс нутгийн орнуудын хөгжлийн түвшин засаглалын чадавхын тэнцвэргүй байдал нь уламжлалт бус аюулгүй байдлын эрсдэлтэй тэмцэхэд бэрхшээл учруулж байдаг.

3. Хамтын ажиллагаа, хөгжлийн шинэ арга замыг эрэлхийлэх нь

Өнөөгийн сөргөлдөөнийг намжаах нь бүс нутгийн энх тайван тогтвортой байдлыг хамгаалах, уламжлалт бус аюулгүй байдлыг шинэ аюул заналтай тэмцэхэд ч геополитикийн үүднээс хандах нь нөхцөл байдлыг хүндрүүлж бүс нутгийн улсуудын эрх ашигт сөргөөр нөлөөлнө. Хүйтэн дайны ул мөр хадгалагдан үлдсэн энэ бүс нутгийн улсууд байдлыг маш сайн ойлгож буй биз ээ. Геополитик, улс төрийн хязгаарлалтаас гарахын тулд бүс нутгийн орнуудын хамтын хүчин чармайлт шаардагдана. Нэн тэргүүнд, бүс нутгийн эмзэг асуудлыг хяналтад байлгах шаардлагатай. Тухайлбал, Солонгосын хойгийн асуудлаар бүх талууд хойгийн энх тайван тогтвортой байдлыг хадгалахын ач холбогдол, хариуцлагыг ухамсарлаж асуудлыг яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх байр суурийг тууштай баримталж, хойгийг цөмийн зэвсгээс ангижруулахыг дэмжиж цуцалтгүй хүчин чармайлт гаргах нь хойгийн энх тайван тогтвортой байдлыг бататгахад ашиг тустай. Хойгийг цөмийн зэвсгээс ангижруулж хойгт энх тайвны механизмыг бий болгох нь талууд санал нэгдэн хэрэгжүүлэх цорын ганц боломжит арга зам юм.

Өдгөө АНУ Умард Солонгосын цөмийн зэвсгээс татгалзах асуудал мухардалд ороод байгаа бөгөөд хоёр талын харилцан итгэлцэл дутмаг байгаа тул Умард Солонгосын цөмийн асуудлаарх яриа хэлэлцээнд ахиц харагдахгүй байна. Солонгосын хойгт энх тайвны механизмыг бий болгох хүчин чармайлтыг эхлүүлж, олон талт механизмаар дамжуулан талуудыг хариуцлагатай байж хүлээсэн үүргээ биелүүлэх нөхцөлийг хангах замаар харилцан итгэлцлийг бэхжүүлж нөхцөл байдлыг хурцатгаж буй талуудын өдөөн хатгалтыг таслан зогсоох боломжтой болох юм. Хоёрдугаарт, хоёр талын асуудлыг яриа хэлэлцээрээр шийдвэрлэх хэрэгтэй байна. Тухайлбал, Хятад-Япон, Япон-Солонгосын түүхийн улбаатай болон газар нутгийн маргаан зэрэг асуудлыг цэрэг зэвсэг, хүч хэрэглэлгүй яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх боломжтой байтал бүс нутгийн бус оролцогчийг татан оролцуулснаар сөргөлдсөн байр суурь баримталж харилцан хатуу арга хэмжээ хэрэгжүүлж буй нь дайны улбаатай асуудлыг аюулгүй байдлын сорилт болгон хувиргаж байна.

Саяхан Япон Өмнөд Солонгос хооронд өрнөсөн албадан хөдөлмөр эрхлэхтэй холбоотой маргаанд Японы зүгээс Өмнөд Солонгост эдийн засгийн хариу арга хэмжээ авсан нь мөн сөрөг үр дагавартай юм. Үүнээс гадна дотоодын улс төрийн ашиг сонирхлыг ингэж нийтэд зарлах нь хоёр улсын иргэд төөрөлдөх эсвэл харилцан тааламжгүй хандлагатай болгодог. Олон нийтийн санаа бодлыг улс төр хөтлөн чиглүүлж байдаг. Хэрэвзээ олон нийтийн санаа бодлыг буруу чиглүүлж улмаар санаатайгаар төөрөлдүүлбэл энэ нь алсдаа тухайн улсын гадаад бодлогын уян хатан чанарыг алдагдуулж улмаар мөргөлдөөн гарахад хүргэдэг.

Гуравдугаарт, их гүрнүүдийн зөрчлийг арилгахад “гал дээр тос нэмэх”-гүй байх хүчин чармайлт гаргах шаардлагатай байдаг. Өнөөгийн байдлаар бүс нутагт илэрч буй их гүрнүүдийн тод томруун зөрчилдөөн бол Хятад, Америкийн өрсөлдөөн юм. Америкийн зүгээс прагматизм суурьтай геополитикийн үүднээс Хятадыг хязгаарлахыг хичээж Байдены засаг захиргаа ч энэ бодлогыг үргэлжлүүлэн эдийн засгийн ялангуяа өндөр технологийн салбарт Хятадад хатуу бодлого баримталж байна. Ингэснээр эдийн засгийн хамаарал ихэсч буй бүс нутгийн улсуудад сорилт тулгарч байна. Өөрөөр хэлбэл, тэдний хувьд Америкийг дагавал бодит эрх ашиг хохирно, дагахгүй бол Америк шахалт үзүүлнэ.

АНУ-ын Хятадад чиглэсэн бодлого нь зөрчилдөөний үндэс суурь болдог тул АНУ-ын бодлогыг өөрчилж, Хятад, Америкийн хоорондын зөрчлийг намжаах нь асуудлыг үндсээр нь шийдвэрлэх боломж юм. Хэдийгээр богино хугацаанд хэрэгжүүлэхэд хэцүү ч одоохондоо гал дээр тос нэмж, зөрчлийг улам хурцатгахгүй байхыг хичээх хэрэгтэй юм. Тодруулбал, зарим улс орнууд Хятад Америкийн хоорондох зөрчил эрчимжих нь тэдэнд ашигтай гэж үзэж байгаа учир Хятад Америкийн зөрчил хурцдаж буйг тааламжтай ажигладаг. Энэ нь зарим улс төрчдөд ашигтай байж болох ч урт хугацаандаа Хятад Америкийн зөрчлийг улам даамжруулах нь бүс нутгийн аюулгүй байдал болон ашиг сонирхолд хохиролтой юм. Цар тахлын өнөөгийн байдал, улс орнуудад тулгарч буй бэрхшээлүүд нь хамтын ажиллагааг хөгжүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байгаа бөгөөд зөрчлийг намжааж, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх хүчин чармайлт нь бүс нутгийн аюулгүй байдлын орчныг сайжруулахад ч бүс нутгийн улс орнуудын хамтын хөгжил цэцэглэлтэд ч чухал ач холбогдолтой учир бид хамтын ажиллагааг хөгжүүлэх шинэ замыг эрэлхийлэх ёстой билээ.

Хоёр. Хятад Монголын харилцааны өнөөгийн төлөв байдал

1. Хятад Монголын харилцаа

Хятад Монгол Улс бол эртнээс түүхэн холбоотой хөрш орнууд юм. Хятадын ард түмэн Монголыг хамгийн дотно хөршөө хэмээн үздэг. Үүнээс улбаалан Си Зиньпин даргын 2014 оны наймдугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалыг “Садандаа зочилсон” хэмээн нэрлэдэг. Мөн түүнчлэн Хятадад цар тахлын дэгдсэний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНХАУ-д хийсэн айлчлал нь тахлын үеэр Хятадад айлчилсан хамгийн анхны төрийн тэргүүний айлчлал байсан бөгөөд 30 мянган хонь хандивласан нь хөрш орнууд хүнд цагт бие биедээ тусалж байгааг илтгэсэн үйл явдал болсон юм. Энэ тухай Хятадын хэвлэл мэдээллээр Монгол Улсын эдийн засаг төдийлөн хөгжөөгүй ч Хятадад цар тахалтай тэмцэхэд зориулж үнэтэй бэлэг өгч байна. Монголын ард түмэн Хятадын ард түмнийг цар тахалтай тэмцэхэд олон хэлбэрээр дэмжлэг, туслалцаа үзүүлсэн тухай мэдээллэж Хятадын олон нийтэд халуун дулаан уур амьсгал авчирсан юм.

Сүүлийн жилүүдийн Хятад, Монголын харилцааг дүгнэвэл улс төрийн дээд түвшний удирдлага нь хоёр орны харилцаанд чухал үүрэг гүйцэтгэснийг харж болно. 2014 оны наймдугаар сарын 21-22-ны өдрүүдэд БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол Улсад айлчилж, «Хятад, Монголын харилцаа сайн сайхан ирээдүй рүү довтолгож явна», “Сааахалт айлын санаа нэг Хятад, Монголын харилцааны шинэ үеийг хамтдаа бүтээе” хэмээх илтгэлээ танилцуулсан. Тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч байсан Ц.Элбэгдорж Хятад, Монголын харилцааг таван чиглэлээр сайжруулах санал дэвшүүлсэн. Үүнд харилцан итгэлцлээ бэхжүүлэх, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хил дамнасан тээвэр, дэд бүтцийн хамтын ажиллагааг урагшлуулах, олон талт хамтын ажиллагааны агуулгыг баяжуулах, хоёр орны худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэхээр хамтран ажиллана хэмээв.

Хятад, Монгол Улс нь “Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэл байгуулж, хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” гаргаж, хоёр улсын харилцааг албан ёсоор “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа”-ны түвшинд хүргэв. Мөн хүрээнд хамтын ажиллагааны 26 гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд талууд улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэг, олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаа болон бусад салбарт иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж Хятад, Монголын найрамдал, хамтын ажиллагаа шинэ шатанд хүрсэн юм.

Си Зиньпин дарга Монгол Улсын Их Хуралд хэлсэн үгэндээ «Хятадын зүгээс Монгол зэрэг хөрш орнууддаа хамтын хөгжлийн боломж, орон зайг бий болгож Хятадын хөгжлийн буухиа галт тэргэнд суухыг урьж байна. Хөгжлийн буухиа галт тэргэнд суух нь хэн бүхэнд нээлттэй байх болно. Хятад амалснаа биелүүлж, гүйцэлдүүлдэг хэмээн онцолсон. Энэ нь Хятад улсын нээлттэй байж өөрийн хуримтлуулсан хөгжлийн туршлагаа хөрш орнуудад нэвтрүүлж, хамтдаа хөгжих, хөгжиж буй орнуудтай «Амь нэгтэй хувь заяаны нэгдэл» байгуулах хүсэлтэйн илрэл юм. Энэ бол ХКН-ын XVIII их хурлаас хойш баримталж буй Хятадын хөрш орнуудад явуулах гадаад бодлогын «дотно, шударга, хүртээмжтэй, хүлээцтэй» зарчмыг хэрэгжүүлж буй хэрэг юм. Ийнхүү Монгол Улсыг сонгон анх удаа “хөгжлийн

буухиа галт тэрэг”-д суухыг урьсан явдал нь Хятад улсын хувьд Монгол Улс чухал ач холбогдолтойн дээр Хятад, Монголын харилцааг хоёр хөрш орны харилцааны үлгэр жишээ болгох гэсэн хүсэл юм. Х.Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгчөөр 2017 онд сонгогдсоны дараа Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх нь тэргүүний зорилт хэмээн тодорхойлж, Хятад улстай энх тайван, найрсаг харилцаа хөгжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж, улмаар БНХАУ-ын «Бүс ба зам» санаачилгад идэвхтэй оролцох болсон. Ерөнхийлөгч асан Х.Баттулга БНХАУ-д 2019 оны дөрөвдүгээр сард төрийн айлчлал хийж, “Бүс ба зам” олон улсын II форумд оролцов. Си дарга уулзалтын үеэр Хятад, Монгол хоёр улс уул усаар холбогдсон “сайн хөрш, сайн найз, сайн түнш” хэмээн онцлов. Өдгөө хоёр улсын хамтын ажиллагаа хэдийнэ хурдны замдаа оржээ. Хятад улс дотно, шударга, хүртээмжтэй, хүлээцтэй зарчмаа баримталж, Монгол Улсын эдийн засгийн хөгжил, ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлж, улс төрийн зөв чиглэлийг тууштай барьж, бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлэх замын зургаа боловсруулж, харилцан хүндэтгэж, харилцан итгэсэн стратегийн түнш, харилцан ашигтай хамтын ажиллагааны түнш, харилцан зорчиж харилцан айлчилсан нөхөрсөг түнш, харилцан тусалдаг олон талт хамтын ажиллагааны түнш болон цаг үеийн шаардлагад нийцсэн Хятад, Монголын харилцааг бүтээн байгуулна гэсэн юм. Мөн үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч асан Х.Баттулга «Хятад улстай сайн хөршийн харилцан ашигтай хамтын ажиллагааны урт хугацааны түншлэлийг хөгжүүлэх нь Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл юм. Монгол Улс Хятад улстай хоёр орны харилцааны ирээдүйн хөгжлийн чиглэл, зорилтыг төлөвлөж “Хөгжлийн зам” санаачилгыг “Бүс ба зам” санаачилгатай уялдуулан худалдаа, эрчим хүч, хөдөө аж ахуй, мал аж ахуй, дэд бүтцийн бүтээн байгуулалт, иргэний нисэхийн болон бусад салбарын хамтын ажиллагааг бэхжүүлж Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорыг байгуулна» гэдгээ илэрхийлсэн юм. Чухамхүү улс төрийн лидерүүдийн удирдлагаар Хятад, Монголын улс төрийн харилцан итгэлцэл тасралтгүй бэхжиж, бүхий л салбарын хамтын ажиллагаа идэвхжиж, хоёр талын харилцаа хөгжсөөр байна. БНХАУ-ын Худалдааны яамны 2019 оны статистикаас үзэхэд, Хятад, Монгол хоёр улсын худалдаа 8.16 тэрбум ам.долларт хүрч, сүүлийн 10 жилд 4.5 дахин өссөн байна. Монгол Улсын статистикийн мэдээгээр 2019 онд Монгол Улсын нийт гадаад худалдааны 64 хувийг Хятадтай хийсэн бөгөөд үүнээс нийт экспортын 93.8 хувийг Хятад руу экспортолжээ.

Хөрөнгө оруулалтын хувьд 2019 онд Хятадаас Монгол Улсад 270 сая ам.долларын хөрөнгө оруулсан нь өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 132 хувиар өссөн байна. БНХАУ-аас Монгол Улсад шинээр хэрэгжих төслийн хүрээнд 4.06 тэрбум ам.доллар хөрөнгө оруулсан нь өнгөрөгч оны мөн үеэс 56.4 хувиар өссөн байна. БНХАУ-аас Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт 2019 оны дугаар сар гэхэд нийт 4.8 тэрбум орчим ам.долларт хүрснээр Хятад улс Монголын хоёр дахь том хөрөнгө оруулагч болов. Хятадын аж ахуйн нэгжүүд Монгол Улсад 9.8 тэрбум орчим ам.долларын төсөл хэрэгжүүлж, гүүр, зам, хотын захиргаа, үйлдвэр, уурхай гэх мэт томоохон барилгын бүтээн байгуулалт хийжээ. Хятад улс мөн Монгол Улсад үзүүлэх санхүүгийн дэмжлэгээ өргөжүүлж, санхүү, хүний нөөцийн салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэв. Энэхүү тахал өвчинд нэрвэгдсэн ч 2020 онд Хятад, Монгол хоёр улсын хоорондох худалдаа, хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан ч, Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэж, Хятад, Монголын чөлөөт худалдааны бүс байгуулснаар Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн харилцаа өргөжин хөгжинө.

2. Хятад, Монголын харилцааг хөгжүүлэх түүхэн боломж бий болж байна

Өдгөө Хятад, Монголын харилцаа түүхэн дэх хамгийн сайн түвшинд байгаа бөгөөд хөрш орнуудын харилцааны загвар болжээ. Хятад, Монгол Улс хөгжиж буй орнууд болохын хувьд хөгжлийг стратегийн үндсэн зорилт гэж үздэг бөгөөд хоёр улс харилцан хамааралтай, харилцан нөхөлцсөн стратегийг сонгосон юм. Сүүлийн жилүүдэд Хятад улс хурдацтай хөгжиж, дипломат үйл хэргээ хөрш орнуудад чиглүүлэх болсноор Монгол Улс Хятадын гадаад бодлогод нэн чухал байр суурь эзэлж байна. Ялангуяа Хятадын «Бүс ба зам» санаачилга нь Монгол Улсын «Хөгжлийн зам» (Талын зам нэртэй байсан) санаачилгатай агуулга ижил төстэй, ашиг сонирхол давхцаж байгаа нь хоёр талын харилцаанд түүхэн шинэ боломжуудыг авчирч байна.

Хятадын удирдагчид 2013 онд “Бүс ба зам” санаачилгын үзэл баримтлалыг дэвшүүлсэн. Монгол Улс 2014 онд Европ, Азийг холбон орших газарзүйн давуу талаа түшиглэн санаачилсан «Талын зам» (хожим нь «Хөгжлийн зам» болгон өөрчилсөн) төлөвлөгөө нь тээвэр, худалдаагаар дамжуулан Монгол Улсын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх зорилготой юм. БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 оны есдүгээр сарын 11-нд Хятад, Орос, Монгол Улсын төрийн тэргүүн нарын уулзалтад оролцохдоо БНХАУ-ын “Бүс ба зам”, ОХУ-ын “Евразийн эдийн засгийн холбоо”, Монгол Улсын “Талын зам” санаачилгыг уялдуулан Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах санаачилга гаргасан юм. Монгол Улсыг “Бүс ба зам” санаачилгын хамгийн анхны дэмжин оролцогч тал хэмээн нэрлэж болно. Хятад, Монголын Засгийн газар Монгол Улсын “Талын зам”, БНХАУ-ын “Бүс ба зам” санаачилгыг уялдуулах тухай хамтын ажиллагааны санамж бичигт 2017 онд гарын үсэг зурж хоёр тал худалдаа, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, эрчим хүч болон бусад салбарт шинэ эрч хүч зэрэг салбарт хамтран ажиллах болсноор хамтын ажиллагааны шинэ талбаруудыг нээсэн билээ.

“Бүс ба зам” санаачилга нь энх тайванч хамтын ажиллагаа, нээлттэй хүртээмжтэй байдал, харилцан суралцах, харилцан ашигтай байх гэсэн үзэл баримтлалтай, иж бүрэн хамтын ажиллагааг дэмжиж, улс төрийн итгэлцэлтэй, эдийн засгийн харилцаатай, олон талт соёлыг багтаасан эрх ашгийн болон үүрэг хариуцлагын нэгдлийг бий болгохыг зорьж буй юм.

“Бүс ба зам” санаачилга бол түүхийн шинэ нөхцөлд Хятадын зүгээс гадаад ертөнцөд дэвшүүлж буй харилцан ашигтай, хамтран ажиллах боломж юм. “Бүс ба зам”-ыг байгуулах шаардлага нь Хятадын дотоодын хөгжлөөс урган гарсан стратегийн сонголт бөгөөд эдийн засгийн даяаршлыг дэмжих зорилготой. Монгол Улсын «Хөгжлийн зам» төлөвлөгөөг дэвшүүлсэн явдал нь Монголын талаас «Тал нутгийн торгоны зам»-ын хөгжлийн түүх, үзэл баримтлалд онцгой ач холбогдол өгч буйг харуулж буй бөгөөд ингэснээр Монголын эдийн засаг төдийгүй, Хятад Монголын харилцаанд ихээхэн хувь нэмэр оруулах нь дамжиггүй. Тиймээс “Бүс ба зам”, “Хөгжлийн зам” санаачилга огтлолцох учиртай ажээ.

Агуулгын хувьд «Бүс ба зам» санаачилга бол харилцан холбогдох тухай юм. Хатуу дэд бүтцээр харилцан холбогдсоны үндсэн дээр иргэд хоорондын харилцааг бэхжүүлэх учиртай. Өөрөөр хэлбэл, дэд бүтцээр харилцан холбогдох нь “Бүс ба зам” санаачилгын гол концепц юм.

Монгол Улсын «Хөгжлийн зам» төлөвлөгөө нь Хятад, Оросыг холбосон дамжин өнгөрөх төмөр зам, хурдны зам, байгалийн хий, газрын тосны хоолой байгуулах эрчим хүчний сүлжээ барих мега төсөл юм. Эндээс харахад, Монгол Улсын «Хөгжлийн зам» төлөвлөгөө нь Европ ба Азийг холбосноор далайд гарах зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэж байна. Энэ нь мөн чанартаа нь Евразийн улсуудтай эрчим хүч, худалдааны түншлэлийн харилцаагаа бэхжүүлэх замаар Ази Номхон далайн эдийн засгийн системд нэгдэх зорилготой ажээ. Тиймээс Хятад, Монголын санаачилга үндсэндээ агуулгын хувьд ижил төстэй гэж дүгнэж болно.

Өнөөгийн байдлаар, төмөр зам, хурдны зам, иргэний агаарын тээврээр харилцан холбогдож хөрөнгийн урсгал, ложистик, иргэд, мэдээллийн урсгалыг саадгүй болгох нь эдийн засгийг сэргээх өсөлтийн шинэ цэг гэдэгт хоёр тал санал нэгдэж байна.

Иймээс Хятадын “Бүс ба зам” санаачилга, Монгол Улсын “Хөгжлийн зам” төлөвлөгөө харилцан уялдаж амжилттай хэрэгжих нь нэн чухал ач холбогдолтой юм. Нэг талаар “Бүс ба зам”, “Талын зам” санаачилга амжилттай хэрэгжих нь хоёр талын түншлэлийн харилцааг шинэ шатанд гаргахын зэрэгцээ “Бүс ба зам” санаачилгын хэрэгжилтийн сайн жишиг болж Зүүн Хойд Азийн улсуудыг идэвхжүүлэх нөлөөтэй. Мөн түүнчлэн Монгол Улс “Бүс ба зам” санаачилгын анхны дэмжигч улс болохын хувьд “Бүс ба зам”-ын орнуудад Хятадтай хамтран ажиллах итгэл төрүүлэх юм. Иймээс талууд хоёр санаачилгаа уялдуулан өөрийн онцлогт тохируулан хамтран ажиллах нь “Бүс ба зам”-ын орнуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь дамжиггүй.

Цар тахлын аюул хүн төрөлхтний эрүүл мэнд, аюулгүй байдал, дэлхийн хөгжил цэцэглэлтэд ноцтой хохирол учрууллаа. Хятад, Монгол Улс ч тахлын нөлөөнд автаж багагүй сорилт бэрхшээлийг даван туулж байна. Гэвч Хятад, Монголын харилцаа цар тахлын сорилт бэрхшээлийн үед ч ганхашгүй бат бэх байж чадсан юм. Өмнө дурьдсанчлан Хятадад тахал дэгдсэний дараа Монгол Улс Хятадын ард түмэнд сайн санааны тусламж илгээн зовох цагт нөхрийн чанараа таниулан “Хүн төрөлхтний хувь заяаны нэгдэл”-ийн үзэл санааг тод томруун харууллаа.

Цар тахлын сорилтын дараа Хятад, Монголын худалдаа, эдийн засгийн үр ашигтай хамтын ажиллагааны бат бөх суурь тавигдлаа. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд гадаад хэргийн сайд Ван И 2020 оны есдүгээр сард Монгол Улсад хийсэн айлчлалынхаа үеэр «Хоёр тал тахлын дараа хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, алдагдсан цаг хугацаагаа нөхөх ёстой» гэж онцолсон юм. “Хятадын асар том зах зээл Монгол Улсын хөгжилд чухал боломж олгоно. Дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, эрчим хүчний бүтээгдэхүүнийг импортлох, хилийн боомтууд болон дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааг бэхжүүлж, хоёр талын чөлөөт худалдааны хэлэлцээрт ойрын хугацаанд гарын үсэг зурах хүсэлтэй байна. Бид хоёр талын худалдааны тогтвортой өсөлтийг дэмжих болно. Хятад, Монгол, Оросын хамтын ажиллагаа нь хөрш орнуудын харилцан ашигтай хамтын ажиллагаа юм. Бид гурван улсын эдийн засгийн коридорыг байгуулж, хамтын ажиллагааны чухал төслүүдийг эрэмбэлэн хэрэгжүүлнэ гэжээ. Цар тахлыг даван туулсны дараа Хятад, Монголын харилцаа хөгжлийн шинэ боломжийг биднийг угтана.

Гурав. Хятад, Монголын харилцааны хөгжилд тулгарч буй асуудлууд

Өдгөө Хятад, Монголын зүгээс хоёр талыг харилцааг эрчимтэй хөгжүүлэх хүсэлтэй, түүхэн бодит боломжууд нээгдэж байгаа ч Хятад, Монголын харилцааг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэвэл хөгжлийн буухианд сууж хурдны замаар урагшлах билээ.

Хятад талаас Монгол, Хятад хоёр улсын харилцаанд дараах шийдвэрлэвэл зохих асуудал байна гэж үзнэ. Үүнд,

1. Аюулгүй байдал, гадаад бодлого дахь геополитикийн нөлөө

Хятад, Орос бол Монгол Улсын хөршүүд бөгөөд хоёулаа Монголтой урт удаан түүхэн харилцаатай. Монгол Улс аюулгүй байдал, гадаад бодлогын түвшинд Хятад, Оросын эзлэх байр суурийг ямагт анхаарч ирсэн. Өөрөөр хэлбэл, Монгол Улс Хятад, Оросыг харилцан тэнцвэржүүлэх замаар аюулгүй байдлаа хангахад анхаарч иржээ. Нөгөөтэйгүүр, Монголын зүгээс Хятад, Оросын нөлөөг сулруулж, бүс нутгийн бүс тоглогчоор Хятад, Оросыг хязгаарлахыг оролдож ирсэн ба энэ нь хүйтэн дайн дууссаны дараа Монгол Улс «Гуравдагч хөрш»-ийн бодлого хэрэгжүүлэх чухал шалтгаан болсон юм. Үнэн хэрэгтээ Монгол Улсын голлох «Гуравдагч хөрш» болох АНУ, Япон, улсууд сүүлийн жилүүдэд Хятадыг илэрхий сөрж байгаа нь Хятад, Монголын харилцаанд сөрөг хүчин зүйл болж байна. Гэсэн ч эерэг талаас нь харвал сүүлийн жилүүдэд Монгол Улс “Гуравдагч хөрш”-ийн бодлогоо төдийлөн онцлохгүй болсон явдал юм.

Эдийн засгийн хамтын ажиллагаанд саад бэрхшээл тулгарсаар байна. Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд олон хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна. Нэгдүгээрт, эдийн засаг, худалдааны харилцааг өргөжүүлэхээс болгоомжилж байна. Өөрөөр хэлбэл, Хятад, Орос, Монголын эдийн засгийн коридороор дамжуулан худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд хятадын бараа бүтээгдэхүүн, их хэмжээний хятадын хөдөлмөрлөх хүч орж ирснээр үндэсний үйлдвэрлэл шахагдана гэж үзэж байна. Ялангуяа Оросын тал энэ асуудлаар санаа зовниж буй нь илэрхий байдаг. Хоёрдугаарт, байгаль экологи эмзэг орчин нөхцөлтэй, хоцрогдсон дэд бүтэцтэй зэрэг асуудлаар хязгаарлагдаж байдаг. Монголын харьцангуй хоцрогдсон дэд бүтэц, ялангуяа тээвэрлэх хүчин чадал тааруу байдаг нь хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд нөлөөлж байна. Төмөр замыг жишээ болгон авч үзэхэд техник, технологи хоцрогдсон, тээвэрлэх хүчин чадал хангалтгүй, хурд багатай, өргөн царигтай зэрэг асуудал нь Хятад-Монголын төмөр замын тээврийн өртгийг нэмэгдүүлж хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хязгаарлаж байдаг. Үүнээс гадна Хятадын аж ахуйн нэгжүүд Монголд хөрөнгө оруулж үйлдвэр байгуулах, уул уурхайн олборлолт хийх тохиолдолд шаардлагатай зам, ус, цахилгаан, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн асуудлаа өөрсдийн хөрөнгөөр шийдвэрлэх шаардлагатай болдог тул хөрөнгө оруулалтын өртгийг нэмэгдүүлж байдаг. Гуравдугаарт, дотоод улс төрийн нөлөө ихтэй байдаг. Хятадын аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтад Монгол Улсын дотоодын хөрөнгө оруулалтын орчин, ихэвчлэн институцийн түвшинд нөлөөлж байгаа бөгөөд бодлого, хууль эрх зүйн орчин тодорхойгүй тогтворгүй байдаг нь хөрөнгө оруулалтын эрсдэлийг нэмэгдүүлж байна.

“Хятадын аюулын онол”-ын нөлөө оршсоор байна. Хятадын улсын нийт хүч бэхжихийн хэрээр “Хятадын аюулын онол” газар авсаар байгаа нь Монголд ч нөлөөлдөг.

Сүүлийн үед Хятадын эсрэг хандлагууд идэвхжиж ялангуяа Хятадтай хийж буй худалдаа, Хятадын аж ахуйн нэгжүүд уул уурхайн салбарт их хэмжээгээр хөрөнгө оруулж буйд сэтгэл ханамжгүй байгааг илэрхийлэх болсон ч үүнийг ойрын хугацаанд залруулах боломжгүй юм. Түүнээс гадна Хятадын ард иргэд, ААН Монгол Улсад тийм ч нэр хүндтэй биш. Энэ нь зарим нэг иргэд, ААН-ийн сөрөг үйлдэлтэй холбоотой бөгөөд хоёр талын харилцаанд ч нөлөөлж ирсэн аж. Зарим олон улсын байгууллагын Монгол Улсад явуулсан судалгаанаас үзэхэд Монголын олон нийтийн Хятадад хандах хандлага доогуур буюу Орос, Америк, Японоос хол хоцорсон байна. Мөн түүнчлэн Хятад, Монголын түүх, шашны улбаатай эмзэг асуудлууд оршдог ба нэг талын эрх ашгийг хөндсөн улс төрийн шинжтэй үйл явдал болмогц хоёр талын харилцаанд ноцтой нөлөөлж байдаг.

Дөрөв. Хятад, Монгол хоёр улсын хөгжлийн нийтлэг арга замыг эрэлхийлэх нь

Сүүлийн жилүүдэд Хятад, Монголын харилцаа, хамтын ажиллагаа нь хөрш орнуудын харилцааны загвар болж, түүхэн дэх хамгийн сайн үедээ байгаа бөгөөд цаашид Хятад, Монголын харилцааг хөгжүүлэх асар их боломж, орон зай бий. Цаашид илүү их хүчин чармайлт гаргаж геополитикийн хүлээсийг даван туулж, хамтын ажиллагааны хөгжлийн нийтлэг арга замаа тодорхойлох ёстой.

1.Улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлж, бүс нутгийн энх тайвныг хамгаалах нь

Бүс нутгийн энх тайван тогтвортой орчин нь Хятад, Монголын харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх урьдач нөхцөл юм. Тиймээс хоёр тал улс төрийн харилцан итгэлцлээ бэхжүүлж, бүс нутгийн энх тайвныг хамгаалахад хамтран ажиллах хэрэгтэй юм. Нэгдүгээрт, хоёр талын харилцан итгэлцлийг бэхжүүлж, харилцан хоёр талын аюулгүй байдлын гадаад орчин дахь эерэг хүчин зүйл болох ёстой. Хятад, Монгол хоёр орны харилцааг «энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим»-ын үндсэн дээр хөгжүүлж байна. Урт хугацааны түүхэн үйл явцад, Хятад, Монголын харилцааг хөгжүүлэхэд харилцан хүндэтгэсэн, эрх тэгш, харилцан ашигтай байхын ач холбогдлыг гүнзгий ухамсарлав. Тиймээс шинэ эринд бие биенийхээ аюулгүй байдлын асуудалд харилцан хүндэтгэлтэй хандахын ач холбогдлыг ухамсарлах, аюулгүй байдлын ашиг сонирхолд харш зүйл хийхгүй байх, өндөр түвшний стратегийн харилцан ойлголцлыг баталгаажуулах нь чухал юм. Хоёрдугаарт, бүс нутгийн халуун асуудлаар хамтын ажиллагаагаа бэхжүүлэх хэрэгтэй. АНУ-ын шинэ засаг захиргаа нь Солонгосын хойгийн асуудалд шинэ нөхцөл байдал үүсгэж, цар тахал бүс нутгийн улс орнуудад шинэ сорилт бий болгов. Хятад, Монголын улс төрийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хамгаалах нийтлэг ашиг сонирхол улам бүр нэмэгдэж байна. Солонгосын хойгийн асуудлын эргэн тойронд Америк, Умард Солонгосын зөрчил намжаагүй хэвээр Умард Солонгосын аюулгүй байдлын баталгаа ба цөмийн зэвсэггүй болох зэрэг асуудлыг шийдвэрлэхэд хугацаа шаардагдана. Хэдийгээр Америк, Умард Солонгос асуудлын гол дүр боловч хоёр талын ноцтой үл итгэлцлийг харгалзан үзэхэд бүс нутгийн бусад улсад асуудлыг шийдвэрлэхэд илүү үүрэг гүйцэтгэх боломжтой. Солонгосын хойгийн тогтвортой байдал нь бүс нутгийн үндэсний ашиг сонирхолтой нягт холбоотой бөгөөд талууд энх тайвны механизмыг байгуулах сонирхолтой байна. Монгол Улс хойгт яриа хэлэлцээний уур амьсгал оруулахад ихээхэн хүчин чармайлт гаргаж байна. Сүүлийн жилүүдэд болсон “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын хурал

бол маш сайн жишээ юм. Монгол Улс өнгөрсөн хугацаанд хойгийн харилцан ярианы уур амьсгалыг хадгалахад тодорхой үүрэг гүйцэтгэхийг хичээж ирсэн. Ирээдүйд Хятад, Монгол хойгийн энх тайван, тогтвортой байдлыг хамгаалах талаар ойлголцол, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, Зүүн Хойд Азид энх тайвны механизм байгуулахад хамтран хувь нэмрээ оруулах боломжтой.

2. Хамтын ажиллагаагаар үндэсний хөгжлийг дэмжих боломжтой

Хятад, Монголын хооронд үндэсний хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах өргөн боломжууд байсаар байна. Нэгдүгээрт, стратегийн уялдааг боловсруулж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх замын зургаа боловсруулах шаардлагатай байна. Хятад, Монголын төрийн тэргүүн нар «Бүс ба зам» санаачилга, «Хөгжлийн зам» төлөвлөгөөг уялдуулахаа удаа дараа нотолж Хятад, Монгол, Орос улсын тэргүүн нар 2016 онд “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор төлөвлөгөө”-г баталж коридорын бүтээн байгуулалтыг албан ёсоор эхлүүлэв. Сүүлийн жилүүдэд холбогдох төлөвлөгөө, бүтээн байгуулалт, ялангуяа “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ын худалдааг хөнгөвчлөх процесст багагүй ахиц гарч байна. Хятадын холбогдох мужууд болох Хармөрөн, Ляонин, Жилинь, Шиньжаан, Өвөрмонгол болон бусад муж холбогдох төлөвлөгөө гаргаж идэвхтэй оролцоотой байна.

Ирээдүйд Хятад, Монгол Улс давуу талаа харилцан нөхөж, “Бүс ба зам” санаачилга ба Монгол Улсын «Хөгжлийн зам» төлөвлөгөөг уялдуулж, худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлснээр хоёр орны ард түмэн үр шимийг нь хүртэх юм. Түүнээс гадна, хоёр тал хамтран бүс нутгийн хамтын ажиллагааны платформыг ашиглаж болно. Тухайбал, 2019 онд Хятадын Чэнду хотод болсон Хятад, Япон, Өмнөд Солонгосын удирдагчдын уулзалтаар “Хятад, Япон, Өмнөд Солонгосын хамтын ажиллагааны 10 жилийн төлөв” хэмээх тайлан илтгэл гаргасан. Мөн түүнчлэн, «Хятад, Япон-БНСУ + Х» форматаар хамтран ажиллах санаачилга гаргаж бүс нутгийн бусад оролцогчийг татан оролцуулахаар ажиллаж байна. Тус хурлаар «Хятад, Япон-БНСУ + Х» форматын хүрээнд хамтын ажиллагааны зарим төлөвлөгөө тухайлбал, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Монгол Улс хамтран элсэн шуурганаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиглэлээр ажиллах төлөвлөгөөг баталсан.

Хоёрдугаарт, дэд бүтцийн бүтээн байгуулалт дахь хамтын ажиллагааг бэхжүүлж, харилцан холбогдох шаардлагатай. Учир нь эдийн засгийн хамтын ажиллагаанд зам тээвэр нэн чухал байдаг. Хятад, Монголын зам тээврийн харилцааны өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалан хоёр тал хурдны зам, агаарын тээвэр ялангуяа төмөр замын чиглэлээр хамтын ажиллагаагаа бэхжүүлэх шаардлагатай. Хятадын тал туслахад бэлэн байгаа боловч хамтын ажиллагаа нь хоёр талын, ялангуяа Монголын талын хэрэгцээ шаардлагад үндэслэх юм. Өнгөрсөн хугацаанд Хятадын аж ахуйн нэгжүүдийн Монгол Улс дахь хөрөнгө оруулалтаас үүдэлтэй Монголын олон нийтийн санаа бодлыг харгалзан Монголын тал санаачлагаа гарган хоёр тал зөвлөлдөн шийдвэрлэх боломжтой.

Гуравдугаарт, боловсон хүчний солилцоо, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг дэмжих хэрэгтэй. Өнөөгийн нөхцөл байдлаас харахад энэ чиглэлээр хамтран ажиллах боломж маш их байна. Хоёр тал харилцан тохиролцсоны дагуу хамтын ажиллагааны хүрээг тодорхойлон, тогтвортой механизмыг бүрдүүлж, хоёр орны боловсон

хүчний солилцоо, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааг үе шаттайгаар хөгжүүлэх боломжтой.

Дөрөвдүгээрт, эрдэм шинжилгээ, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай. Хятад, Монголын улс төрийн харилцаа харьцангуй өндөр түвшинд хүрсэн боловч улс төрийн түвшний ойлголцол нийгэм, олон нийтийн түвшинд хүрээгүй байна. Тиймээс эрдэм шинжилгээний болон хүмүүнлэгийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх хоёр талын иргэдийн харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх боломжтой юм.

3.Тогтвортой хөгжилд байгаль орчныг хамгаалах хамтын ажиллагаа нэн чухал

Монгол орны экологийн орчин харьцангуй эмзэг байдаг. Сүүлийн жилүүдэд дэлхийн дулаарал, цөлжилт зэрэг байгалийн хүчин зүйл, бэлчээрийн даац хэтрэх, уул уурхайн олборлолт хийх зэрэг хүний хүчин зүйлээс шалтгаалан Монголын тэгш өндөрлөгийн экологийн орчин алдагдаж байна. Энэ нь Зүүн Хойд Азийн орнуудад ямар нэг байдлаар нөлөөлдөг. Одоогийн байдлаар Хятад, Монголын Засгийн газар байгаль орчныг хамгаалах ажлыг эрчимжүүлж, холбогдох хуулиудыг шинэчлэн боловсруулж, цөөнгүй бодлого төлөвлөгөө боловсруулсан. Хятадын зүгээс Монголтой холбогдсон хөрш орны хувьд өөрийн орны байгаль хамгаалалд анхаарахын зэрэгцээ Монгол Улсын байгаль экологи, ялангуяа ашигт малтмалын нөөц нээн ашиглах, тээвэрлэх чиглэлээр баримтлах Монгол Улсын баримтлах бодлого, хууль дүрмийг хүндэтгэн үздэг.

Хятадын Коммунист намын XVIII их хурлаас хойш Хятад улс экологийн соёл бий болгоход ихээхэн ач холбогдол өгч, шинэ санаачилга, стратеги дэвшүүлсэн. Бид экологийн соёлыг бий болгохын тулд тогтолцооны механизмд анхаарлаа хандуулсан. Тухайлбал, 2018 онд байгаль орчны яамыг байгуулж, экологи, хот, хөдөөгийн бохирдлыг бууруулах менежмент боловсруулах, хяналт тавих, хууль сахиулах хариуцлага оногдуулах нэгдсэн систем бүрдүүлсэн. Мөн байгалийн нөөц баялгийн яам байгуулж улсын газрын хэрэглээг хянах, экологийн нөхөн сэргээлт хийх асуудлыг хариуцуулж холбогдох хууль тогтоомж, журмын хэрэгжилтийг сурталчлах зорилгоор эко орчныг хамгаалах байцаагч ажиллуулав.

Сүүлийн жилүүдэд Хятад улс экологийн соёл бий болгох чиглэлээр багагүй амжилтад хүрч, туршлага хуримтлуулжээ. Хөрш зэргэлдээ хөгжиж буй хоёр орны хувьд Хятад, Монгол хоёр улс тогтвортой хөгжлийг хангахад нэгдмэл зорилго тавин ажиллаж, хамтын ажиллагааг бэхжүүлэх бүрэн боломжтой ажээ.

